

VOO ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУГАЦААТАЙ БАГЦЫН ГЭРЭЭ

/Байгууллага/



24 04 08
20.. оны сарын

№ 503 029 23

Улаанбаатар хот

Нэг талаас: Регистрийн 5334977 дугаартай, улсын бүртгэлийн 9011214001 тоот гэрчилгээтэй Монгол Улсын хуулийн этгээд болох Мобинет ХХК /цаашид "Нийлүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж Харилцагч хариуцсан менежер\ Борлуулалтын инженер Э. Ариунтүвшин
Нөгөө талаас: Регистрийн 3744574 дугаартай, улсын бүртгэлийн 1370002040 тоот гэрчилгээтэй Монгол Улсын хуулийн этгээд болох Сэлэнгэ аймгийн Ерөнхий Сөлийн Төв /цаашид "Хэрэглэгч" гэх/, түүнийг төлөөлж Р. Болорбаяр нар /цаашид хамтад нь Талууд гэх/ дараах нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр Үйлчилгээ үзүүлэгч нь VOO үйлчилгээ үзүүлэх, Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбоотой харилцаа болон Талуудын эрх, үүрэг тэдгээртэй холбоотойгоор үүсэх бусад харилцааг зохицуулна.
- 1.2 Гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцаа нь Үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн хүчин төгөлдөр үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдана.
- 1.3 Хэрэглэгчтэй байгуулсан гэрээ, хавсралт болон бусад баримт бичгүүд нь талуудын хоорондох бүхий л тохиролцоог илэрхийлнэ.
- 1.4 Гэрээний хавсралт 1, 2 нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 1.5 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1 Бүртгэлийн хураамж гэж үйлчилгээ идэвхжүүлсэн төлбөрийг хэлнэ.
- 2.2 Үйлчилгээний нөхцөл гэж интернэт орчинд гар утас, таблет, компьютер, телевиз зэрэг ухаалаг төхөөрөмжүүд дээр гадаад, дотоодын кино, контент, телевизийн сувгуудыг үзэх боломжийг олгож буй "VOO" үйлчилгээг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 2.3 Сарын хураамж гэж хэрэглэгчийн сонгосон багцын сарын хураамж ба бусад нэмэлт үйлчилгээний сарын хураамжуудаас бүрдэх сар бүр тогтмол төлөх төлбөрийг хэлнэ.
- 2.4 Багц солих гэдэг нь VOO үйлчилгээний багцын төрлөө өөрчлөхийг хэлнэ.
- 2.5 Хадгалах үйлчилгээ гэж хэрэглэгчийн хүсэлтээр VOO үйлчилгээний эрхийг 12 сар хүртлэх хугацаанд хадгалахыг хэлэх ба хугацаатай нөхцөлөөр үйлчилгээ авсан хэрэглэгч өргөдлийн маягт дээр заасан хугацаагаар хадгалах боломжгүй.
- 2.6 Хэрэглэгчийн хэрэглээ гэж Хэрэглэгчийн үзсэн гадаад, дотоодын кино, контент, телевизийн сувгуудыг хэлэх ба тэдгээрт суурилсан нэмэлт үйлчилгээ болон бусад бүх төрлийн хэрэглээг хэлнэ.

- 2.7 Багцад дагалдах эрх нь хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын хурамжид дагалдах хэрэглээний эрх юм.
- 2.8 Төлбөртэй сувгийн үйлчилгээ хэрэглэгч өөрийн ашиглаж байгаа багцын төлбөр дээр багц сувгуудыг нэмэлт төлбөр төлж үзэх боломжтой үйлчилгээг олгоно.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1 Энэхүү гэрээ нь 20.. оны сарынны өдрөөс 20... оны сарын ны өдрийг хүртэл 2 /хоёр/ жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 3.2 Хугацаатай гэрээ нь Хэрэглэгч VOO төхөөрөмжийг энэхүү гэрээнд заасан нөхцөлийн дагуу авч, сонгосон VOO үйлчилгээний багцын өгөгдлийн маягт дээр заасан хугацаанд тогтмол ашиглахыг ойлгоно.

ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Гэрээнд гарын үсэг зурснаар Хэрэглэгч гэрээний нөхцөлийг бүхэлд нь уншиж ойлгосон, бүх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн, өөрийн хувийн мэдээллийг үнэн зөв өгсөн болохыг баталгаажуулж байгаа болно.
- 4.2 Хэрэглэгч нь гэрээ байгуулахаас өмнө үйлчилгээ ашиглахад шаардлагатай интернет орчинг бүрдүүлж бэлэн болгосон байна.
- 4.3 Хэрэглэгчийн интернет болон түүнд ашиглаж байгаа төхөөрөмжөөс шалтгаалан гарсан аливаа гэмтэл саатал болон өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас гарсан гэмтэл хоцрогдлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 4.4 Хэрэглэгч VOO үйлчилгээг зөвхөн байгууллагын зориулалтаар ашиглах эрхтэй.
- 4.5 Нэвтрэх нэр, нууц үгээ бусдад дамжуулан болон алдсанаас болж үүсэх аливаа асуудлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 4.6 Хэрэглэгч VOO үйлчилгээнд бүртгэлтэй үүрэн холбооны дугаараа бусдад шилжүүлэх тохиолдолд үйлчилгээний бүртгэлээс хасаж дахин өөр дугаар бүртгүүлэх үүрэгтэй.
- 4.7 VOO үйлчилгээгээр дамжуулан үзэж буй кино, контент, телевизийн нэвтрүүлгүүд, үзвэрүүд, тоглолтын бичлэг болон бусад оюуны өмчийн материалуудыг холбогдох эрх эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, түгээх арилжааны зориогоор ашиглах, эдгээртэй адилтгах бусад хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 4.8 Хэрэглэгч 3.1-т заасан хугацаанаас өмнө үйлчилгээг цуцалсан тохиолдолд төхөөрөмжийн үндсэн төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлөх үүрэгтэй.
- 4.9 Хэрэглэгч гэрээг цуцлах тохиолдолд албан тоотоор хүсэлт гарган үйлчилгээний салбарт хандана.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа техникийн гэмтэл, гэнэтийн саатал гарсан тохиолдолд хурдан шуурхай засварлах, үйлчилгээг техникийн боломж хүчин чадлын хүрээнд стандартын дагуу чанартай үзүүлэх үүрэгтэй.
- 5.2 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний нөхцөл, гэрээ, бусад нөхцөл, гэрээ, бусад нөхцөл, үнэ тарифыг нэг

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцааг хүлээлгэх болно.

44117146



талын санаачлаагаар өөрчлөх эрхтэй бөгөөд өөрчлөлт орсон тухай хэрэглэгчид ажлын 5 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

- 5.3 Өөрчлөлт орсноос хойш хэрэглэгч үйлчилгээг хэрэглэсээр байгаа бол өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 5.4 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэглэгчийн үйлчилгээний эрхийг нээх үүрэгтэй.
- 5.5 Үйлчилгээ үзүүлэгч нь веб болон аппликейшний бүтэц, видео сан, телевизийн сувгийг өөрчлөх эрхтэй.
- 5.6 Хэрэглэгч байгууллагын хэрэгцээнээс бусад зорилгоор үйлчилгээг ашигласан тохиолдолд үйлчилгээг зогсоож, гэрээг цуцлах эрхтэй.
- 5.7 Оюуны өмчийн эрхийг зөрчсөн сувгийг хаах, нэвтрүүлэхгүй байх эрхтэй.
- 5.8 Үйлчилгээ үзүүлэгч нь VOO үйлчилгээгээр дамжуулан үйлчилгээний болон сурталчилгааны мэдээлэл хүргэх эрхтэй.
- 5.9 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөвхөн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран хэрэглэгчийн мэдээллийг ашиглах эрхтэй.
- 5.10 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаандаа төлөөгүй болон гэнэтийн гэмтэл саатлын улмаас үйлчилгээ доголдсон тохиолдолд үйлчилгээг түр хаах эрхтэй.
- 5.11 Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээнд тусгагдаагүй боловч хуулиар олгогдсон бусад эрхээ хэрэгжүүлэх эрхтэй байна.

ЗУРГАА. ТӨЛБӨР ТООЦОО

6.1 Төлбөрийн нэхэмжлэх

- 6.1.1 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөрийг сарын 01-нээс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 05-ны дотор Хэрэглэгчээс нэхэмжилнэ.
- 6.1.2 Төлбөрийн нэхэмжлэх нь тухайн сарын багцын хураамж, нэмэлт үйлчилгээний нийлбэр дүнгээс зохих хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүн, өмнөх сарын төлбөрийн үлдэгдэл, НӨАТ зэргээс бүрдэнэ.
- 6.1.3 Хэрэглэгч нь 6.1.1-д заасан төлбөрийн нэхэмжилсэн сарын 20-ны дотор үлдэгдэлгүй, бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 6.1.4 Хугацаатай гэрээ байгуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр VOO төхөөрөмж авсан Хэрэглэгчээс дараах тохиолдолд төхөөрөмжийн үндсэн үнийн бүтэн нэхэмжилнэ. Үүнд:
- 6.1.4.1 Хэрэглэгч төлбөрөө төлөөгүйн улмаас үйлчилгээ хаагдсан өдрөөс хойш 1 сар өнгөрсөн бол;
- 6.1.4.2 Хугацаанаас өмнө гэрээгээ цуцалсан бол;
- 6.1.5 Хэрэглэгч VOO үйлчилгээний төлбөрөө төлөөгүйн улмаас үйлчилгээ хаагдсан бол үйлчилгээний төлбөрөө бүрэн барагдуулсан тохиолдолд үйлчилгээний эрх нь нээгдэнэ.
- 6.1.6 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрөө үйлчилгээ үзүүлэгчийн заасан банкны дансаар, www.voo.mn,

VOO аппликейшн болон бусад боло
төлнө.

- 6.1.7 Дараа төлбөрт VOO үйлчилгээний хэ
Monpay буцаалт олгохгүй.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭЗНИЙ ЗӨВШӨӨРӨЛ

7.1 Талууд энэхүү гэрээг байгуулах болон гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шууд болон шууд бусаар олж мэдсэн эсхүл цуглуулсан, боловсруулсан, ашигласан, солилцсон хүний хувийн мэдээлэл, хүний болон байгууллагын нууцад хамааралтай (техник, санхүү, бизнесийн нууц гэм мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад аман, бичгэн болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

7.2 Талууд энэхүү гэрээг байгуулах болон гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хоорондоо дамжуулах бол мэдээллийн эзнээс нь зөвшөөрөл авах, холбогдох хуулийн нийцлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд ийнхүү хангаагүйгээс үүсэх аливаа эрсдэлийг өөрөө бүрэн хариуцна.

7.3 Энэхүү гэрээний 7.1 -7.2-д заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцна.

7.4 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн үндсэн мэдээлэл болон үйлчилгээний гэрээ, хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг өөрийн нууцад хамааруулан хадгалах бөгөөд дараах тохиолдлуудад гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй. Үүнд:

- 7.4.1 Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шаардсанаар;
- 7.4.2 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүссэн авлагыг барагдуулах зорилгоор;

НАЙМ. ХЭРЭГЛЭГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН НУУЦ ХАДГАЛАХ

- 8.1 Хэрэглэгч нь Үйлчилгээ үзүүлэгчид мэдээллээ үнэн зөв өгөх үүрэгтэй бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 хоногт багтаан Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэнэ.
- 8.2 Хэрэглэгч нь өөрийн гар утас, тоног төхөөрөмжийн тохиргоо, үйлчилгээ идэвхжүүлэхтэй холбоотой Үйлчилгээ үзүүлэгчээс олгосон болон өөрийн үүсгэсэн нэвтрэх нэр, нууц үг, кодыг хадгалж, хамгаалах үүрэгтэй.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1 Талууд шууд бус хохирлыг нэхэмжлэхгүй.
- 9.2 Хэрэглэгч гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй байдлаар Үйлчилгээ үзүүлэгчээс олгосон болон өөрийн үүсгэсэн нэвтрэх нэр, нууц үг, кодыг хадгалж, хамгаалах үүргээ хэрэгжүүлээгүйгээс бусад байдлаар ашигласнаас үүсэн гарах аливаа үр дагавар, хохирол, зардлыг өөрөө бүрэн хариуцна.
- 9.3 Хэрэглэгч болон гуравдагч этгээдийн үйлдэл, эс үйлдэл, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс учирсан хохирлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй.
- 9.4 Хугацаатай гэрээ байгуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр VOO төхөөрөмж авсан хэрэглэгч өргөдлийн маягт дээр заасан хугацаанаас өмнө үйлчилгээ цуцлах тохиолдолд 6.1.4-д заасан төлбөрийг төлж барагдуулна.

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувиулж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

- 10.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй, нөхцөл байдлын улмаас хохирол учирвал, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан ажил хаялт, эрчим хүчний тасалдал, сүлжээний хэт ачаалал, гуравдагч этгээдийн буруугаас сүлжээ болон үйлчилгээ тасалдах, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, техникийн шинжтэй томоохон гэмтэл, осол, аваар, хорлон сүйтгэх ажиллагаа, эдийн засгийн болон зах зээлийн хүнд нөхцөл байдал, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг тооцно.
- 10.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас үүдсэн нөхцөл байдал 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд гэрээг цуцлагдсанд тооцно.

АРВАН НЭГ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 11.1 Хэрэглэгчийн хүсэлтээр гэрээ цуцлах
- 11.1.1 Хэрэглэгч гэрээ цуцлах тухай саналыг үйлчилгээ үзүүлэгчид ажлын 1 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.
- 11.1.2 Хугацаатай гэрээ байгуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр VOO төхөөрөмж авсан хэрэглэгч гэрээ цуцлах тохиолдолд өргөдлийн маягт дээр заасан төхөөрөмжийн үнийг бүтэн төлж барагдуулна.
- 11.1.3 Хэрэглэгч гэрээ цуцлах өдрийг хүртэлх ашигласан үйлчилгээний төлөгдөөгүй бүх төлбөрийг төлж барагдуулна.
- 11.1.4 Гэрээ цуцлах сарын багцын бүтэн нэхэмжилнэ.

11.2 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гэрээ цуцлах

- 11.2.1 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд дангаар цуцлах эрхтэй байна. Үүнд:
- 11.2.1.1 Төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийн сар хадгалан 4 дэх сард;
- 11.2.1.2 Хадгалах үйлчилгээ авсан хэрэглэгч 6.1.3-д заасан хугацаанд төлбөрийн үлдэгдлээ барагдуулаагүй бол үйлчилгээ автоматаар нээгдэх сард;
- 11.2.1.3 Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол;
- 11.2.1.4 Хэрэглэгч өргөдлийн маягын мэдээллийг худал мэдүүлсэн бол;
- 11.2.1.5 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийн маргаантай бол;
- 11.2.1.6 Захиалга өгснөөс хойш 21 хоногийн хугацаанд хэрэглэгчээс шалтгаалан холболт хийгдээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран холболтын захиалгыг цуцлах эрхтэй.

АРВАН ХОЁР. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 12.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тийнхүү шийдвэрлэж чадахгүй тохиолдолд МУ-ын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
- 12.2 Гэрээг хоёр хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

Нийлүүлэгчийн төлөөлж:

Харилцагч хариуцсан менежер/Борлуулалтын инженер

Гарын үсэг:

Монет
/Тамга/ СЭЛЭНГЭ САЛБАР
ATA6124 5334977

Хэрэглэгчийн төлөөлж:

Албан тушаал: *СОЁЛЫН ТӨВНИЙН ДАРГА*

Гарын үсэг:

Ф.Болормаа
/Тамга/ ОВОГТОЙ
ЕРСӨ СУМЫН

ХОЛБОО БАРИХ

Нийлүүлэгчийн мэдээлэл

Нийлүүлэгчийн албан ёсны хаяг:	МПП цогцолбор, Юнескогийн гудамж -28, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Нийлүүлэгчийн Лавлах утас, и-мэйл, вэб:	Утас: 2288, 75952288 Бусад сүлжээнээс, customercare@mobinet.mn , www.mobinet.mn ,
Харилцагч Хариуцсан Менежерийн нэр, утас, и-мэйл:	

Хэрэглэгчийн мэдээлэл

Хэрэглэгчийн албан ёсны хаяг:	<i>ОХИТЭЭ ГЭВЭ СУМЫН СОЁЛЫН ТӨВ</i>
Тооцоо хийх ажилтны нэр, утас, и-мэйл, албан тушаал:	<i>Ф.Болормаа, 99929570, bolormaa9570@gmail.com</i>
Төлбөрийн нэхэмжлэх хүлээн авах и-мэйл:	<i>eruu50yx19619@gmail.com</i>

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул оор бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

(4911 7176)
 5030 2928
 VOO - тоот Гэрээний Хавсралт 1



Үйлчилгээний төлбөр		
№	Тайлбар	Үндсэн үнэ (₮)
1	VOO төхөөрөмж бэлнээр борлуулах үндсэн үнэ	169'000₮
2	VOO төхөөрөмж суурилуулалтын хураамж	10'000₮

Багцын нэр	Багцын сарын хураамж	Нэг агшинд зэрэг үзэх төхөөрөмжийн тоо	Багцад дагалдах эрх			
			Дотоодын суваг	Гадаад суваг	Төлбөргүй контент үзэх эрх	PSN спорт багц
Standard HD	9'900₮*	2 (ТВ + Утас**)	Дагалдана			7'900₮
Premium HD	19'900₮*		Дагалдана			3'000₮

* Өргөн нэвтрүүлгийн ТВ үйлчилгээний хөлс 2'500₮ (НӨАТ-тай) нэмж тооцогдоно.

**Утас гэдэгт – Гар утас, Таблет, вэбээр үзэх эрх хамаарна.

Жич: Дээрх бүх үнэд НӨАТ 10% орсон болно.

Дараа төлбөрт VOO үйлчилгээний нэмэлт нөхцөл			
Нэмэлт үйлчилгээ	Нөхцөл	Идэвхижүүлэх суваг	Үнэ (₮)
***PSN спорт сувгийн багц	Төлбөртэй сувгийг хэрэглэгч сард 1 удаа идэвхижүүлэх болон цуцлах боломжтой. Цуцлах хүртэл үйлчилгээг сар бүр автоматаар сунган	VOO төхөөрөмж VOO аппликейшн	7'900₮
Нөхөж ухраах	96 цаг доторх контентийг нөхөж, 2 цаг доторх контентыг ухраах боломжтой.		3'000₮

***SPN спорт сувгуудыг Бар, Паб, ресторан болон лоунж зэрэг олон хүмүүст зэрэг спорт сувгуудыг үзүүлдэг үйлчилгээний байгууллагуудад борлуулах боломжгүй.

Жич: Дээрх бүх үнэд НӨАТ 10% орсон болно.

VOO - тоот гэрээний Хавсралт 2

№	Нэвтрэх нэр	Төхөөрөмжийн сериал	Багцын төрөл	Гэрээний хугацаа
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				

Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу харилцаага хүлээлгэх болно.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ 02

Сэлэнгэ аймаг Ерөө сум хот
(аймаг, сум, дүүрэг)

2025 оны 09 дүгээр
сарын 26 -ны өдөр

Нэг талаас: Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Тавин 1-р багт байрлах Соёлын төв
(захиалагч байгууллага, иргэний нэр, хаяг)

(цаашид "Захиалагч гэх") түүнийг төлөөлж Соёлын төвийн дарга **Фельчер** овогтой
Болормаа (төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

Нөгөө талаас: **Студын дууны найруулагч**

(ажил гүйцэтгэгч байгууллага, иргэний нэр, хаяг)

(цаашид "Ажил гүйцэтгэгч гэх") түүнийг төлөөлөн **Энэбиш** овогтой **Оюунсайхан**
(төлөөлсөн хүний нэр, албан тушаал)

нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь гэрээг
харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу **Ерөө нутгийн болон Ахмадын тухай 3 дууны понограмм буюу Аранжировка-ыг** хугацаанд нь гүйцэтгэж захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлнэ.

1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.

2. Гэрээний хугацаа

2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.

2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: 10 хоног

2.3. Ажил эхлэх хугацаа: 2025 оны 09 дугаар сарын 26-ны өдрөөс

2.4. Ажил дуусах хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийг дуустал

3. Ажлын хөлс

3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс **1,578,000** төгрөг байна.

3.2. Гүйцэтгэгчийн ажлын хөлс **1,578,000** /Нэг сая, таван зуун далан найман мянга/ төгрөгийг гэрээ хийсний дараа нэхэмжлэлийн дагуу **ХААН** банкны **5678033110** тоот дансанд шилжүүлж төлж дуусгана.

4. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Ажил гүйцэтгэхэд шаардагдах "**Дууны нот, үг, аялгуу**"-ийг ажил гүйцэтгэгчийн эзэмшилд шилжүүлнэ. (материалын нэр төрөл, хэмжээг бичнэ)

4.2. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.

4.3. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 1 сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

4.4. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
5.2. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
5.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж, үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
5.4. Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.
5.5. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

6. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
6.2. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

7. Бусад заалт

- 8.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)
8.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
8.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

- 9.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

10. Нэмэлт нөхцөл

11. Талуудын хаяг

Захиалагч:

Хаяг: Сэлэнгэ аймаг Ерөө сум
Тавин 1 дүгээр баг
Соёлын төвийн дарга

Утас: 99929570

Гарын үсэг:  Ф. Болормаа

(Тамга, тэмдэг)

Гүйцэтгэгч:

Хаяг: Сэлэнгэ, Шаамар, 3-р баг,
Дулаанхаан бумцэнд гудамж, 1-30 тоот

Утас: 99894570

Гарын үсэг: 

(Тамга, тэмдэг)

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ 05

Сэлэнгэ аймаг Ерөө сум хот
(аймаг, сум, дүүрэг)

2025 оны 09 дүгээр
сарын 29-ны өдөр

Нэг талаас: Захиалагч Ерөө сумын Соёлын төвийг төлөөлж Соёлын төвийн дарга Ф.Болормаа,

Нөгөө талаас: Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар багийн иргэн **Батбаяр** овогтой **Нямдорж** нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь гэрээг харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг заалт

1.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу **Улс, Аймгийн чанартай цэнгээнт бүжгийн тэмцээнд оролцох хамтлагийн хүүхдүүдэд Латин Америк болон Европын цэнгээнт бүжиг зааж** хугацаанд нь гүйцэтгэж захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлнэ.

1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, гэрээгээр тохиролцсоны дагуу төлбөрийг хугацаанд төлнө.

2. Гэрээний хугацаа

2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.

2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: **14 хоног**

2.3. Ажил эхлэх хугацаа: **2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс**

2.4. Ажил дуусах хугацаа: **2025 оны 10 дүгээр сарын 12-ны өдөр хүртэл**

3. Ажлын хөлс

3.1. Гэрээгээр гүйцэтгэх 2 бүжгийн ажлын нийт хөлс **2,000,000** төгрөг байна.(1 бүжгийн төлбөр 1,000,000 төгрөг, нийт 2 бүжиг заана.)

3.2. Ажил гүйцэтгэж эхлэх үед хөлсийг төлнө. (Хэрэв ажлыг тодорхой хэсгээр, үе шаттай гүйцэтгэхээр тохиролцсон бол тухайн хэсгийн ажлын үр дүнгээр хөлсийг хэсэгчлэн төлөхөөр тохиролцож болно.)

4. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Ажил гүйцэтгэхэд шаардагдах **Байр, хөгжим техник хэрэгсэл** -ийг
(материалын нэр төрөл, хэмжээг бичнэ)

ажил гүйцэтгэгчийн эзэмшилд шилжүүлнэ.

4.2. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.

4.3. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 1 сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

4.4. Гүйцэтгэсэн ажлын төлбөрийг саадгүй төлөх үүрэгтэй.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
5.2. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
5.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж, үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
5.4. Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.
5.5. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

6. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд _____ хувийн алданги төлнө.
6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
6.3. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

7. Бусад заалт

- 7.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)
7.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам


- 8.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
8.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

09. Талуудын хаяг

Захиалагч:

Хаяг: Сэлэнгэ аймаг Ерөө сум
Тавин 1 дүгээр баг
Соёлын төвийн дарга
Утас: 99929570
Гарын үсэг:  Ф.Болормаа
(Тамга, тэмдэг) 

Гүйцэтгэгч:

Хаяг: Дархан-Уул аймаг Дархан сум
8 дугаар баг 11-6 тоот
Утас: 99658959
Гарын үсэг:  Б.Нямдорж
(Тамга, тэмдэг)



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 04 сарын 25 өдөр

№25/БНХ-02

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас 3744574 тоот регистрийн дугаартай, **“ЕРӨӨ СУМЫН СОЁЛЫН ТӨВ”** /цаашид “Захиалагч тал” гэх/ түүнийг төлөөлж дарга Ф.Болормаа нөгөө талаас **“АШИДБИЛГҮҮН ХӨРӨНГӨ ҮНЭЛГЭЭ” ХХК** /цаашид “Гүйцэтгэх тал” гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Ч.Жамъян /цаашид хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг удирдлага болгон дор дурьдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Үүнд: Ерөө сумын Соёлын төв байгууллагын газрын үнэлгээ тогтоох зорилготой хөдлөх болон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн үнэлгээг санхүүгийн тайлагналын зориулалтаар хийж гүйцэтгэн үнэлгээний тайлан гаргах.

НЭГ.НИЙТЛЭГ ЗААЛТ

- 1.1 Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгын дагуу үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тайланг хугацаанд нь үнэн зөв, бодит байдалд нийцсэн байдлаар чанарын өндөр түвшинд гүйцэтгэж Захиалагчид шилжүүлнэ.
- 1.2 Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг энэхүү гэрээгээр тохиролцсоны дагуу бүрэн төлж барагдуулна.

ХОЁР.ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Ажил гүйцэтгэх хугацааг Талууд харилцан тохиролцож дараах байдлаар тогтоосон бөгөөд гэрээнд заасан ажлыг заасан хугацаанд гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.1.1. Гэрээний эхлэх хугацаа: Үнэлгээний зүйл болох хөрөнгөд биет үзлэг бүрэн хийж дуусч, захиалагч тал захиалгатай холбоотой мэдээллийг бүрэн ирүүлсэнээс хойш ажлын 7 хоногт хийж гүйцэтгэнэ.

ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

- 3.1. Үнэлгээний ажлын хөлс нь **жишиг тарифын дагуу** байх бөгөөд энэ нь эцсийн дүн болно.
- 3.2. Энэхүү гэрээний 3.1 дэх хэсэгт заасан ажлын хөлсийг Захиалагч нь дараах хуваарийн дагуу Гүйцэтгэгч талд шилжүүлнэ. Үүнд:
 - 3.2.1. Үнэлгээний төлбөр болох ажлын хөлсийг энэхүү гэрээгээр гүйцэтгэсэн ажлын эцсийн үр дүнг Захиалагч талд хүлээлгэн өгснөөр Гүйцэтгэгчийн Хаан банк дахь 5112474730 тоот дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВ.ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч нь Гүйцэтгэгчид гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах Компаний гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, бусад шаардлагатай холбогдох бүх бичиг баримтыг ажил гүйцэтгэгчийн шаардлагаар гарган өгнө.

- 4.2. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авсны дараа ажлын гүйцэтгэл, түүний үр дүнтэй холбоотойгоор нэмэлт тайлбар, тодруулга шаардлагатай тохиолдолд хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхдээ дутуу, буруу хийсэн болох нь тогтоогдсон зэргээр аливаа доголдол илэрсэн тохиолдолд үнэ төлбөргүйгээр дахин гүйцэтгэхийг Захиалагчаас шаардах эрхтэй.
- 4.4. Захиалагч нь гэрээнд заасан төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 4.5. Захиалагч тал хөрөнгийн газар дээрх биет үзлэгийг хийхэд явах ажлын багийг Улаанбаатар хотоос авч газар дээрх үзлэгийн дууссаны дараа Улаанбаатар хотод хүргэн өгөх унаагаар хангана.

ТАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- 5.2. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалын зарцуулалтын талаар захиалагчид тайлагнаж, үлдэгдэл материалыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
- 5.3. Захиалагчийн өгсөн материал чанар, стандартын хувьд ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.
- 5.4. Захиалагч ажлын үр дүнг хугацаанд нь авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцож хөлс төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.
- 5.5. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлаас татгалзах эрхтэй.

ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 6.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэтийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас төлбөрөөс чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 6.2. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 6.3. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 6.4. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монгол Улсын шүүхээр эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 6.5. Талууд гэрээнд гарын үсэг зурж тамга дарснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

- 7.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжинд заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

НАЙМ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

- 8.1. Энэхүү талуудын гараар бичиж оруулсан өөрчлөлт нь энэ гэрээний хүчин төгөлдөр заалт хэвээр үлдэх ба талууд оруулсан өөрчлөлт дээр гарын үсгээ зурж тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Ашидбилгүүн хөрөнгө үнэлгээ” ХХК
/64091722/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р
хороо Нарны зам, ЦОМА оффис 3-304 тоот
Утас: 77377368, 99115672, 95020019

Гүйцэтгэх захирал:

Ч. Жамъян

Ч.Жамъян

Захиалагчийг төлөөлж:

“Ерөө сумын Соёлын төв” /3744574/

Хаяг: Сэлэнгэ аймаг Ерөө сумын 2-р баг
Буурагчин Гэрэлт гудамж 1-134 тоот

Утас: 99929570, 99676233

Нягтлан бодогч:



Б.Билэгмаа



"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК

АЖ АХУЙН НЭГЖИЙГ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

ЦЭХ-НИЙ ХЯНАЛТ, УДИРДЛАГА, АРИЛЖААНЫ АВТОМАТИЗУУЛАЛТЫН СИСТЕМ

Хэрэглэгчийн нэр:

Велон тов

Хэрэглэгчийн код:

5010 658

УХААЛАГ
ТООЛУУРЫ
СИСТЕМ

БОРЛУУЛАЛТ
СИСТЕМ
Дэд станц:

ХЭРЭГЛЭГЧИЙН
ЭНЛАЙН
СИСТЕМ

АТМ - 163

ДИССЕТЕРИ
УСЛАВТЫН
СИСТЕМ

НАЛТЫН
МЭҮРИН
СИСТЕМ

БЭРНИ
СИСТЕМ

ХАЛТЫН
СИСТЕМ

20 *16* он



ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

20²² оны 07 сарын 25-ны өдөр

Энэхүү гэрээг нэг талаас “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК (цаашид “Хангагч” гэх), түүнийг төлөөлж Ц.Орвоотар Салбар, ХҮТ-ийн Н.О.О албан тушаалтай, нөгөө талаас Монгол улсад бүртгэлтэй “Мелон ТВ” (цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж М.О.О албан тушаалтай Д.О.О нар (цаашид хамтад нь “Талууд”, талуудын аль нэгийг “Тал” гэх) дараах нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож 20²² оны 07 сарын 25-ний өдрөөс эхлэн 20²⁵ оны 07 сарын 25-ний өдрийг хүртэл хүчинтэй байхаар байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Хангагчтай “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ” байгуулах хэрэглэгч нь шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлтэй, цахилгаан эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй, хэрэглэгчдийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийлгэсэн байна.
- 1.2. Энэхүү гэрээг иргэн болон хуулийн этгээдийн эзэмшигчтэй байгуулна. Эзэмшигчийн өмнөөс нотариатаар баталгаажсан итгэмжлэгдсэн төлөөлөгч байгуулж болно.
- 1.3. Төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч нар адил эрх үүрэг хүлээнэ.
- 1.4. Энэхүү гэрээгээр нэг талаас Хангагч нь “Эрчим хүчний тухай хууль”-ийн дагуу Хэрэглэгчийг цахилгаан эрчим хүч (цаашид “ЦЭХ” гэх)-ээр хангах, нөгөө талаас Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх, энэхүү гэрээ болон дор дурьдсан хууль зүйн актуудыг дагаж мөрдөх үүргийг тус тус харилцан тохиролцож оруулав.
- 1.5. Энэхүү гэрээгээр шууд зохицуулагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын Иргэний тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Хэмжилзүйн тухай хууль, Зөрчилийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Аж ахуйн харилцааны дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актын заалтуудыг баримтлан зохицуулна.
- 1.6. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хангагч хэрэглэгч хоёр байгууллагын баталгаат гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж талуудад хадгалуулах ба хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 1.7. Хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 1.8. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 1. “Эрчим хүч” гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан болон шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг;
 2. “Эрчим хүчний эх үүсвэр” гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг;



ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

ХАНГАГЧ:

Хаяг: ДСЦТС ХК-ийн *Сүржаатар*

Салбар, ХҮТ-ийн байр

Бити аймаг

Ерөө сум, *2* баг

E-mail: ds_tugeeh@yahoo.com

Website: /www.dsedn.mn/

Website: /www.tsakhilgaan.mn/

Гэрээтанхимын утас: *70363900*

Борлуулалтын утас:

Диспетчерийн утас: *70363783*

Мессеж лавлагаа: 1400-15

Санал, гомдол, хүсэлт: 7037-4000

ХЭРЭГЛЭГЧ:

УБГ-ний хаяг: *Бити Ерөө*

Мавис

Үйл ажиллагаа явуулж буй газрыг хаяг:

Бити ашиг Ерөө сум

г

УБГ-ний № *137 000 2040*

Регистрийн дугаар *3744574*

E-mail: *bolormaa9540@gmail.com*

Website:

Утас: Захирал *99929540*

Утас: Ня-бо *99932163*

Утас: Цахилгаанчин *-*

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАНГАГЧ:

ДСЦТС ХК-ийн *Сүржаатар*

Салбар, ХҮТ-ийн дарга

Б. Сүржаатар

Гэрээ, танхимын ажилтан

О. Олигунов

Борлуулалтын ажилтан

Б. Багдур

Ня-бо

Н. Отгонтуяа

ХЭРЭГЛЭГЧ:

Болорм -ийн

албан тушаалтай

Болорм

-г төлөөлж

албан тушаалтай

/ /

Цахилгааны инженер, цахилгаанчин

/ /

Ня-бо

/ /



Хавсралт №1

ХЭРЭГЛЭГЧИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ

1. Трансформаторуудын нийлбэр чадал 250 кВА

2. Тоног төхөөрөмжийн нийлбэр чадал кВт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал / кВт/	Тоо ширхэг	Хоногт ажиллах цаг	Хоногийн хэрэглээ /кВт.ц/
1	Зуураг мотор	4 кВт	2 ш	24 ц	192 кВт
2	Тэрэг	0,1 кВт	24 ш	8 ц	19,2 кВт
3	Машингаас хөдмөл	0,5 кВт	1 ш	5 ц	2,5 кВт
4	Компьютер	0,5	3	8 ц	12 кВт
5	Караоке	1,1	2	5 ц	11 кВт
6	тайгун	0,5	12	5 ц	30 кВт
7					
8					
9					
10					

Хангагчийг төлөөлж:

..... МБ албан тушаалтай
..... Б.Б.Б. / Б.Б.Б. /

Хэрэглэгчийг төлөөлж:

..... Б.Б.Б. албан тушаалтай
..... Б.Б.Б. / Б.Б.Б. /

4316123426 3744574
ЕРӨӨ СУМЫН



Хавсралт №2

ТООЛУУР ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Тоолуурын № 6001934 Гүйдлийн тр марк

Тоолуурын марк OTS 3 Гүйдлийн тр баталгаат хугацаа

Баталгаат хугацаа 2026.2.15 Хүчдэлийн тр марк

Коефициент Гүйдлийн тр лац А....., В....., С.....

Хэлхээнд тавьсан тоолуурын мэдээлэл	Хэлхээнээс авсан тоолуурын мэдээлэл
Тоолуурын №.....	Тоолуурын №.....
Тоолуурын марк.....	Тоолуурын марк.....
Баталгаат хугацаа.....	Баталгаат хугацаа.....

Тоолуур сольсон шалтгаан:.....

Хэрэглэгчийн нэмэлт мэдээлэл:.....

Хангагчийг төлөөлж:

АББ албан тушаалтай
г / Багдуров /

Хэрэглэгчийг төлөөлж:

дара албан тушаалтай
В / Багдурмаа /





ДУЛААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

2025 оны 01 сарын 02 өдөр

№ 03/

Тавин

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэт талаас "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ /цаашид энэ гэрээний дулаанаар хангагч тал болох/, нөгөө талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Соёлын төв /цаашид энэ гэрээний дулаан хэрэглэгч тал болох/ нар харилцан тохиролцож дулаан үйлдвэрлэх, дулаанаар хангах, дулаан авах, хэрэглэх талаар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

1.2. Хангагч нь дулаан үйлдвэрлэх, түгээх ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангагдсан байх, хэрэглэгч нь халаалт дулаан хангамжаар найдвартай хангагдах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.3 Энэ гэрээ нь Эрчим хүчний тухай хууль, холбогдох дүрэм, журам болон Сумын Засаг даргын 2022 оны 09 сарын 30-ны өдрийн А/210 тоот захирамжийн хүрээнд байгуулагдаж тэдгээрийг удирдлага болгон зохицуулагдах бөгөөд талууд хууль, дүрэм, журмын хүрээнд энэ гэрээг мөрдөж эрх үүрэг хариуцлага хүлээж ажиллана.

Хоёр. Гэрээний нөхцөлүүд

2.1 Гэрээний хугацаа: Энэ гэрээ нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, 2025 оны 09 дүгээр сарын 15-аас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нийт 8 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

2.1.1 Халаалтын улирал нь 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 15, 2025 оны 09 дүгээр сарын 15-аас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл буюу жилд нийт 8 (найман) сар байна.

2.2. Гэрээний ажил

2.2.1. Дулаанаар хангагч талын ажил үүрэг: Гэрээний хугацаан дахь халаалтын улирлын сард хэрэглээг Соёлын төвийн барилга нийт **8,058.44 м³** халаалтын талбэй (эзлэхүүн) бүхий объектыг дулаанаар хангана.

2.2.2 Гэрээний төлбөр буюу халаалтын хөлс: Гэрээний төлбөр буюу халаалтын хөлс нь дулааны нэгж үнэ /12327/, хэрэглэгчийн халаалтын эзлэхүүн /8,058.44 м³/, халаалтын улирлын хугацаа буюу халаалт явах сарын тоо /8 сар/ гэсэн хэмжигдэхүүнүүдийн үржвэрээр тодорхойлогдоно.

2.3. Халаалтын зардлыг хэрэглэгчид хүргэсэн халаалтын гүйцэтгэлээр тооцож хангагч талын дансанд хуваарийн дагуу шилжүүлнэ.

2.3.1. Хэрэглэгч нь халаалтын сар бүрийн хөлсийг тухайн сард нь багтаан хангагч талын дансанд шилжүүлэх буюу эсвэл тооцоо нийлсэн акт хийж хангагч талын дансанд шилжүүлнэ.

2.3.2. Халаалтын хөлс түүний хэмжээ, төлөх хугацаа зэргийг талууд харилцан тохирсны үндсэн дээр шинээр буюу 2.3-д зааснаас өөрөөр тогтоож



болно. Дулааны үнэ /халаалтын хөлс/ нь эрх бүхий газрын тогтоол шигарснаар эсвэл үнийг өөрчилж шинэчлэх талаар талууд харилцан тохирсон талуудын гарын үсэг зурж тамга дарсан бичиг үйлдэгдсэнээр баталгаажиж мөрдөгдөнө.

2.3.3 Дулааны үнэ, халаалтын хөлсийг нэмэх шаардлага үүссэн үед хангагч тал нь үндэслэл тооцоог гаргаж хэрэглэгч руу болон ЭХЗЗ-д хандан 1-2 сарын хугацаатай санал шаардлага тавьж шийдвэрлүүлнэ.

2.3.4. Дээрх нөхцөлүүд ба хэмжигдэхүүнүүд, тэдгээрт холбогдох тодорхойлолтыг эрх бүхий газруудаас баталсан тогтоол тушаалын дагуу өөрчилж мөрдөж болох ба өөрчлөлт нь зөвхөн талууд харилцан тохирч баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

2.3.5 Халаалтын сард хангагчаас гэрээнд заасан нөхцөлд нийцсэн халаалт авч чадаагүйн улмаас нэмэлтээр халаалтын хэрэгсэл ашигласан цахилгааны төлбөрийг тооцож тухайн сарын халаалтын зардлаас хасаж тооцоо нийлэн төлбөрийг шилжүүлэх

Гурав. Хэрэглэгчийн эрх үүрэг

3.1. Хэрэглэгч дараах эрхтэй:

3.1.1. Хангагчаас гэрээнд заасан нөхцөл / халаалтын хугацаа, халаалтын талбай, дулааны үнэ, Тасалгааны 20С⁰ хэмээс багагүй дулааныг /-ийн дагуу авч хэрэглэх

3.1.2. Халаалтын зуухны үйл ажиллагаа хэвийн явж буй эсэхийг хянах, эргүүл шалгалт хийх, халаалтын зуух, дулааны үзэлүүд дээрх баталгаатай хянах хэмжих хэрэгслийн заалтуудыг тэмдэглэж бичилт хийх.

3.1.3. Халаалт дулаан хангамж доголдсон үед хангагчид мэдэгдэж шаардлага тавих, доголдол гэмтлийг засаж залруулах арга хэмжээг хамтран авах, шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлэхгүй байвал Мэргэжлийн хяналтын газар, эрчим хүчний хяналтын улсын байцаагчид мэдэгдэж хяналт шалгалт хийлгэх.

3.2. Хэрэглэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Халаалтын улирлын сар бүрийн 20-ны дотор хангагчтай тооцоо нийлж тухайн сард багтаан халаалтын хөлсөө төлөх.

3.2.2 Гэрээний талууд харилцан тохиролцож баталснаас бусад ямар ч тохиолдолд халаалтын төсөв, санхүүжилтийг бууруулахгүй байх, гэрээний нөхцөл дэх нэгж үнэ, халаалтын эзлэхүүн, халаалтын хугацаа зэргийг дангаараа өөрчлөхгүй байх.

3.2.3. Дулааны үнэ тариф нэмэх үндэслэл шаардлага үүссэн үед үнийн санал тооцоог үндэслэн дулааны үнэ ба халаалтын төсвийг шаардлагатай хувь хэмжээгээр нь нэмэгдүүлэн төсөвлүүлж, санхүүжүүлж байна.

3.2.4. Халаалт авах барилга объектынхоо дулааны техникийн нөхцөлийг бүрдүүлэх, дотоод шугам сүлжээгээ засах, дулаалга хийх зэрэг өвөлжилтийн бэлтгэл ажлыг дулаан авахаас өмнө хийж хангагчид хүлээлгэж өгдөг байх.

3.2.5. Өөрийн өмчийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн урсгал болон их засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх.

Дөрөв. Хангагчийн эрх, үүрэг

4.1. Хангагч дараах эрхтэй:

4.1.1. Гэрээнд заасан хугацаанд гэрээнд заасан дулаанаар хэрэглэгчийг хангах, дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа явуулах

4.1.2. Хэрэглэгчээс халаалтын улирлын сар бүр гэрээнд заасан нөхцөлийн дагуу нийлүүлсэн халаалтын төлбөрийг авах



4.1.3. Халаалтын хөлс, төлбөрөө хугацаанд нь төлөөгүй буюу дутуу үнэ нэмэх саналыг хугацаанд нь шийдвэрлээгүй дулаан хэрэглэгчийн хангамжийг түдгэлзүүлэх.

4.1.4. Техникийн нөхцөл хангаагүй, энэ гэрээг болон Эрчим хүчний хууль, ДЭХХДүрэм дэх нөхцөлүүдийг зөрчсөн, эс биелүүлсэн хэрэглэгчдийн дулаан хангамжийг түдгэлзүүлэх

4.2. Хангагч дараах үүрэгтэй:

4.2.1. Гэрээний хугацаан дах халаалтын улирлын саруудад хэрэглэгчийг дулаанаар тасралтгүй найдвартай хангах

4.2.2 Тасалгааны 20С⁰ хэмээс багагүй дулааныг тогтмол нийлүүлэх.

4.2.3. Халаалтын зуухыг горимын дагуу ажиллуулах, нүүрс, цахилгаан, тоног төхөөрөмж сэлбэг, холбоо, мэргэжилтэй ажилтны нөөц, удирдлагаар цаг тухайд нь шуурхай хангах.

4.2.4. Халаалтын зуухны засвар үйлчилгээг төлөвлөгөө графикийн дагуу хийдэг байх, хангагчийн буруугаас халаалт доголдсон үед шуурхай арга хэмжээ авч ажиллах

4.2.5. Дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сахин биелүүлж ажиллах.

4.2.6. Тухайн сум орон нутгийн хүмүүсийг ажилд авах, ажилчдаа мэргэжлийн сургалтад хамруулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх арга хэмжээ авах.

Тав. Хариуцлага хүлээлгэх ба маргаан шийдвэрлэх

5.1. Дулаанаар хангагч болон дулаан хэрэглэгч талууд нь холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд энэ гэрээг мөрдөн ажиллах эрх үүрэг хүлээх ба гэрээний хугацаанд гэрээг зөрчсөн буюу эс биелүүлсэн тал нь энэ гэрээнд заасны дагуу нөгөө талын өмнө хариуцлага хүлээнэ. Гэрээний аль нэг тал энэ гэрээг болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөнөөс буюу биелүүлээгүйгээс нөгөө талд хохирол учирсан бол хохирлоо нэхэмжлэн авах эрхтэй бөгөөд буруутай тал шууд хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

5.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн онцгой нөхцөл байдлын үед талууд бие биеэ аль болох бага хохиролтой гаргахын төлөө шаардлагатай бол хөрөнгө хүч, эд материалаар туслан хамтарч ажиллана. Гэнэтийн осол гамшгийн улмаас дулаан хангамж тасалдсан, хэрэглэгчид хохирол учирсан бол хангагч тал хариуцахгүй.

5.3. Гэрээг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах цуцлах журам:

5.3.1. Гэрээний талууд харилцан тохиролцсоноор гэрээг сунгаж, нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Нэмэлт өөрчлөлт, сунгалт нь талуудын гарын үсэг, тамга тэмдэгтэй байж хүчин төгөлдөр болно.

5.3.2. Энэхүү гэрээ нь дараах тохиолдлуудад цуцлагдсанд тооцогдоно.

- Гэрээний хугацаа нь дуусгавар болсон
- Цуцлах талаар талууд харилцан тохиролцсон

5.4. Гэрээг талууд дангаараа цуцлах журам:

5.4.1. Хангагч тал гэрээг дангаараа цуцлах нөхцөл:

- Хэрэглэгч халаалтын хөлсөө хугацаанд нь төлөөгүй, дутуу төлсөн
- Хэрэглэгч гэрээг болон холбогдох хууль дүрмийг зөрчсөнөөс хангагчид хохирол учирч үйл ажиллагаа хэвийн явуулах боломжгүй болсон
- Дулааны үнэ халаалтын хөлсийг нэмэх тухай шаардсанаас хойш 1 /нэг/ сарын хугацаа өнгөрөхөд хэрэглэгч тал үнэ ба халаалтын хөлсөө нэмээгүй
- Дулаан үйлдвэрлэл, хангамжийг хэвийн явуулахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлээгүй, энэ талаарх албан шаардлагын хариуд арга хэмжээ аваагүй, хугацаанд нь хариу өгөөгүй



- Хангагч тал үйл ажиллагаа явуулах боломжгүй болж энэ тухай мэдэгдэл өгөөд 3 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд хангагч нь хэрэглэгчид дангаараа цуцалж буй тухай албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх ба мэдэгдэл өгснөөс хойш 1 /нэг/ сарын дараагаас эхлэн гэрээг цуцлагдсанд тооцогдоно

5.4.2. Хэрэглэгч тал гэрээг дангаараа цуцлах нөхцөл:

Хангагч тал нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, удаан хугацаанд доголдуулсан, тасалсан / энэ нь Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актаар нотлогдсон байх/ тохиолдолд хэрэглэгч нь хангагчид албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх ба мэдэгдэл өгснөөс хойш нэг сарын дараагаас эхлэн гэрээг цуцлагдсанд тооцогдоно.

5.5. Хэрэглэгч тал нь халаалтын сардаа багтаж тухайн сарын халаалтын хөлсийг төлөөгүй буюу төлсөн бол хангагч нь хэрэглэгчид төлбөр төлөхийг шаардсан хугацаатай албан шаардлага хүргүүлнэ. Шаардлагын хугацаанд төлөхгүй бол холбогдох хууль тогтоомж ба энэ заалтын дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ. Хангагч тал гэрээг дангаараа цуцалж, холбогдох хугацааны халаалтын хөлс бусад хохирлоо шүүхэд хандан гаргуулж авна.

5.6. Талуудын хооронд маргаантай асуудал гарвал талууд хоорондоо харилцан ярилцаж тохирч шийдвэрлэж болох бөгөөд гэрээнд нэмж тусгах буюу харилцан зөвшөөрч баталгаажуулсан акт протокол үйлдэн гэрээний хамтаар мөрдөж байна.

5.7. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

5.8. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж хувь тус бүрийн хуудас бүр дээр талууд тамгаа дарж баталгаажуулсан байна. Гэрээний тал бүр нэг хувийг өөртөө авах ба хувь тус бүр хүчин төгөлдөр байж мөрдөгдөнө.

Зургаа. Гэрээний биелэлтийг дүгнэх

6.1 Энэхүү гэрээний биелэлтийг бүтэн жилээр дүгнэх бөгөөд "Гэрээ дүгнэх тэмдэглэл"-д талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

6.2 Гэрээ дүгнэсэн тэмдэглэл нь хангагч болон хэрэглэгч талууд цаашид хамтран ажиллах эсэхийг шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Хангагч талыг төлөөлж:

Гарын үсэг 

Нэр: Б. Гандол

Албан тушаал: "Төгөлдөр Ерөө"

ОНӨААТҮГ-ын Нягтлан бодогч

Хаяг: Сэлэнгэ, Ерөө сум

Утас: 99499162

Хэрэглэгч талыг төлөөлж:

Гарын үсэг 

Нэр: Б. Билэгмаа

Албан тушаал: Соёлын төвийн

Нягтлан бодогч

Хаяг: Сэлэнгэ, Ерөө сум

Утас: 99676233

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Нийлүүлэгч

Батлав Мон Өртөөчин ХХК

Захирал Ц.Батцэнгэл

20 25 он 01 сар 02 өдөр

Захиалагч

Батлав Сэлэнгэ Ерөө Соёлын төвийн

Дарга Ф.Болормаа

№ 1

Дархан

Нэг: Гэрээний зорилго

Энэхүү гэрээний зорилго нь харилцан бизнесийнхээ үйл ажиллагааг дэмжих, хэрэгцээ, хугацаа чанар зэрэг шаардлагыг бүрэн хангах, харилцан ашигтай нэгдсэн зорилготой бөгөөд гэрээт байгууллагын хоорондын харилцааны эрх, үүрэг, хариуцлагыг энэхүү гэрээгээр зохицуулна.

Хоёр: Гэрээний хугацаа

2.1 Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

1. Өгсөн захиалгыг тогтоосон хугацаанд нь шаардлагын дагуу чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангана.
2. Захиалгын хугацааны болон чанарын үл тохирол гарсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцна.
3. Захиалгат бүтээгдэхүүн бэлэн болсон тохиолдолд захиалагч талд мэдэгдэх.
4. Захиалагч үйлчлүүлэгчид хэвлэлийн бүтээгдэхүүний мэдлэг олгох үүргийг хүлээнэ.
5. Шаардлага хангасан материал бэлдээд захиалагч талд хянуулж, гэрээнд заасан хугацаанд багтаан хэвлэж нийлүүлэх үүргийг гүйцэтгэнэ.
6. Бэлэн болсон бүтээгдэхүүнийг сав баглаа боодлоор хангах үүрэгтэй.
7. Захиалгын материал нь захиалагч тал нэмж өөрчлөлт хийж байгаа бол хугацааг сунгах.
8. Захиалгын эх материалын эх бэлтгэл дууссанаас хойш захиалгын хугацааг тохиролцоно.
9. Захиалагч талын албан ёсны төлөөлөгч мөн болохыг шалгах эрхтэй.

2.2 Захиалагч талын эрх, үүрэг.

1. Өөрийн хэвлэлийн холбоотой захиалгыг гэрээт хугацаанд гүйцэтгэгч талаар гүйцэтгүүлэх үүрэгтэй.
2. Захиалгын эх материал гаргацтай хэвлэмэл байх шаардлагыг хангана.
3. Хэвлүүлэх бүтээгдэхүүний захиалгаа сар, улирал, жилийн хуваарь гарган өгсөн байх ба 3-7 хоногийн өмнө мэдэгдэж тохиролцоно.
4. Захиалагч талын өөрийн байгууллагын албан ёсны төлөөлөгчтэй байх ба түүнийг мөн болохыг баталсан баримт бичгээр хангасан байна.

5. Захиалагч тал гүйцэтгэгч талтай харилцахдаа харилцааны соёлтой элдэв маргаан зөрчил гаргахгүй байх үүрэгтэй.
6. Хэрвээ зөрчил гарвал гадны хэрэглэгчгүй үед харилцан тохиролцох замаар шийдвэрийг гаргуулах үүрэгтэй.
7. Захиалагч тал бэлэн болсон бүтээгдэхүүнийг шалган тоолж хүлээн авах үүрэгтэй.
8. Захиалгат бүтээгдэхүүний чанарын гологдолтой бол дахин засварлуулах гомдлоо барагдуулах эрхтэй.


Гурав. Талуудын хүлээх үүрэг хариуцлага.

1. Гэрээ талын төлөөлөл гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж тэр өдрөөс эхлэн мөрдөгдөнө.
2. Талууд нэг удаа гэрээг дүгнэх ба хоёр талын аль нэг гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлтэй бол нөгөө талдаа албан ёсоор мэдэгдэх харилцан зөвшилцөн гэрээний хавсралт болон гарын үсэг зурж баталгаажуулан мөрдөнө.
3. Талуудын аль нэг гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй түүнээс гарах хохирлыг бүрэн хариуцах ба маргаан гарвал харилцан зөвшилцөж тохиролцоно.
4. Хамтран ажиллах хугацаа 2025 оны 01 сарын 02-ны өдрөөс 2025 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар ажиллах.

Дөрөв. Гэрээний үнэ, захиалга, төлбөрийн нөхцөл

1. Бараа бүтээгдэхүүнийг захиалахдаа захиалгын нийт үнийн дүнгийн 40-60%-ийг урьдчилан төлөх бөгөөд захиалсан бүтээгдэхүүнийг хүлээн авсны дараа үлдэгдэл төлбөрийг барагдуулна.
2. Бусад захиалгын төлбөр тооцоог "Мон Өртөөчин" ХХК-ны нэхэмжлэхийн дагуу Худалдаа Хөгжлийн банкны 403104139 дансанд шилжүүлнэ.
3. Валютын ханш болон түүхий эдийн үнийн гэнэтийн өсөлтөөс хамааран нийлүүлж буй бүтээгдэхүүний нэгжийн үнэнд өөрчлөлт орохоор бол 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан



/Н.Тэрбиш/

Утас 99080937, 99372503



Захиалга, захиалгын төлбөр

Б.Тулзмаа

99676233

ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 01 сарын 02 өдөр

№

25/32

Сүхбаатар сум

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээг нэг талаас (үйлчлэгч гэх) **“Монгол шуудан” ХК**-ийг төлөөлж Сэлэнгэ аймгийн Шуудангийн үйлчилгээний газрын дарга **Г.Ган-Эрдэнэ** нөгөө талаас **“Сэлэнгэ аймгийн Ерөө сумын соёлын төв”** (үйлчлүүлэгч гэх)-ийг төлөөлж эрхлэгч **Ф.Болормаа** нар харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

1.2 Үйлчлүүлэгч, үйлчлэгч байгууллагын хооронд үүсэх аж ахуйн харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.3 Энэхүү гэрээ нь 2025 оны 01-р сарын 02-ны өдрөөс 2026 оны 01-р сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд хүчинтэй болно.

1.4 Гэрээний хугацаа дууссан болон гэрээг цуцлах, дуусгавар болгох санал аль нэг талаас гараагүй тохиолдолд уг гэрээг дээрх /1 жилийн/ хугацаагаар сунгасанд тооцно.

Хоёр. Үйлчлэгч байгууллагын эрх, үүрэг

2.1 Үйлчлүүлэгч байгууллагаас шуудангийн бүх төрлийн зүйлсийг хүлээн авч хугацаанд нь хаягт эзэнд нь хүргэж гардуулах ажиллагаа явуулна.

2.2 Хаягт эзэн хаягтаа эзгүй шалтгаанаар илгээмжийг хүлээн авах боломжгүй тохиолдолд түүний зөвшөөрлийн дагуу хамаарал бүхий этгээдэд гардуулж болно.

2.3 Гэрээний 2.1, 2.2-т заасны дагуу гардуулалт хийхэд хаягт эзнээр гарын үсэг /тоон гарын үсэг/ зуруулах болон бусад цахим хэрэгслээр дамжуулан хүлээн авсныг баталгаажуулна.

2.4 Үйлчлэгч нь шуудангаар явуулж байгаа шуудангийн илгээмжийн бүрэн бүтэн байдлыг үйлчлүүлэгчээс хүлээн авснаас эхлэн хаягт эзэнд нь гардуулах хүртэлх хугацаанд хариуцна.

2.5 Үйлчлэгч нь шинээр гэрээг хийхдээ уг байгууллага урьд нь шуудангийн ямар нэг салбар нэгжээр үйлчлүүлж байсан эсэх, үйлчлүүлж байсан бол төлбөр тооцоог дуусгасан байдлыг харгалзан үзнэ.

2.6 Үйлчлүүлэгчийн явуулах илгээмжийн хаяг нь стандартын дагуу гүйцэд бичигдсэн дугтуй болон хайрцаг сав, богцны битүүмжлэл нь тээвэрлэлтийн явцад бусад илгээмжийг гэмтээхгүйгээс гадна эвдэрч задрахгүй байх, бат бөх хийгдсэн эсэхийг шалгах бөгөөд стандартын шаардлага хангахгүй тохиолдолд хүлээн авахаас татгалзана.

2.7 Үйлчлэгч нь үйлчлүүлэгч төлбөрөө хугацаанд нь төлөөгүй нөхцөлд урьдчилан мэдэгдэж үйлчилгээгээ түр зогсоох эрхтэй.

2.8 Шуудан бэлтгэж явуулсны дараа ирүүлсэн зайлшгүй яаралтай богино хугацаанд явуулах шаардлагатай зүйл гарвал буухиа шуудангаар явуулах боломжтой эсэх, дараагийн шуудан явах графикт хугацааг мэдэгдэнэ.

2.9 Үзүүлэх шуудангийн үйлчилгээний төрөл:

- Олон улсын буухиа болон энгийн шуудан
- Дотоод энгийн болон буухиа шуудан
- Хэвлэл захиалга
- Дугтуй, марк худалдаа захиалга
- Шуудангийн хайрцаг эзэмших

Гурав. Үйлчлүүлэгч байгууллагын эрх, үүрэг

3.1 Үйлчлүүлэгч нь шуудангаар явуулж буй илгээмжийн мэдээллийг Postnet4 шуудан бүртгэлийн системд шивж илгээнэ. /Нэвтрэх эрхийг Үйлчлэгч олгоно/. Тухайн өдрийн 12 цагаас өмнө Postnet4 системд оруулсан захиалгыг тухайн өдөртөө очиж авч маргааш нь хүргэгдэхийг зарчим болгоно. Ийнхүү шивж оруулаагүй тохиолдолд мэдээллийг системд бүртгэхтэй холбоотойгоор гарах нэмэлт зардлыг шуудангийн байгууллагаас тогтоосон тарифын дагуу төлнө.

3.2 Үйлчлүүлэгч байгууллага нь шуудангаар явуулах шуудан илгээмжүүдийг шуудангийн стандартын дагуу бэлтгэж, эдийн тодорхойлолтод илгээж буй зүйлс бүрийн анхны өртгөөр нь бичиж үйлчлэгч байгууллагад хүлээлгэн өгнө.

3.3 Шуудангаар явуулж буй зүйлийнхээ хамгаалалтыг шаардлагын дагуу хийж хүлээн авагчийн болон өөрийн шуудангийн хаяг, zip кодыг зөв тодорхой гаргацтай бичсэн байна.

3.4 Хаяг алдаатай, стандартын дагуу бичигдээгүйгээс гарсан саатал, зөрчлийн хариуцлагыг гүйцэтгэгч тал хүлээхгүй болно.

3.5 Шуудангаар явуулсан илгээмжүүдийн төлбөрийг гэрээний дагуу шуурхай төлж, төлбөрийн даалгаврын нэг хувийг үйлчлэгч шуудангийн салбар нэгжийн кассет хүргүүлнэ.

3.6 Үйлчлүүлэгч нь шуудангийн үйлчилгээний төлбөрийн даалгаварт үйлчлэгчийн шуудангийн салбар нэгжийн нэр, дугаарыг тодорхой бичсэн байна.

3.7 Үйлчлүүлэгч байгууллага нь байршлаа өөрчилсөн тохиолдолд үйлчлэгч байгууллагад урьдчилан мэдэгдэж хаягийн өөрчлөлт хийлгэнэ.

3.8 Үйлчлэгч байгууллагын буруугаас болж будниж төөрүүлсэн, саатуулсан, дутагдуулсан, гэмтээсэн, алдаж үрэгдүүлсэн, хяналтын хугацаа хэтрүүлсэн зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр үйлчлэгч байгууллагын customerservice@mongolpost.mn цахим хаяг, болон 1800-1613, 70075070 тоот утсаар мэдэгдэж зөрчлийг арилгахад тусална.

3.9 Үйлчлүүлэгч нь явуулж буй шуудангийн илгээмжүүдийг зээл тооцооны №150 маягтад бичиж гарын үсэг зурж баталгаажуулна.

3.10 Хэрэв үйлчлүүлэгч өндөр өртөгтэй зүйлс /1'000'000₮-өөс дээш/ шуудангаар явуулж байгаа тохиолдолд “үнэ зарлах үйлчилгээ” буюу даатгагдсан хэлбэрээр үйлчлүүлж болох ба хэрэв үнэ зарлаагүй явуулсан илгээмж үйлчлэгчийн буруугаас алдаж, үрэгдсэн тохиолдолд үйлчлүүлэгч талд учирсан хохирлыг 5.1-д зааснаар барагдуулна.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Үйлчилгээний тарифыг үйлчилгээ үзүүлэх үед “Монгол Шуудан” ХК-нд хүчин төгөлдөр мөрдөж буй тарифыг үндэслэн тооцно. Үйлчилгээний тарифт өөрчлөлт орсон тохиолдолд үйлчлүүлэгч талд тухай бүр албан бичгээр болон үйлчилгээний ажилтнаар дамжуулан мэдэгдэнэ. Шинэчилэн баталсан үйлчилгээний тарифыг гэрээний хугацаанаас шалтгаалахгүйгээр тухайн тариф шинэчилэн батлагдсан өдрөөс эхлэн талууд мөрдөнө.

4.2 Үйлчлэгч нь тухайн сарын 20-ний өдрөөр тасалбар болгон нэхэмжлэлийг үйлчлүүлэгчид өгнө.

4.3 Үйлчлүүлэгч төлбөрийг үйлчлэгчээс нэхэмжлэл авснаас хойш 7 хоногийн дотор Төрийн банкны 150000023955 тоот дансанд шилжүүлнэ.

4.4 Үйлчлэгч, үйлчлүүлэгч байгууллага үйлчилгээний төлбөрийн тооцоог улирал тутам хийж, төлөгдөөгүй үлдэгдлийг харилцан тохирч баталгаажуулна.

4.5 Энэхүү гэрээний 4.1-д заасан үнийн санал нь харилцагч байгууллагын шуудангийн үйлчилгээний салбарт хүлээлгэн өгсөн илгээмжийг хаягт эзэнд гардуулан өгөхтэй холбоотой үйлчилгээнд хамаарна.

4.6 Илгээмжийг үйлчлүүлэгч байгууллагын хаягийн дагуу очиж аван, хүлээн авагчийн хаягаар хүргэж өгөхөд үйлчлэгч байгууллага хүргэлтийн үйлчилгээний хөлсийг сар бүрийн

шуудангийн үйлчилгээний төлбөр дээр нэмж нэхэмжилж болно.

Тав. Хариуцлага

5.1 Шуудангийн илгээмж алдаж, үрэгдсэн тохиолдолд үйлчлэгч шалтгааныг тогтоож Монгол шуудан хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2017.12.26-ны өдрийн №А/278 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Шуудангаар үйлчлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөх журам”-д заасны дагуу үйлчлүүлэгчийн хохирлыг барагдуулна. Уг журамд өөрчлөлт орвол Үйлчлүүлэгч талд тухай бүр мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүй тохиолдолд уг журмыг талууд мөрдөж хохирлыг тооцно.

5.2 Үйлчлүүлэгч шуудангийн илгээмжийн хамгаалалтыг шаардлагын дагуу хийгээгүй болон хаяг индексийг буруу буюу тодорхой бичээгүйн улмаас шуудангийн илгээмж гэмтэж саатсан, төөрснийг шуудан бэлтгэж явуулснаас хойш илрүүлсэн тохиолдолд үйлчлэгч хариуцлага хүлээхгүй.

5.3 Байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, аюулаас бусад тохиолдолд үйлчлэгчийн буруугаас бүртгэлтэй илгээмжийг хугацаанд нь хүргэж чадаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам үнийн дүнгийн 0.5 %-иар алданги төлнө.

5.4 Үйлчлүүлэгч төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам үнийн дүнгийн 0.5 %-иар алданги төлнө.

5.5 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд орсон тал нь нөгөө талдаа албан ёсоор мэдэгдэнэ.

Зургаа. Авилгын эсрэг хамтын ажиллагаа

6.1 Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхдээ аливаа ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчин ажиллах бөгөөд ажил хэргийн хүрээнд тогтоосон харилцаа холбоогоо ашиглан мөнгөн болон бусад хэлбэрээр авилга, хээл хахууль, өглөг, шан харамж, тусламж, дэмжлэг өгөх, гадаад дотоодод зорчих эрх, хөнгөлөлт бэлэг сэлт өгөх, урамшуулал өгөхийг хориглоно.

6.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад “Монгол шуудан” ХК-ийн аливаа ажилтан дээр дурдсан ашиг тусыг хүртэхийг зорьж, хамтын ажиллагаанд санаатайгаар саад учруулсан, хууль бусаар эд хөрөнгө шаардсан, илт шударга бус үйлдэл гаргаж байгааг олж мэдсэн тохиолдолд Монгол шуудан ХК-ийн Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс-т мэдээлэл ирүүлнэ үү. Мэдээлэл ирүүлэх утас: 70078977, и-мэйл хаяг: monitoring@mongolpost.mn

Долоо. Бусад зүйл

7.1 Гэрээ нь 2 хувь хийгдэх ба гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээг цуцлах болон нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал аль нэг талаас гарвал харилцагч талдаа 7 хоногийн өмнө албан

бичгээр мэдэгдэж талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

7.3 Шуудангийн илгээмжийн хаягийг бичихдээ mongolpost.mn веб хуудсанд байршсан зааврын дагуу хаяглана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



“Сэлэнгэ аймгийн Ерөө сумын соёлын
төв”-ийг төлөөлж:

Эрхлэгч.....Ф.Болормаа
Хаяг: Ерөө сум, Сэлэнгэ аймаг
Утас: 99929570
РД: 3744574



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

1. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр: ЕРӨӨ СУМЫН СОЁЛЫН ТӨВ
Гэрээний дугаар: 10184511
E-mail: bolormaa9570@gmail.com
Гар утас: 99676233
Холбогдох хүний утасны дугаар: 99676233
ТТД: 3744574
Хаяг: СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМ БУУРАГЧИН 2-Р БАГ 2-Р ХЭСЭГ
БУУРАГЧИН

2. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Энэхүү гэрээг нэг талаас Монгол улсын хуулийн этгээд болох 2073943 регистрийн дугаартай "Монголын Цахилгаан Холбоо" ХК /цаашид "Үйлчилгээ үзүүлэгч" гэх/, нөгөө талаас 3744574 тоот регистрийн дугаартай ЕРӨӨ СУМЫН СОЁЛЫН ТӨВ /цаашид "Хэрэглэгч" тал гэх, хамтад нь "Талууд" гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь үйлчилгээ үзүүлэгчээс хэрэглэгчид суурин утас, интернэт, Мип70, TVroom, KaTV, багцын үйлчилгээ, нэмэлт болон бусад үйлчилгээ /цаашид "Үйлчилгээ гэх/" үзүүлэх, хэрэглэгч гэрээнд заасны дагуу зохих төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
1.2. Гэрээний хавсралт нь гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1. Үйлчилгээ үзүүлэгч гэж "Монголын Цахилгаан Холбоо" ХК-ийг;
2.2. Хэрэглэгч гэж үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлж буй үйлчилгээг ашиглаж буй Хувь хүн, хуулийн этгээдийг;
2.3. Үйлчилгээ гэж суурин утас, интернэт, Мип70, TVroom, KaTV, багцын үйлчилгээ, нэмэлт болон бусад үйлчилгээг;
2.4. Холболтын хураамж гэж үйлчилгээг идэвхижүүлсний төлбөрийг;
2.5. Урьдчилсан төлбөрт үйлчилгээний үндсэн хугацаа гэж хуанлийн 30 хоногийг;
2.6. Сарын суурь хураамж гэж хэрэглэгчийн сонгосон үйлчилгээний сарын суурь хураамж ба бусад нэмэлт үйлчилгээний хураамжаас бүрдэх сар тутам тогтмол төлөх төлбөрийг тус тус ойлгоно.

Гурав. Үйлчилгээний үндсэн нөхцөл болон төлбөрийн нөхцөл

3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн сонгосон үйлчилгээ, нэмэлт болон бусад үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж сүлжээний найдвартай ажиллагааг ханган ажиллана.
3.2. Түрээсийн байранд түр хугацаагаар түрээсийн гэрээний дагуу байгаа иргэн, хуулийн этгээдийн албан хүсэлт, түрээсийн гэрээг үндэслэн үйлчилгээний гэрээг урьдчилсан төлбөрт нөхцөлөөр байгуулна.
3.3. Үйлдвэрийн гэмтлээс шалтгаалан хэрэглэгчийн төхөөрөмж /Wi-fi модем, Set top box, Ont, Home gateway, ... г.м/ гэмтсэн тохиолдолд хэрэглэгчийн өргөдлийг үндэслэн харьяа бүс, аймаг, дүүргийн ахлах инженерээр шалгуулан акт тогтоож, гэрээ байгуулснаас хойш 1 /нэг/ сарын дотор 1 /нэг/ удаа удаа үнэ төлбөргүй сольж өгч болно.
3.4. Хэрэглэгчийн төхөөрөмжийг /Ont, Home gateway/ 24, 36 сараар тасралтгүй ашиглах нөхцөлтэй тохиолдолд төхөөрөмж үнэгүй ба идэвхгүй тохиолдолд төхөөрөмжийн үнэ төлнө.
3.5. Хэрэглэгч гэрээ байгуулснаас хойш үйлчилгээг 2 сараас доош хугацаагаар ашигласан, хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний стандарт, чанарын шаардлага хангаагүй болохыг үйлчилгээ үзүүлэгчийн чанар хяналт хариуцсан нэгжээс тодорхойлсон, үйлчилгээ үзүүлэгчийн ажилтан нь хэрэглэгчид хүлээлгэн өгсөн төхөөрөмжийг шалгаж гэмтэлгүй гэж тус тус тогтоосон тохиолдолд төхөөрөмжийг акт үйлдэн буцааж авч болно.
3.6. Хэрэглэгч гэрээ байгуулснаас хойш үйлчилгээг 2 сараас дээш хугацаагаар ашигласан, хэрэглэгчийн буруугаас шалтгаалан төхөөрөмж гэмтэлтэй болсон тохиолдолд төхөөрөмжийг үнийг хэрэглэгчээр бүрэн төлүүлнэ.
3.7. Төлбөр нь сарын суурь хураамж, үндсэн болон нэмэлт үйлчилгээний төлбөр, бусад үйлчилгээний төлбөрөөс бүрдэх ба НӨАТ нэмж тооцно.
3.8. Талуудаас энэхүү гэрээг цуцлах санал /Төлбөрөө төлөөгүйгүйгээс гэрээ цуцлагдахаас бусад нөхцөлд/ гаргаагүй бол цаашид мөн хугацаагаар гэрээ сунгагдсанд тооцно.
3.9. Дараа төлбөрт үйлчилгээ

3.9.1. Дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгчийн төлбөр сар бүрийн 05-ны өдөр гарч, төлбөрийн мэдээллийг хэрэглэгчийн бүртгэлтэй хэрэглэгчийн цахим шуудангийн хаягаар илгээх бөгөөд төлбөрөө төлбөл зохих хугацаа тухайн сарын 20-ны

өдрийг дуустал байна.

3.9.2. Гэрээний 3.9.1-т заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хэрэглэгчийн суурин утсыг орох ярианы эрхтэйгээр ажиллуулах ба хэрэглэгчийн гар утсанд төлбөрийн санамж бүхий мессеж илгээнэ.

3.9.3. Дараа төлбөрт суурин утас, багцын хэрэглэгчийн орох, гарах ярианы эрх хаагдсанаас 61 /жаран нэг/ дэх хоног өнгөрөхөд төлбөр төлөгдөөгүй бол "Үйлчилгээ үзүүлэгч" хэрэглэгчийн үйлчилгээний эрхийг хааж /багцад багтах бүх үйлчилгээ/ гэрээг цуцалж, гарсан төлбөрийг хэрэглэгчээр төлүүлэх арга хэмжээг авна.

3.10. Урьдчилсан төлбөрт үйлчилгээ

3.10.1. Урьдчилсан төлбөрт үйлчилгээний /интернэт, кабелийн телевиз, хосолсон багцын интернэт үйлчилгээ/ хэрэглэгчийн үндсэн хугацаа дуусах өдрөөс 5 /тав/ хоногийн өмнө "Таны үйлчилгээний хугацаа 5 хоногийн дараа дуусна" гэсэн санамжийг хэрэглэгчийн цахим шуудангийн хаягаар, кабелийн телевизийн үйлчилгээний хэрэглэгчдэд Техник, технологийн ашиглалтын газраас системд тохиргоо хийж Set top box-оор, OTT үйлчилгээний хэрэглэгчид апплейкешнаар дамжуулан төлбөрийн санамжийг дэлгэцэнд гаргаж хэрэглэгчдэд тус тус мэдэгдэнэ.

3.10.2. Дан ярианы багцын урьдчилсан төлбөрт суурин утасны хэрэглэгчийн дансан дахь үлдэгдлээр үйлчилгээний сарын суурь хураамжийг цэнэглэхгүй ба дансан дахь үлдэгдлийг зөвхөн ярианы эрхээр ашиглана. Гарах ярианы эрх хаагдсанаас хойш 7 хоногийн хугацаатай зөвхөн орох ярианы эрхтэй байх ба 8 /найм/ дахь хоногоос түр хугацаагаар тасална.

3.10.3. Үйлчилгээний үндсэн хугацаа дууссанаас хойш 61 /жаран нэг/ дэх хоног болоход үйлчилгээний хугацаагаа сунгаагүй бол "Үйлчилгээ үзүүлэгч" хэрэглэгчийн үйлчилгээг бүрмөсөн тасалж, гэрээг цуцална.

3.10.4. Мип70 хэрэглэгчийн үйлчилгээний хугацаа дууссан өдрөөс гарах ярианы эрх хязгаарлагдах ба 90 хоног зөвхөн гаднаас дуудлага хүлээн авах ба энэ хугацаанд үйлчилгээний хугацааг сунгаагүй бол дугаар хураагдаж, гэрээг "Үйлчилгээ үзүүлэгч"-ийн санаачлагаар цуцална.

3.10.5. Мип70 үйлчилгээний хугацаа дууссан хэрэглэгчийн хүсэлтийг үндэслэн дансан дах үлдэгдлийг хоног болгох боломжтой ба харьяа холбооны газар хэрэглэгчийн дансан дах нэгжийн үлдэгдлээс хасалт хийн үйлчилгээний хоногийг батлагдсан тарифын дагуу хоногоор сунгаж болно. 90 хоногийн хүлээлгийн хугацаа дуусч хураагдсан тохиолдолд дансан дахь нэгж устгах ба хэрэглэгч үйлчилгээг сэргээхэд нэгж, хоногийн хугацаа 0 байна. .

3.10.6. Интернэт, кабелийн телевизийн үйлчилгээний үндсэн хугацаа дууссан өдрөөс интернэтийн болон IP хаягийн үйлчилгээний эрх хязгаарлагдана.

3.10.7. Үйлчилгээний эрх хязгаарлагдсан хугацаанаас хойш кабелийн телевизийн үйлчилгээний хэрэглэгч 12 сар, интернэтийн, багцын үйлчилгээний хэрэглэгч 91 /ерэн нэг/ дэх хоногоос бүрмөсөн тасалт хийж, гэрээг цуцална.

3.11. Төлбөр төлөлт

3.11.1. Төлбөр тооцооны мэдээллийг Улаанбаатар, орон нутгийн Хэрэглэгчийн үйлчилгээний төв, салбарууд болон 19001109, 70008000 утаснаас лавлаж болно.

3.11.2. Үйлчилгээний төлбөрийг Улаанбаатар хот болон орон нутгийн Хэрэглэгчийн үйлчилгээний төв, салбарууд болон банкнуудаар төлөх боломжтой.

Банк	Дансны дугаар	Банк	Дансны дугаар
Хаан банк	50 3801 7776	Төрийн банк	100 000 16 9250 100 000 99 9990
Худалдаа хөгжлийн банк	499 13 7062	Капитал банк	20 000 25 507
Голомт банк	113 103 9768		

3.11.3. Бэлэн бусаар үйлчилгээний төлбөр төлөх бол төлбөрийн даалгаврын гүйлгээний утга хэсэгт: гэрээний 2.3.-т заасан үйлчилгээний дугаарыг заавал бичнэ.

Дөрөв. Үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө тогтоосон хугацааны дотор төлөөгүй тохиолдолд үйлчилгээг түр болон бүрмөсөн таслах, гэрээг цуцлах /үйлчилгээ үзүүлэгчийн батлагдсан журмын дагуу/ эрхтэй.

4.2. Томоохон хэмжээний гэнэтийн гэмтэл, саатлын улмаас засвар хийх бол үйлчилгээг 48 цаг хүртэл хаах эрхтэй.

4.3. Хэрэглэгчээс гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

4.4. Үйлчилгээ үзүүлэгч үйлчилгээний үнэ болон нөхцөл, гэрээнд өөрчлөлт оруулах эрхтэй байна. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, өөрийн цахим сүлжээ, бусад сувгуудаар ажлын 5-с доошгүй хоногийн өмнө нийтэд мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээр өөрчлөлт орсонд тооцно.

4.5. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг өөрийн техникийн боломж, хүчин чадлын хүрээнд, стандартын дагуу, чанартай үзүүлэх, сүлжээний бэлэн байдлыг хангах үүрэгтэй.

4.6. Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн ярианы дэлгэрэнгүй жагсаалт болон хэрэглэгчийн мэдээллийн нууцыг чандлан хадгалж, бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

4.7. Хэрэглэгчээс үйлчилгээний талаар ирүүлсэн санал, хүсэлтийг 7000-8000 утсаар хүлээн авч, гаргасан гомлдыг шийдвэрлэх үүрэгтэй.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

5.1. Хэрэглэгч нь үйлчилгээг өөрийн хүсэлтээр сонгох, сонгосон үйлчилгээнийхээ талаар холбогдох мэдээллийг авах эрхтэй.

5.2. Интернэтийн нэмэлт үйлчилгээ +18 /шүүлтүүртэй интернэт/ болон бусад нэмэлт үйлчилгээг хэрэглэгч өөрийн хүсэлтээр сонгон авах эрхтэй.

5.3. Хэрэглэгчийн ярианы дэлгэрэнгүй жагсаалтыг гэрээ байгуулсан эзэмшигч болон түүний зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн

төлөөлөгч /гэрээ болон албан бичгийг үндэслэн/ хүсэлт гарган авах эрхтэй.

5.4. Хэрэглэгч гэрээний хугацаанд суурин утасны дугаарыг зөвхөн эзэмших, ашиглах эрхтэй.

5.5. Хэрэглэгч сонгосон үйлчилгээний суурь хураамж, бүртгэл, холболт, үйлчилгээний үнэ, хэрэглээний төлбөрийг үйлчилгээ үзүүлэгчийн тарифын дагуу гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрийг хэсэгчлэн төлөхгүй.

5.6. Хэрэглэгч ямар нэгэн байдлаар үйлчилгээ авах боломжгүй болсон тохиолдолд нэн даруй Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэж, үйлчилгээг хаалгаж төлбөр тооцоог бүрэн дуусгах үүрэгтэй. Энэ талаар мэдэгдээгүй нь гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

5.7. Хэрэглэгч нь үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд, хуулийн хүрээнд ашиглах үүрэгтэй.

5.8. Хэрэглэгчийн нэр, нууц үгээ хадгалах, өөрчлөх, сүлжээгээр дамжуулах мэдээллээ нууцлах, компьютерын вирус, бусдын халдлагаас хамгаалах, хэрэглэгч суурин утсыг үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэлгүйгээр бусдад шилжүүлсэн, дотуур холбооны төхөөрөмж /IP BOX/ болон бусад төхрөөмжүүдийг хэрэглэгчийн шугамд холбосон зэрэг техник, технологи, мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангаагүйгээс шалтгаалан үйлчилгээ саатах, тасрах, хууль бус гэмт хэргийн шинжтэй халдлага, дайралт /fraud, attack/ зэрэгт өртөх тохиолдолд үүссэн хохирлыг Хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.

5.9. Хэрэглэгчийн шугам /дотор монтаж, таталттай хэрэглэгчийн шугам, давхар хоорондын шугам/ болон төгсгөлийн төхөөрөмжийн /телефон аппарат, модем, router, set top box, home gateway, ONT, компьютер, зурагт ... г.м/ ашиглалт, бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.

5.10. Хэрэглэгч нь энэхүү гэрээний хэрэглэгчийн мэдээлэл хэсэг дэх мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр үйлчилгээ үзүүлэгчид өөрчлөлтийг хийлгэх үүрэгтэй.

Зургаа. Гэрээ цуцлах, шилжүүлэх тухай

6.1 Гэрээ цуцлах

6.1.1. Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтийг хуулийн этгээд албан бичгээр, иргэн маягт бөглөж гаргах бөгөөд үйлчилгээ үзүүлэгч нь албан хүсэлтийг үндэслэн гэрээг цуцална.

6.1.2. Хэрэглэгч гэрээг цуцлах хүртэлх үйлчилгээний төлбөр, хэрэглэгчийн төхөөрөмжийн тооцоог үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээ үзүүлэх журамд заасны дагуу бүрэн барагдуулна.

6.2. Гэрээ шилжүүлэх

6.2.1. Тухайн хэрэглэгчийн эзэмшиж байгаа гэрээ /үйлчилгээ/-г дараагийн хэрэглэгч өөрийн нэр дээр шилжүүлэх буюу эзэмшигчийн нэр солих үйлчилгээг авч болно. Энэ тохиолдолд иргэн, хуулийн этгээд бол эрх бүхий /итгэмжлэгдсэн/ хүн биеэр ирж албан бичгээр хүсэлт гаргана.

6.2.2. Хэрэглэгч гэрээг шилжүүлэх өдрийг хүртэлх үйлчилгээний төлбөр тооцоог дуусгавар болгоно.

Долоо. Хариуцлага

Хэрэглэгч үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдээгүй дур мэдэн төхөөрөмжийг салгасан, үйлчилгээг тасалдуулсан тохиолдолд үйлчилгээг авсанд тооцож, үйлчилгээний төлбөрийг төлнө.

7.2. Энэ гэрээний 5.6, 5.7-д заасан үүргээ зөрчсөнөөс гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг Хэрэглэгч дангаараа хариуцна.

7.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлж чадахгүйд хүрвэл 3 хоногийн дотор нөгөө Талдаа мэдэгдэнэ.

7.4. Гэрээний 7.3-д заасан нөхцөл байдлын улмаас хохирол учирсан бол Талууд харилцан хариуцлагаас чөлөөлөгдөнө.

7.5. Хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд үйлчилгээний төлбөрөө төлөөгүй тохиолдолд төлбөрийн үлдэгдлийн мэдээлэл Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдэнэ.

7.6. Хэрэглэгч өөрийн сүлжээний найдвартай байдлыг хангаж, гаднын халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах ба уг шаардлагыг хангаагүйн улмаас үүссэн хохирлыг үйлчилгээ үзүүлэгч тал хариуцахгүй.

7.7. Хэрэглэгч энэхүү гэрээний 5.10-т заасан үүргээ зөрчсөний улмаас учирсан хохирлыг өөрөө бүрэн хариуцна. /шаардлагатай мэдээллийг бүрэн авч чадаагүй гэх мэт/

7.8. Төлбөрөө урьдчилан төлсөн хэрэглэгч гэрээний үүргээ удаа дараа биелүүлээгүй, гэрээг өөрийн хүсэлтээр хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд урьдчилан төлсөн төлбөрийг хэрэглэгчид олгохгүй.

Найм.Бусад зүйл

8.1. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд адил, гэрээ цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Талуудын хооронд гарсан энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

8.3. Энэхүү гэрээтэй холбогдон гарах аливаа маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон гарын үсэг зурж, баталгаажуулав.

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

2025 он 02 сар 20 өдөр
 Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:
 Ажилтны нэр: SEL001014
 Хаяг: СБ сум 1 дугаар
 Утас: 70364802
 И-мэйл хаяг: sel.mtc@mtc.cne.net
 Гарын үсэг: [signature]

Хэрэглэгчийг төлөөлж:
 Хэрэглэгчийн нэр: ЕРӨӨ СУМЫН СОЁЛЫН ТӨВ
 Хаяг: СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМ БУУРАГЧИН 2-Р БАГ 2-Р
 ХЭСЭГ БУУРАГЧИН
 Утас: 99676233
 И-мэйл хаяг: bolorgaa9570@gmail.com
 Гарын үсэг: [signature]



3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Үйлчилгээний №	Төрөл	Үүсгэсэн огноо
B4271291	Дараа төлбөрт	22 Dec 2022
ddn-4271275	Дараа төлбөрт	22 Dec 2022
70366402	Дараа төлбөрт	22 Dec 2022

4. ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төхөөрөмжийн нэр	Борлуулах нөхцөл	Сериал дугаар	Сард төлөх дүн	Лизингийн хугацаа	Дуусах огноо

*Гэрээний хугацаанаас өмнө үйлчилгээг цуцласан тохиолдолд төхөөрөмжийн үнийг бүрэн барагдуулна

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:
 Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж: [signature]
 Тамга гарын үсэг нэр



[signature] Б.Тогтоол
 Төмрөг гарын үсэг нэр

Бүтээгдэхүүн				Огноо	Үйлчилгээний ажилтан
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД	ДАН БАГЦ	☐ Багц 1 16,500₮ ☐ Багц 3 49,500₮	Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 200 минут -3 нэмэлт үйлчилгээ Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 600 минут -7 нэмэлт үйлчилгээ	☐ Багц 2 33,000₮ Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 400 минут -5 нэмэлт үйлчилгээ	
	ХОСОЛСОН БАГЦ	☒ S Багц 55,000₮	Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 200 минут -3 нэмэлт үйлчилгээ	Интернэтийн хурд 10 Mbps	2025.02.20
		☐ M Багц 99,000₮	Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 400 минут -5 нэмэлт үйлчилгээ	Интернэтийн хурд 30 Mbps	
	ГУРВАЛСАН БАГЦ	☐ Багц 1 49,500₮	Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 30 минут -Нэмэлт үйлчилгээ 1	20 Mbps -80+ TB суваг SPS 5 суваг -96 цагаар нөхөж үзэх -Онцлохоос бусад контент үнэгүй	
		☐ Багц 2 66,000₮	Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 60 минут -Нэмэлт үйлчилгээ 3	50 Mbps -80+ TB суваг SPS 5 суваг -96 цагаар нөхөж үзэх -Онцлохоос бусад контент үнэгүй	
	ГУРВАЛСАН БАГЦ /СУМ/	☐ Демо багц 0₮	-TV room promo суваг, MYOHT үндсэн суваг	0 Mbps -80+ TB суваг SPS 5 суваг боломжгүй -96 цагаар нөхөж үзэх боломжгүй -контент боломжгүй	
		☐ Багц 1 165,000₮	-Анхны холболтын хураамж 22,000₮ -Сүлжээндээ хязгааргүй -Бусад сүлжээнд 400 минут -Нэмэлт үйлчилгээ 1	12 Mbps -80+ TB суваг SPS 5 суваг -96 цагаар нөхөж үзэх -Онцлохоос бусад контент үнэгүй	
	TV ROOM	☐ TV Room Standard багц	-80+ TB суваг -Онцлохоос бусад контент хязгааргүй -Нэг зэрэг ашиглах төхөөрөмж: 1		
		☐ TV Room Premium багц	-80+ TB суваг -Онцлохоос бусад контент хязгааргүй -SPS спорт сувгууд -96 цаг хүртэл нөхөж үзэх үйлчилгээ -Нэг зэрэг ашиглах төхөөрөмж:1		
	Төхөөрөмж	Төхөөрөмжийн үнэ хувааж төлөх нөхцөл ☐ 24сар ☐ 36сар			
	Суурин утас				

Интернэт			


*Гэрээний хугацаанаас өмнө үйлчилгээг цуцласан тохиолдолд төхөөрөмжийн үнийг бүрэн барагдуулна. /НӨАТ орсон/

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛТЭЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН
 Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:..... /
 Тамга гарын үсэг нэр



БАТЛАВ:

"Үйлс Дэвжих" ХХК-ны Захирал:

 Г. Энхжаргал/



БАТЛАВ:

Сэлэнгэ аймаг Ерөө сумын Соёлын төв
/Ф.Болормаа/



**КОМПЬЮТЕР ПРИНТЕР, БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ, ПРИНТЕРИЙН ХОР
ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

ГЭРЭЭ №

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү бараа материал худалдах, худалдан авах гэрээг /цаашид "Гэрээ" гэх/:

Нэг талаас 4274407 тоот регистрийн дугаартай, өөрийн дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж буй "ҮЙЛС ДЭВЖИХ" ХХК /цаашид "Худалдагч" гэх/-г төлөөлж Худалдааны менежер Д.Эрдэнэжаргал, Нөгөө талаас Сэлэнгэ аймаг Ерөө сумын Соёлын төв 3744574 регистрийн дугаартай /цаашид "Худалдан авагч" гэх/-г төлөөлж Ф.Болормаа нар харилцан тохиролцож /цаашид хамтад нь "Талууд", тусад нь "Тал" гэх/ 2025 оны 04 сарын 25-ны өдөр /цаашид "Гэрээт Өдөр" гэх/ дараах нөхцөлөөр энэхүү гэрээг 2025 оны 12 сарын 31-нийг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээнд хэрэглэгдэх нэр томъёо

- 2.1. Бараа материалыг тодорхой үр дүнд хүрэх зорилгоор
- 2.2. Принтерийн Хор
- 2.3. Бичиг хэрэг
- 2.4. Компьютер
- 2.5. Хяналтын камерт зориулсан бараа бүтээгдэхүүн байна.

Гурав. Ерөнхий зүйл

- 3.1. Гэрээнд заасан нөхцөлийн дагуу худалдагч нь Бараа материал худалдан авагчийн эзэмшилд шилжүүлэн өгч худалдан авагч нь түүнийг хүлээн авна.
- 3.2. Бараа материалын нэр төрөл, үнэ, тоо ширхэгийг тухай бүрд нь тохиролцоно.
- 3.3. Худалдагч нь гэрээний дагуу бараа материалыг худалдсанаар бүтээгдэхүүн ашиглах онцгой эрхийг худалдан авагчид шилжүүлэн өгнө.
- 3.4. Бараа материал, бүтээгдэхүүнийг ашиглах нөхцөл нь үйлдвэрлэгч компанийн бүтээгдэхүүнд хамаарах техникийн нөхцөлийн дагуу тодорхойлогдоно.

Дөрөв. Худалдагчийн баталгаа

- 4.1. Худалдагч нь бараа материалыг бүрэн эрх эзэмшигч болохыг нотолж эзэмших, захиран зарцуулах, 1 сарын хугацаанд ашиглахад баталгаа гаргаж байна.
- 4.2. Худалдагч нь үйлдвэрлэгч компанийн баталгаат түнш бөгөөд Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн, найдвартай бараа бүтээгдэхүүнээр бараа хангадаг болохыг баталж байна.
- 4.3. Бараа материалын үзүүлэлтүүд, чанар, бүрэн бүтэн байдал нь хавсралт 1-д заасан нөхцөлүүдтэй нийцсэн байна. Бараа материал бүтээгдэхүүний чанар, бүрэн бүтэн байдалтай холбоотойгоор гарч болох худалдан авагчийн хохирлыг худалдагч хариуцаж баталгаат хугацаанд бараа материалыг солих эсвэл засаж өгөх үүрэгтэй..

Тав . Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 6.1. Талууд бүтээглэхүүний нийт үнийг тусган
/..... /төгрөгөөр тохирч үүнд НӨАТатвар, гаалийн татвар ба бусад хураамжууд орсон болно.
- 6.2. Худалдан авагч нь Худалдагчийн гэрээний үнийг нэхэмжилснээс хойш ажлын 5 хоногийн дотор Худалдагчийн дансанд шилжүүлнэ.

Зургаа . Талуудын хариуцлага

- 7.1. Худалдагч нь гэрээний 4.2-р зүйлд заасан хохирлыг учруулсан тохиолдолд худалдан авагчид ийнхүү учирсан шууд хохирлыг бүрэн хариуцах бөгөөд худалдан авагчийн шууд бус хохирол ба олж болох ашгийн алдагдлыг хариуцахгүй.
- 7.2. Худалдагч нь гэрээний 5.2-р зүйлд заасан хугацаанд бараа бүтээгдэхүүнийг нийлүүлээгүй тохиолдолд нийлүүлэлт хойшлогдсон хоног тус бүрд гэрээт үнийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг худалдан авагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ нь гэрээт үнийн 5 хувиас хэтрэхгүй байна.
- 7.3. Худалдан авагч нь гэрээний 6.2-р зүйлд заасан хугацаанд бараа бүтээгдэхүүний үнийг төлөөгүй тохиолдолд төлбөр хойшлогдсон хоног тус бүрд гэрээний үнийн 0,1 хувьд тэнцэх алдангийг худалдагчид төлөх ба энэхүү алдангийн нийт хэмжээ гэрээт үнийн 5 хувиас хэтрэхгүй байна.

Долоо. Гэрээний нууцлал

- 8.1 Талууд уг гэрээний биелэлттэй холбоотой мэдээллийг зөвхөн бичгээр солилцоно. Дээрхи бичгээр хийгдсэн мэдээллүүдийг явуулсан, хүлээж авсан хугацааг тодорхой тогтоох үүднээс албан ёсны шуудан, факс, биет төлөөлөгчийг ашиглан дамжуулна. Бичгээр хийгдсэн мэдэгдэл талуудын харилцан зөвшөөрөгдсөн тамга тэмдэг гарын үсгээр баталгаажсан байна. Электрон шуудангаар харилцах тохиолдолд эсрэг тал хүлээж авснаа мэдэгдсэн тохиолдолд мэдээллийг явуулсанд тооцно.
- 8.2 Талууд гэрээний биелэлтийн хугацаанд болон дууссанаас хойш 12 сарын дотор уг гэрээний заалтуудтай болон бие биенээсээ авсан мэдээлэлтэй холбоотой асуудлыг гуравдахь этгээдэд задруулахгүй. Талууд гэрээнд оролцогч талтай холбоотой нууц мэдээллийг бичгээр өгсөн албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдахь этгээдэд задруулж үл болно.
- 8.3 Талууд мэдээлэл задарсан тохиолдолд гэрээнд оролцогч талдаа яаралтай мэдэгдэнэ.
- 8.4 Талууд гэрээний нууцлал хадгалах үүргээ иргэний хуулиар татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан ч ганцаарчилсан байдлаар цуцалж үл болно.
- 8.5 Нууц задарна гэдэг нь гэрээнд оролцогч талуудын үйлдэл, эс үйлдлийн үр дүнд мэдээлэл гуравдагч этгээдэд задарсан тохиолдол болно. Энэ тохиолдолд мэдээлэл ямар хэлбэрээр задарсан нь хамаагүй.
- 8.6 Хэрэв нууц мэдээллийг хууль эрх сахиулах газар, төрийн эрх барих байгууллага болон албан тушаалтан хуулийн дагуу шаардаж авсан тохиолдолд аль нэг талыг нууц задалсанд тооцохгүй. Энэ тухай ажлын 2 хоногт мэдээлнэ.

Найм . Давагдашгүй хүчин зүйл

- 9.1 Талуудын төлбөр төлөх үүргээс бусад үүрэг хариуцлага нь тухайн талын хяналтаас давсан, урьдчилан тооцоолох, зохих арга хэмжээ авах боломжгүй нөхцөл байдлаас болж түр хойшлогдож болох ба үүнд дор дурьдсан зүйлийг хамруулна:

- (a) Байгалийн гамшиг /үер, гал, шуурга, газар хөдлөлт г.м.л/;
(b) Дайн, үймээн самуун ба нийгмийн бусад сөрөг нөхцөл байдал;
(c) Гэрээний биелэлтэд нөлөөлөх төрийн, захиргааны ба шүүхийн эрх бүхий байгууллагын шийдвэр;
(d) Аваар осол, эвдрэл, үйлдвэрлэл, худалдаа, тээврийн хэрэгсэл албадан хураагдсан ба бусад техникийн нөхцөл байдал.
- 9.2 Давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал нь нөгөө талд тухайн давагдашгүй хүчин зүйлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгч давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэх хугацаа, гэрээний биелэлт хойшлогдсон хугацааг урьдчилан тооцож мэдээлнэ.
- 9.3 Аль нэгэн тал давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрийн гэрээт үүргээ бүрэн буюу хэсэгчлэн гүйцэтгэж чадахгүй болсон нөхцөлд энэхүү тал нь хариуцлагаас чөлөөлөгдөж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой нөхцөл бүрдсэн үед бүрэн гүйцэтгэнэ.
- 9.4 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээт өдрөөс 3 сарын дотор (эсвэл талуудын харилцан зөвшилцсөн өөр хугацаанд) үүргээ биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд аль ч тал гэрээг цуцлах эрхтэй.

Ес . Бусад

- 8.1 Дагаж мөрдөх хууль. Гэрээ Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдаж, тайлбарлагдана.
- 8.2 Маргаан шийдвэрлэх. Гэрээтэй холбоотой маргаан гарвал талууд зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд эс зөвшилцвөл маргааныг Монголын шүүхийн байгууллагаар Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 8.3 Хүчин төгөлдөр хугацаа. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдөр хүчин төгөлдөр болох бөгөөд 2025 оны 12-р дугаар сарын 31-ний өдөр хүртэл хүчинтэй байна.
- 8.4 Гэрээний нэмэлт өөрчлөлт. Гэрээнд оруулж болох аливаа нэмэлт, өөрчлөлт нь бичгээр үйлдэгдэж талуудын бүрэн эрхт төлөөлөгч гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж гэрээний салшгүй хэсэг болон хавсрагдана.
- 8.5 Бүрэн гэрээ. Гэрээ нь талуудын бүрэн харилцан ойлголцлыг илэрхийлнэ.

Талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болсныг ийнхүү нотолж байна:

Талуудын албан ёсны хаяг, банкны мэдээлэл:

Нийлүүлэгч:

"Үйлс Дэвжих" ХХК
Хаяг: Дархан Уул аймаг Дархан сум 15-р баг
Номин Агуулах худалдаа 84 тоот
Утас: (976) 88097073.80097073
E-mail: ukaika0@gmail.com
Банкны Мэдээлэл: Хас Банк 5005645816

Худалдан авагч:

Хаяг: Сэлэнгэ аймаг Ерөө сумын Соёлын төв
Утас: 99929570, 99676233
E-mail: bilegmaab82@gmail.com
Банкны Мэдээлэл: Төрийн сан 100130235095

Худалдааны менежер:

4274407 4516223412



/Д.Эрдэнэжаргал /

Огноо

2025 оны 04 дугаар сарын 25-ны өдөр



Нягтлан бодогч

 /Б.Билэгмаа /

Огноо

2025 оны 04 дугаар сарын 25-ны өдөр



БАТЛАВ:
ХАНГАГЧ:
"ТӨГӨЛДӨР ЕРӨӨ" ОНӨААТҮГ
ДАРГА Ц.УРТНАСАН

БАТЛАВ:
ХЭРЭГЛЭГЧ:
СЭЛЭНГЭ АЙМАГ ЕРӨӨ СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Ф.БОЛОРМАА

ДУЛААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

2025 оны 09 сарын 15 өдөр

№ 023

Тавин

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэт талаас "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ /цаашид энэ гэрээний дулаанаар хангагч тал болох/, нөгөө талаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Соёлын төв /цаашид энэ гэрээний дулаан хэрэглэгч тал болох/ нар харилцан тохиролцож дулаан үйлдвэрлэх, дулаанаар хангах, дулаан авах, хэрэглэх талаар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

1.2. Хангагч нь дулаан үйлдвэрлэх, түгээх ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөл боломжоор хангагдсан байх, хэрэглэгч нь халаалт дулаан хангамжаар найдвартай хангагдах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.3 Энэхүү гэрээ нь Эрчим хүчний тухай хууль, холбогдох дүрэм, журам болон Сумын Засаг даргын 2022 оны 09 сарын 30-ны өдрийн А/210 тоот захирамжийн хүрээнд байгуулагдаж тэдгээрийг удирдлага болгон зохицуулагдах бөгөөд талууд хууль, дүрэм, журмын хүрээнд энэ гэрээг мөрдөж эрх үүрэг хариуцлага хүлээж ажиллана.

Хоёр. Гэрээний нөхцөлүүд

2.1 Гэрээний хугацаа: Энэ гэрээ нь 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл нийт 4 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

2.2. Гэрээний ажил

2.2.1. Дулаанаар хангагч талын ажил үүрэг: Гэрээний хугацаан дахь халаалтын улирлын сард хэрэглээг Соёлын төвийн барилга нийт 8,058.44 м³ халаалтын талбай (эзлэхүүн) бүхий объектыг дулаанаар хангана.

2.2.2 Гэрээний төлбөр буюу халаалтын хөлс: Гэрээний төлбөр буюу халаалтын хөлс нь дулааны нэгж үнэ /1,232₮/, хэрэглэгчийн халаалтын эзлэхүүн /8,058.44 м³/, халаалтын улирлын хугацаа буюу халаалт явах сарын тоо /4 сар/ гэсэн хэмжигдэхүүнүүдийн үржвэрээр тодорхойлогдоно.

2.3. Халаалтын зардлыг хэрэглэгчид хүргэсэн халаалтын гүйцэтгэлээр тооцож хангагч талын дансанд хуваарийн дагуу шилжүүлнэ.

2.3.1. Хэрэглэгч нь халаалтын сар бүрийн хөлсийг тухайн сард нь багтаан хангагч талын дансанд шилжүүлэх буюу эсвэл тооцоо нийлсэн акт хийж хангагч талын дансанд шилжүүлнэ.

2.3.2. Халаалтын хөлс түүний хэмжээ, төлөх хугацаа зэргийг талууд харилцан тохирсны үндсэн дээр шинээр буюу 2.3-д зааснаас өөрөөр тогтоож болно. Дулааны үнэ /халаалтын хөлс/ нь эрх бүхий газрын тогтоол шийдвэр гарснаар эсвэл үнийг өөрчилж шинэчлэх талаар талууд харилцан тохирсон тухай талуудын гарын үсэг зурж тамга дарсан бичиг үйлдэгдсэнээр баталгаажиж мөрдөгдөнө.

2.3.3 Дулааны үнэ, халаалтын хөлсийг нэмэх шаардлага үүссэн үед хангагч тал нь үндэслэл тооцоог гаргаж хэрэглэгч руу болон ЭХЗЗ-д хандан 1-2 сарын хугацаатай санал шаардлага тавьж шийдвэрлүүлнэ.

2.3.4. Дээрх нөхцөлүүд ба хэмжигдэхүүнүүд, тэдгээрт холбогдох тодорхойлолтыг эрх бүхий газруудаас баталсан тогтоол тушаалын дагуу өөрчилж мөрдөж болох ба өөрчлөлт нь зөвхөн талууд харилцан тохирч баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

2.3.5 Халаалтын сард хангагчаас гэрээнд заасан нөхцөлд нийцсэн халаалт авч чадаагүйн улмаас нэмэлтээр халаалтын хэрэгсэл ашигласан цахилгааны төлбөрийг тооцож тухайн сарын халаалтын зардлаас хасаж тооцоо нийлэн төлбөрийг шилжүүлэх

Гурав. Хэрэглэгчийн эрх үүрэг

3.1. Хэрэглэгч дараах эрхтэй:

3.1.1. Хангагчаас гэрээнд заасан нөхцөл / халаалтын хугацаа, халаалтын талбай, дулааны үнэ, Тасалгааны 20С⁰ хэмээс багагүй дулааныг /-ийн дагуу авч хэрэглэх

3.1.2. Халаалтын зуухны үйл ажиллагаа хэвийн явж буй эсэхийг хянах, эргүүл шалгалт хийх, халаалтын зуух, дулааны үзэлүүд дээрх баталгаатай хянах хэмжих хэрэгслийн заалтуудыг тэмдэглэж бичилт хийх.

3.1.3. Халаалт дулаан хангамж доголдсон үед хангагчид мэдэгдэж шаардлага тавих, доголдол гэмтлийг засаж залруулах арга хэмжээг хамтран авах, шаардлагыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлэхгүй байвал Мэргэжлийн хяналтын газар, эрчим хүчний хяналтын улсын байцаагчид мэдэгдэж хяналт шалгалт хийлгэх.

3.2. Хэрэглэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Халаалтын улирлын сар бүрийн 20-ны дотор хангагчтай тооцоо нийлж тухайн сард багтаан халаалтын хөлсөө төлөх.

3.2.2 Гэрээний талууд харилцан тохиролцож баталснаас бусад ямар ч тохиолдолд халаалтын төсөв, санхүүжилтийг бууруулахгүй байх, гэрээний нөхцөл дэх нэгж үнэ, халаалтын эзлэхүүн, халаалтын хугацаа зэргийг дангаараа өөрчлөхгүй байх.

3.2.3. Дулааны үнэ тариф нэмэх үндэслэл шаардлага үүссэн үед үнийн санал тооцоог үндэслэн дулааны үнэ ба халаалтын төсвийг шаардлагатай хувь хэмжээгээр нь нэмэгдүүлэн төсөвлүүлж, санхүүжүүлж байна.

3.2.4. Халаалт авах барилга объектынхоо дулааны техникийн нөхцөлийг бүрдүүлэх, дотоод шугам сүлжээгээ засах, дулаалга хийх зэрэг өвөлжилтийн бэлтгэл ажлыг дулаан авахаас өмнө хийж хангагчид хүлээлгэж өгдөг байх.

3.2.5. Өөрийн өмчийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн урсгал болон их засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх.

Дөрөв. Хангагчийн эрх, үүрэг

4.1. Хангагч дараах эрхтэй:

4.1.1. Гэрээнд заасан хугацаанд гэрээнд заасан дулаанаар хэрэглэгчийг хангах, дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа явуулах

4.1.2. Хэрэглэгчээс халаалтын улирлын сар бүр гэрээнд заасан нөхцөлийн дагуу нийлүүлсэн халаалтын төлбөрийг авах

4.1.3. Халаалтын хөлс, төлбөрөө хугацаанд нь төлөөгүй буюу дутуу төлсөн, үнэ нэмэх саналыг хугацаанд нь шийдвэрлээгүй дулаан хэрэглэгчийн дулаан хангамжийг түдгэлзүүлэх.

4.1.4. Техникийн нөхцөл хангаагүй, энэ гэрээг болон Эрчим хүчний хууль, ДЭХХДүрэм дэх нөхцөлүүдийг зөрчсөн, эс биелүүлсэн хэрэглэгчдийн дулаан хангамжийг түдгэлзүүлэх

4.2. Хангагч дараах үүрэгтэй:

4.2.1. Гэрээний хугацаан дах халаалтын улирлын саруудад хэрэглэгчийг дулаанаар тасралтгүй найдвартай хангах

4.2.2 Тасалгааны 20C⁰ хэмээс багагүй дулааныг тогтмол нийлүүлэх.

4.2.3. Халаалтын зуухыг горимын дагуу ажиллуулах, нүүрс, цахилгаан, тоног төхөөрөмж сэлбэг, холбоо, мэргэжилтэй ажилтны нөөц, удирдлагаар цаг тухайд нь шуурхай хангах.

4.2.4. Халаалтын зуухны засвар үйлчилгээг төлөвлөгөө графикийн дагуу хийдэг байх, хангагчийн буруугаас халаалт доголдсон үед шуурхай арга хэмжээ авч ажиллах

4.2.5. Дулаан үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сахин биелүүлж ажиллах.

4.2.6. Тухайн сум орон нутгийн хүмүүсийг ажилд авах, ажилчдаа мэргэжлийн сургалтад хамруулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх арга хэмжээ авах.

Тав. Хариуцлага хүлээлгэх ба маргаан шийдвэрлэх

5.1. Дулаанаар хангагч болон дулаан хэрэглэгч талууд нь холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд энэ гэрээг мөрдөн ажиллах эрх үүрэг хүлээх ба гэрээний хугацаанд гэрээг зөрчсөн буюу эс биелүүлсэн тал нь энэ гэрээнд заасны дагуу нөгөө талын өмнө хариуцлага хүлээнэ. Гэрээний аль нэг тал энэ гэрээг болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөнөөс буюу биелүүлээгүйгээс нөгөө талд хохирол учирсан бол хохирлоо нэхэмжлэн авах эрхтэй бөгөөд буруутай тал шууд хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

5.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн онцгой нөхцөл байдлын үед талууд бие биеэ аль болох бага хохиролтой гаргахын төлөө шаардлагатай бол хөрөнгө хүч, эд материалаар туслан хамтарч ажиллана. Гэнэтийн осол гамшгийн улмаас дулаан хангамж тасалдсан, хэрэглэгчид хохирол учирсан бол хангагч тал хариуцахгүй.

5.3. Гэрээг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах цуцлах журам:

5.3.1. Гэрээний талууд харилцан тохиролцсоноор гэрээг сунгаж, нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Нэмэлт өөрчлөлт, сунгалт нь талуудын гарын үсэг, тамга тэмдэгтэй байж хүчин төгөлдөр болно.

5.3.2. Энэхүү гэрээ нь дараах тохиолдлуудад цуцлагдсанд тооцогдоно.

- Гэрээний хугацаа нь дуусгавар болсон
- Цуцлах талаар талууд харилцан тохиролцсон

5.4. Гэрээг талууд дангаараа цуцлах журам:

5.4.1. Хангагч тал гэрээг дангаараа цуцлах нөхцөл:

- Хэрэглэгч халаалтын хөлсөө хугацаанд нь төлөөгүй, дутуу төлсөн
- Хэрэглэгч гэрээг болон холбогдох хууль дүрмийг зөрчсөнөөс хангагчид хохирол учирч үйл ажиллагаа хэвийн явуулах боломжгүй болсон
- Дулааны үнэ халаалтын хөлсийг нэмэх тухай шаардсанаас хойш 1 /нэг/ сарын хугацаа өнгөрөхөд хэрэглэгч тал үнэ ба халаалтын хөлсөө нэмээгүй
- Дулаан үйлдвэрлэл, хангамжийг хэвийн явуулахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлээгүй, энэ талаарх албан шаардлагын хариуд арга хэмжээ аваагүй, хугацаанд нь хариу өгөөгүй
- Хангагч тал үйл ажиллагаа явуулах боломжгүй болж энэ тухай мэдэгдэл өгөөд 3 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд хангагч нь хэрэглэгчид гэрээг

дангаараа цуцалж буй тухай албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх ба мэдэгдэл өгснөөс хойш 1 /нэг/ сарын дараагаас эхлэн гэрээг цуцлагдсанд тооцогдоно

5.4.2. Хэрэглэгч тал гэрээг дангаараа цуцлах нөхцөл:

Хангагч тал нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, удаан хугацаанд доголдуулсан, тасалсан / энэ нь Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актаар нотлогдсон байх/ тохиолдолд хэрэглэгч нь хангагчид албан бичгээр мэдэгдэл хүргүүлэх ба мэдэгдэл өгснөөс хойш нэг сарын дараагаас эхлэн гэрээг цуцлагдсанд тооцогдоно.

5.5. Хэрэглэгч тал нь халаалтын сардаа багтаж тухайн сарын халаалтын хөлсийг төлөөгүй буюу төлсөн бол хангагч нь хэрэглэгчид төлбөр төлөхийг шаардсан хугацаатай албан шаардлага хүргүүлнэ. Шаардлагын хугацаанд төлөхгүй бол холбогдох хууль тогтоомж ба энэ заалтын дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ. Хангагч тал гэрээг дангаараа цуцалж, холбогдох хугацааны халаалтын хөлс бусад хохирлоо шүүхэд хандан гаргуулж авна.

5.6. Талуудын хооронд маргаантай асуудал гарвал талууд хоорондоо харилцан ярилцаж тохирч шийдвэрлэж болох бөгөөд гэрээнд нэмж тусгах буюу харилцан зөвшөөрч баталгаажуулсан акт протокол үйлдэн гэрээний хамтаар мөрдөж байна.

5.7. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

5.8. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж хувь тус бүрийн хуудас бүр дээр талууд тамгаа дарж баталгаажуулсан байна. Гэрээний тал бүр нэг хувийг өөртөө авах ба хувь тус бүр хүчин төгөлдөр байж мөрдөгдөнө.

Зургаа. Гэрээний биелэлтийг дүгнэх

6.1 Энэхүү гэрээний биелэлтийг бүтэн жилээр дүгнэх бөгөөд "Гэрээ дүгнэх тэмдэглэл"-д талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

6.2 Гэрээ дүгнэсэн тэмдэглэл нь хангагч болон хэрэглэгч талууд цаашид хамтран ажиллах эсэхийг шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Хангагч талыг төлөөлж:

Гарын үсэг 

Нэр: Б. Гандөл

Албан тушаал: "Төгөлдөр
ОНӨААТҮГ-ын Нягтлан бодогч

Хаяг: Сэлэнгэ, Ерөө сум

Утас: 99499162

Ерөө"

Хэрэглэгч талыг төлөөлж:

Гарын үсэг 

Нэр: Б. Билэгмаа

Албан тушаал: Соёлын төвийн
Нягтлан бодогч

Хаяг: Сэлэнгэ, Ерөө сум

Утас: 99676233

4.2 Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлэх ажлын хөлс нь хог хаягдлын үйлчилгээний хураамжд хамаарахгүй, дээрхи үйлчилгээний хөлсийг тусдаа байгуулсан гэрээний нөхцлийн дагуу төлнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

5.1 Гэрээ нь 2025 оны 11 сарын 11 өдрөөс 2025 оны 12 сарын 31 өдөр хүртэл 1 жил 0 сарын хугацаатайгаар байгуулав.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

6.1 Талууд хагас эсвэл бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, тооцоо нийлсэн акт үйлдэнэ.

6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол Хог хаягдлын тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Энэхүү гэрээг гүйцэтгэхэд нөлөөлөх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл /үер ус, газар хөдлөлт, гал түймэр, нийтийг хамарсан үймээн самуун гэх мэт онц байдлын нөхцлүүд/ үүссэн тохиолдолд талууд гэрээний үүргээсээ татгалзах эрхтэй ба талууд учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхгүй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД

9.1 Талууд гэрээнд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан:

Тээвэрлэгч

“Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-ыг
төлөөлж Орлогын байцаагч ажилтай
М. Батцэцэг /Ш.Батцэцэг/
/Гарын үсэг/

Утас: 99496388, 91696960, 99439374

Тээвэрлүүлэгч

Соёл төв
/Иргэн, ААНБ-ын нэр/
туунийг төлөөлж
А. Талархиа
/гарын үсэг, нэр/

Утас:

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “ТӨГӨЛДӨР ЕРӨӨ” ОНӨААТҮГ



Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний гэрээ

Гэрээний дугаар: 012
ААНБ/Иргэн-ий нэр: Соёл төв

2025он

ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

2025 оны 02 сарын 01 өдөр Ерөө сум

Гэрээний дугаар:	012
Иргэн, ААНБ-ын нэр:	Соёлн тов.
Иргэн, ААНБ-ын Регистрийн дугаар:	3744574
Үйл ажиллагаа явуулж буй объектын оноосон нэр:	Соёлн, тов.
Үйл ажиллагааны чиглэл:	Соёл, нийгмийн тов.
Байршил:	Зр баг
Иргэн, ААНБ-ын хаяг:	хуучин хуучин
Иргэн, ААНБ-ын холбогдох утас:	
Хог хаягдлын хураамж,	Ажилтны тоо _____ бүтэцтэй тоо 100 Байгууллагын м2 _____ Сард _____ төгрөг Жилд _____ төгрөг Сард _____ удаа
Хог хаягдлын хураамж төлөх банк:	Хүлээн авагчийн нэр: Хог хаягдлын төлбөр Харилцах банкны нэр: Ерөө төрийн сан банк

Нэг талаас "Төгөлдөр Ерөө" ОНӨААТҮГ /цаашид "Хог хаягдал тээвэрлэгч" гэх/ Нөгөө талаас _____
Соёлн тов

/Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр/
/Цаашид "Хог хаягдал тээвэрлүүлэгч" гэх/ түүнийг төлөөлж _____
Хуучин _____ ажилтай _____ нар Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль, Ерөө сумын ИТХ-ын 2021 оны 05 сарын 10-ны өдрийн 30 тоот тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоол, журам зэргийг удирдлага болгон дараах нөхцлийг харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.5 Энэхүү гэрээгээр Хог хаягдал тээвэрлүүлэгчийн хог хаягдлыг Хог хаягдал тээвэрлэгч нь гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэн

төвлөрсөн хогийн цэгт хүргэх, нөгөө талаас Хог хаягдал тээвэрлүүлэгч нь гэрээнд заасан хугацаанд заасан төлбөрийг төлөх талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.6 Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын "Иргэний хууль", "Хог хаягдлын тухай хууль" болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

ХОЁР. ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1 Хог хаягдал тээвэрлэх 2 талын тохирсон хугацааг баримталж хог тээврийн үйлчилгээг үзүүлэх.

2.2 Хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй аюулгүй ажиллгааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

2.3 Хог хаягдал тээвэрлэх жолооч, ачигч нар нь зохих сургалтанд хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлага хангаж ажиллана.

2.4 Хог хаягдлыг тээвэрлэх үед унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ авна.

2.5 Овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдал тээвэрлүүлэх бол нэмэлт ажлын хөлсийг 2 тал тохиролцоно.

ГУРАВ. ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан "Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн" чанарын шаардлага хангасан хогийн савыг байршуулах.

3.2 Хог хаягдлыг зориулалтын хогийн сав болон цэгээс хүлээлгэн өгөх ба хуваарийн дагуу ачих үед саадгүй тээвэрлэх нөхцлийг бүрдүүлнэ. Задгай хог хаягдлыг 80-аас доошгүй литрийн багтаамжтай зориулалтын уутанд хийж савлана. Хөлдүү хогийг тээвэрлүүлэгч өөрөө хариуцаж хогийн сав болон орчноос бүрэн суллаж, ачихад бэлтгэнэ.

3.3 Хог хаягдлын талаарх сургалтанд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх.

3.4 Хог хаягдал тээвэрлүүлэгч нь овор хэмжээ ихтэй болон барилгын хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд тээвэрлэгч байгууллагад хүсэлт гаргаж, хуулийн дагуу тусдаа гэрээ байгуулсны үндсэн дээр тухайн хог хаягдлыг тээвэрлүүлнэ.

3.5 Хог хаягдал тээвэрлүүлэгч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үйл ажиллагаа зогсоох хугацааг урьдчилан мэдэгдэж, хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг албан бичгээр гаргаж өгнө.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

4.1 Ерөө сумын ИТХ-ын 2021 оны 05 сарын 10-ны өдрийн 30 тоот тогтоолыг үндэслэн хог хаягдлын хураамжийг тооцож _____ төгрөгийг Ерөө төрийн сан банкны дансанд төвлөрүүлэх.

АЖ АХУЙН НЭГЖИЙГ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

Хэрэглэгчийн код: 425010658

2025 оны 8 сарын 25 өдөр

Энэхүү гэрээг нэг талаас "Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ХК (цаашид "**Хангагч**" гэх), түүнийг төлөөлж Сүхбаатар -ийн Борлуулалтын ажилтан албан тушаалтай Э.Баярсүвд, нөгөө талаас Монгол улсад бүртгэлтэй СОЁЛЫН ТӨВ" (цаашид "**Хэрэглэгч**" гэх), түүнийг төлөөлж албан тушаалтай нар (цаашид хамтад нь "**Талууд**", талуудын аль нэгийг "**Тал**" гэх) дараах нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож 2025-08-25 өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай хүчинтэй байхаар байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Хангагчтай "Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ" байгуулах хэрэглэгч нь шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлтэй, цахилгаан эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй, хэрэглэгчдийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийлгэсэн байна.
- 1.2. Энэхүү гэрээг иргэн болон хуулийн этгээдийн эзэмшигчтэй байгуулна. Эзэмшигчийн өмнөөс нотариатаар баталгаажсан итгэмжлэгдсэн төлөөлөгч байгуулж болно.
- 1.3. Төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар эзэмшигч итгэмжлэгдсэн төлөөлөгч нар адил эрх үүрэг хүлээнэ.
- 1.4. Энэхүү гэрээгээр нэг талаас Хангагч нь "Эрчим хүчний тухай хууль"-ийн дагуу Хэрэглэгчийг цахилгаан эрчим хүч (цаашид "**ЦЭХ**" гэх)-ээр хангах, нөгөө талаас Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүч хэрэглэсний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх, энэхүү гэрээ болон дор дурьдсан хууль зүйн актуудыг дагаж мөрдөх үүргийг тус тус харилцан тохиролцож оруулав.
- 1.5. Энэхүү гэрээгээр шууд зохицуулагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсын Иргэний тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Хэмжилзүйн тухай хууль, Зөрчилийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Нэгдсэн сүлжээний дүрэм, Аж ахуйн харилцааны дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж байгууламжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм болон бусад холбогдох эрх зүйн актын заалтуудыг баримтлан зохицуулна.
- 1.6. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, хангагч хэрэглэгч хоёр байгууллагын баталгаат гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж талуудад хадгалуулах ба хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 1.7. Хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 1.8. Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 1. "Эрчим хүч" гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулаан болон шугам сүлжээгээр дамжуулан хэрэглэгчид түгээх метаны хийг;
 2. "Эрчим хүчний эх үүсвэр" гэж эрчим хүчний нөөцийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулж цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа байгууламжийг;
 3. "Нэгдсэн сүлжээ" гэж цахилгаан хангамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хоорондоо холбогдсон эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээний нэгдлийг;
 4. "Нэгдсэн сүлжээний дүрэм" гэж нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн хэсгийн техникийн үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээг;
 5. "Цахилгаан дамжуулах сүлжээ" гэж нэгдсэн сүлжээ үүсгэж байгаа цахилгаан дамжуулах зориулалт бүхий 110 кВ, түүнээс дээш хүчдлийн шугам, дэд станц, түүнчлэн энэ сүлжээнд холбогдсон, эсхүл техник, технологийн хувьд энэ сүлжээнд хамрагдах шаардлагатай бусад хүчдлийн шугам, дэд станцыг;
 6. "Цахилгаан түгээх сүлжээ" гэж эх үүсвэрээс шууд холбогдсон болон цахилгаан дамжуулах сүлжээний дэд станцаас хэрэглэгчийн тоног төхөөрөмж хүртэлх цахилгаан түгээх зориулалт бүхий 110кВ, түүнээс доош шугам, дэд станцыг;
 7. "Эрчим хүчний барилга байгууламж" гэж эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам, дэд станц болон технологийн зориулалттай бусад байгууламжийг;
 8. "Төвлөрсөн дулаан хангамж" гэж дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг болон дулааныг дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэрээс диспетчерийн зохицуулалттайгаар, эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50 хувиас дээш хэсгийг шугам сүлжээгээр хангах үйл ажиллагааг;
 9. "Халаалтын улирал" гэж барилга, байгууламжийг дулаанаар хангах шаардлагатай, хүний ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон жилийн цаг агаарын дундаж үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон хугацааг;
 10. "Эрчим хүчээр хангагч" гэж эрчим хүчний зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
 11. "Хэрэглэгч" гэж эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүчийг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийг;

12. "Аж ахуйн харилцааны дүрэм" гэж хангагч, хэрэглэгчийн хоорондын гэрээний нөхцөл, шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөрийн нөхцөлийг тусгасан хэм хэмжээ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг;
13. "Тариф" гэж үйлдвэрлэгчийн үнэ, дэмжих тариф диспетчерийн зохицуулалтын болон дамжуулах, түгээх, хангах үйлчилгээний төлбөр, импортын цахилгааны үнэ, хэрэглэгчийн эрчим хүчний үнэ, эсхүл эдгээрийн аль нэгийг багтаан Эрчим хүчний зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнийг;
14. "Диспетчерийн зохицуулалт" гэж диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулааны үйлдвэрлэл, хэрэглээг тэнцвэржүүлэн нэгдсэн сүлжээний өдөр тутмын шуурхай үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохицуулахыг;
15. "Хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдваржилтын зэрэглэл" гэдэгт тухайн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний тасалдлыг зөвшөөрөх нөхцөл, хугацаа, уг нөхцөл, хугацааг хангахуйц техникийн шаардлагын хэм хэмжээг;
16. "Нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгч" гэж бие биеэс үл хамаарах хоёр талын тэжээл бүхий үндсэн ба бэлтгэл шугамтай, үндсэн тэжээлийн шугам хүчдэлгүй болоход хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмж уг шугамаас салж бэлтгэл шугамд залгагдах автомат удирдлагатай байвал цахилгаан хангамжийн тасалдлын зөвшөөрөгдөх хугацаа нь нэг талын тэжээл тасрахад бэлтгэл тэжээл нь автоматаар залгагдах хугацаагаар тодорхойлогдсон өөрийн тасралтгүй ажиллагааг хангахуйц бие даасан эх үүсгүүртэй хэрэглэгчийг;
17. "Хоёрдугаар зэрэглэлийн хэрэглэгч" гэж бие биеэс үл хамаарах хоёр талын тэжээл бүхий үндсэн ба бэлтгэл шугамаар холбогдсон боловч үндсэн тэжээлийн шугам хүчдэлгүй болоход хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмж уг шугамаас салж бэлтгэл шугамд залгагдах автомат удирдлага байхгүй, цахилгаан хангамжийн тасалдлын зөвшөөрөгдөх хугацаа нь жижүүрийн буюу шуурхай үйлчилгээний явуулын бригадын хүмүүс бэлтгэл тэжээлийг залгахад шаардагдах хугацаагаар тодорхойлогдсон хэрэглэгчийг;
18. "Гуравдугаар зэрэглэлийн хэрэглэгч" гэж ганц шугам трансформатороор холбогдсон тэдгээр нь гэмтсэн тохиолдолд хангагч очиж сэргээн засварладаг хэрэглэгчийг;
19. "Аваарийн байдал" гэж нэгдсэн сүлжээнд чадлын дутагдал үүсэх, давтамж унах, нэгдсэн сүлжээ тусдаа гарах, хуваагдах, дулаан, цахилгааны үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтэд саатал үүсэх, хэрэглэгчдийн дулаан, цахилгааныг хязгаарлах, таслах зэрэг нөхцөл байдалд орохыг;
20. "Бэлтгэл тоног төхөөрөмж" гэж шаардлага гарсан үед ажиллагаанд залгаж болох тоноглолыг;
21. "Захиалга" гэж тоноглолыг хэвийн ажиллагаа буюу бэлтгэлээс гаргахад үйлдэгддэг засварын ажлын товч утга, гаргах хугацаа, аваарийн журмаар ажилд залгах хугацаа зэргийг тодорхойлж техникийн дээд удирдлагаар батлуулсан мэдэгдэлийг;
22. "Техникийн нөхцөл" гэж иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг цахилгаанаар хангах зорилгоор тэдгээрийн байр, байгууламж, тоног төхөөрөмжийг цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбох, хэрэглэгчийн цахилгааны чадлыг нэмэгдүүлэхтэй холбогдсон техникийн шийдлийг тусгасан, хангагчаас цахилгаан хэрэглэгч буюу цахилгаанаар хангагдахыг хүссэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон баримт бичгийг;
23. "Эзэмшлийн зааг" гэж дамжуулагч, түгээгч, хангагч болон хэрэглэгчийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээг өмчлөлийн буюу эзэмшлийн харъяаллаар нь хуваан зааглаж байгаа цэгийг;
24. "Хэрэглээг тооцох цэг" гэж хэрэглэгчид түгээсэн цахилгаан эрчим хүчний хэмжээг тодорхойлох зорилгоор цахилгаан дамжуулах, түгээх сүлжээнд тооцооны хэмжих хэрэгслийг холбосон цэгийг;
25. "Тооцооны хэмжих хэрэгсэл" гэж хэрэглээг тооцох цэг дээр төлбөрийг тооцох зорилгоор тавьсан цахилгааны тоолуур, чадлын итгэлцүүр, тэдгээрт холбогдсон хэмжүүрийн трансформатор болон холболтын хэрэгслийг;
26. "Хяналтын хэмжих хэрэгсэл" гэж тухайн сонгосон цэг дээр хянах зориулалтаар тавьсан цахилгааны тоолуур, чадлын хэмжүүр, тэдгээрт холбогдсон хэмжүүрийн трансформатор болон холболтын хэрэгслийг;
27. "Шууд хохирол" гэж цахилгаан хангамж тасалдсанаас болон чанарын үзүүлэлт хэлбэлзсэнээс хэрэглэгчид учирсан бүтээгдэхүүний чанарын гологдол, цахилгаан хэрэгслийн гэмтлийг;
28. "Цахилгаан тоног төхөөрөмж" гэж цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэх, хувирган өөрчлөх, дамжуулах, хуваарилах, хэрэглэх төхөөрөмжийг;
29. "Цахилгааны бие даасан үүсгүүр" гэж цахилгаан эрчим хүчний суурин (хангагчийн) үүсгүүрээс хамааралгүйгээр хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр тэжээх боломжтой үүсгүүрийг;
30. "Үл хамаарах эх үүсвэр" гэдэгт тухайн хэрэглэгчийн 1 талын тэжээл тасрахад нөгөө талын хүчдэл нь стандартуудад заагдсан хэмжээнд байх 2 ба түүнээс дээш тэжээлийн эх үүсвэрийг;
31. "Нөхөн тооцоо" гэж хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаас шалтгаалан хангагч нь эрчим хүчний тооцоо, төлбөрийн зөрүүг арилгахаар авсан арга хэмжээг;
32. "Алданги" гэж ЦЭХ-ний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй эсвэл дутуу төлөгдсөн дүнд хоног тутам тавигдах төлбөрийг;
33. "Хазайлтын төлбөр" гэж хэрэглэгчийн тухайн сарын захиалга, хэрэглээний гүйцэтгэлийн зөрүү нь 2 хувиас илүү буюу дутуу гарсан хазайлтанд ноогдуулсан төлбөрийг;
34. "Төлбөрийн барьцаа" гэж хэрэглэгч нь төлбөрийн баталгаа болгон цахилгаан эрчим хүчний хэрэглээний урьдчилан байршуулсан төлбөрийг;

ХОЁР. ХАНГАГЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭЗЭМШЛИЙН ЗААГ


2.1 Техникийн нөхцөл:

а. Олгосон: он сар өдөр №

Хаанаас олгосон:

2.2 Хангагч, хэрэглэгч нь дор дурьдсан хувилбаруудын дагуу цахилгаан шугам, тоног төхөөрөмжийн эзэмшлийн заагаа тогтооно. Талуудын тоног төхөөрөмжийн эзэмшлийн заагийг 025 -р хувилбараар тогтоов.

2.2.1. Эзэмшлийн заагийн схем:



2.2.2. Эзэмшлийн зааг бичиглэлээр: АТП-163 дэд станцын, 1-р гаргалгааны, тоолуур төвлөрсөн хайрцаг №.1 н гаргалгааны автоматанд холбосон хэрэглэгчийн оруулганы кабелийн эхний холбоосоор эзэмшлийн заагийг тогтоов.

2.3 Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30.1.8 дугаар заалт Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.8, 5.1.11, 5.1.14, 5.1.16 дугаар заалтуудын дагуу энэхүү эзэмшлийн заагаас цааш өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, цахилгааны утас, кабелийн үзлэг үйлчилгээ, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааг болон гал түймэр эсэргүүцэх багаж хэрэгслээр тоноглохыг хариуцна.

2.4 Хэрэглэгчийн эзэмшлийн зааг доторх цахилгааны утас, тоног төхөөрөмж, орон байр, хашаа зэрэгт гарсан аливаа хүний амь нас эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх гал түймэр гарах, мал амьтан, эд хөрөнгөнд хохирол учрах зэргийг хангагч байгууллага хариуцахгүй.

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН НАЙДВАРЖИЛТЫН ЗЭРЭГЛЭЛ

3.1 Цахилгаан хангамжийн найдваржилтын зэрэглэлийн техникийн шаардлага ба хэрэглэгчийн зэрэглэл

- а. Нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгчид нь харилцан бие биеийнхээ бэлтгэл тэжээл болох үл хамаарах 2 эх үүсвэрээс тэжээгдэх 2 талын тэжээлтэй байхаас гадна өөрийн мэдлийн аваарийн эх үүсвэртэй байх бөгөөд эдгээрийн аль нэг нь тасрахад өөр хоорондоо автоматаар залгагдах схемтэй (АВР-тай) байна. Хэрэглэгчийн харъяаны эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадал нь түүний тасралтгүй ажиллагаатай байх нэгжүүд /байрууд/-ийг хангахад хүрэлцэхүйц хэмжээтэй байна. Нэгдүгээр зэрэглэлийн хэрэглэгчид нь өөрийн мэдлийн эрчим хүчний бэлтгэл үүсвэрийг ажиллуулахад зориулсан түлш, сэлбэг материал, багаж, материалын нөөцтэй байх бөгөөд бэлтгэл эх үүсвэрийн ажиллагааны байнгын бэлэн байдлыг хангах үүрэгтэй.
- б. Хоёрдугаар зэрэглэлийн хэрэглэгч нь харилцан бие биеийнхээ бэлтгэл тэжээл болох үл хамаарах хоёр эх үүсвэрээс тэжээгдсэн байх ба эдгээр хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тасалдлын зөвшөөрөгдөх хугацаа нь жижүүрийн буюу шуурхай үйлчилгээний явуулын бригадын хүмүүс бэлтгэл тэжээлийг залгахад шаардагдах хугацаагаар тодорхойлогдоно.
- в. Хэрэглэгч нь ганц шугам, трансформатораар холбогдсон бол гуравдугаар зэрэглэлийн хэрэглэгч болох ба гамшиг үүссэнээс бусад тохиолдолд цахилгаан хангамжийн тасралтад өртсөн хэсэг бүлэг хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг тухайн хангагчийн үйлчилгээний цэгээс гэмтэл гарсан байршил хүртэлх зай (үйлчлэх хүрээ)-наас хамаарч доорх хүснэгтэд заасан хугацаанд сэргээнэ.

Д/д	Үйлчилэх хүрээ /зай/	Тасралтыг сэргээх хугацаа
1	20 км хүртэл	4 цагийн дотор
2	20-40км хүртэл	8 цагийн дотор
3	40-80км хүртэл	14 цагийн дотор
4	80-150км хүртэл	20 цагийн дотор

5	150-250км хүртэл	38 цагийн дотор
6	250 км буюу түүнээс дээш	48 цагийн дотор

3.2 Цахилгаан станц, дэд станцуудын 2 секц /систем шин/ нь дараахи нөхцөлүүдийг нэгэн зэрэг хангаж байвал уг секцүүдийг /систем шинүүдийг/ үл хамаарах тэжээлд тооцно. Үүнд:

- Эдгээр секцүүд /систем шинүүд/ нь тус бүрдээ үл хамаарах үүсвэрүүдээс тэжээгдэж байх.
- Эдгээр секцүүд /систем шинүүд/ нь хоорондоо холбогдоогүй байх эсхүл хоорондоо холбогдсон боловч аль 1 секцийн /систем шинийн/ хэвийн ажиллагаа алдагдахад холбоос нь автоматаар тасардаг байх.

3.3 Монгол улсын эрчим хүчний систем нь чадлын дутагдалд орсон, ОХУ-н эрчим хүчний системээс тусгаарлагдсан, Үйлдвэрлэх болон Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шугам тоноглол дээр гарсан гэмтлээс шалтгаалсан хязгаарлалт, тасралтын хугацааг тус тусгай зөвшөөрөл эзэмшигч гэмтлийг сэргээн засварлах хугацаагаар тодорхойлно.

3.4 Хангагч хэрэглэгчийн хүсэлтээр цахилгаан эрчим хүчний найдваржилтын нэг ба хоёрдугаар зэрэглэлд тохирсон үйлчилгээ үзүүлж болно. Тухайн зэрэглэлийг хангах техникийн боломжийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хэрэглэгч хариуцна.

3.5 Хэрэглэгч нь undefined

ДӨРӨВ . ТООЦООНЫ ЗААГ, ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ

- Хэрэглэгчийн эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тооцохдоо эзэмшлийн зааг дээр хэрэглээг тооцохоор тавьсан тоолуур, тооцооны хэмжих хэрэгслүүдийг ашиглана. Хангагчтай гэрээ бүхий хэрэглэгчийн шугам тоноглолоос хангагдаж байгаа хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээг тус хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээнээс хасаж тооцно.
- Тооцооны хэмжих хэрэгсэл буюу тоолуур, хэмжүүрийн трансформаторууд нь Монгол улсын "Хэмжилзүйн тухай хууль"-ийн дагуу стандарт хэмжил зүйн газарт загварын туршилтад орж баталгаажсан Стандарт Хэмжилзүйн байгууллагын улсын байцаагчаар шалгагдан баталгаажсан, тэдгээрийн холболтын хэлхээ нь тусдаа хайрцаг шитэнд байрласан ба Хангагчийн эрх бүхий ажилтны битүүмжилсэн лацтай байна.
- Тоолуурын хайрцаг буюу шитийг 1.4-1.7 метрийн өндөрт хөдөлгөөнгүй байрлуулах бөгөөд найдвартай газардуулсан (4 Омоос бага) байх шаардлагатай. Газардуулгын хэмжилтийг жил бүрийн аянгын улиралын өмнө эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулсан байна.
- Тооцооны хэмжих хэрэгслийг тэжээж байгаа хэмжүүрийн трансформаторыг солих, тооцооны тоолуурыг салгах, тавих ажлыг зөвхөн хангагчийн зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Тооцооны тоолуурыг сүлжээнээс салгах, холбох үед хэрэглэгчийн төлөөлөгчийг байлцуулна.
- Тооцооны хэмжих хэрэгслийг тэжээж байгаа хүчдэлийн трансформаторын салгуурын бариул, түүний холболтын цуглуулга зэргийг байрлуулсан шит, хайрцаг, тоолуурын таг зэргийг хангагчийн эрх бүхий ажилтан битүүмжилсэн байна.
- Тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг уг хэмжих хэрэгслийн эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хариуцна.
- Эзэмшлийн зааг дээр тооцооны хэмжих хэрэгсэл тавих боломжгүй тохиолдолд хэрэглээг тооцох цэг дээр суурилуулсан тоолуур, тооцооны хэмжих хэрэгслүүдийг ашиглана. Энэ тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэл шугам трансформаторын алдагдлыг зохих журмын дагуу тооцож хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээ дээр нэмж тооцно.
- Тооцооны тоолуур гэмтсэн, гацсан болон бусад тохиолдолд тоолуур тоолоогүй үеийн төлбөр тооцоог нам талын тоолуур, суурилагдсан хүчин чадал, хэмжилт болон холбогдох тооцоо, балансыг хийж харилцан тохиролцож нөхөн тооцно.
- Тоолуур хэмжих хэрэгслийг хэлхээнээс салгаж авах болон шалгаж засварлах тохиолдолд гэрээт талууд харилцан тохиролцож баланс тооцооны аргаар хэрэглэсэн ЦЭХ-ний тоо хэмжээг тогтооно.
- Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн зааг дотор байгаа бүх шугам, трансформаторын цахилгааны алдагдлыг хариуцана.
- Хангагчийн эрх бүхий ажилтны тавьсан лацыг бүрэн бүтэн байлгахыг Хэрэглэгч хариуцна.
- Хэрэглэгч нь тоолуур хэмжих хэрэгслийн тохируулга, засвар үйлчилгээ хийх, баталгаажуулахад шаардлагатай зардлыг хариуцна.
- Хэрэглэгч нь ЦЭХ-ний зарцуулалтад дотоодын хяналт тавих зорилгоор шаардлагатай хэсэг, нэгж цахилгаан тоноглолдоо хяналтын тоолууруудыг байрлуулж болно.
- Тооцооны тоолуур болон хэмжих хэрэгслийг солих, засварлах, тохируулга шалгалт хийхдээ талуудын төлөөлөгчийг байлцуулж протокол үйлдэнэ. Протоколд хуучин шинэ тоолууруудын заалт, баталгаажуулсан огноо, тоолуурын марк, дугаар, гүйдлийн трансформаторын коэффициентыг тэмдэглэж талууд гарын үсэг зурсан байна.
- Талуудын хооронд тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагаатай холбогдон гарсан маргааныг хамтарсан комисс томилон зөрчлийг судлан шийдвэрлэх бөгөөд харилцан ойлголцолд хүрээгүй тохиолдолд стандарт хэмжилзүйн улсын байцаагчаар шийдвэрлүүлнэ.

ТАВ . ТӨЛБӨР, ТООЦОО

- 5.1. Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтын тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан, хангагчийн ажилтны битүүмжилсэн тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуурын заалтыг баримтлан Хангагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь сар бүрийн 1-5 -ны өдөр тоолуурын заалтыг авч хэрэглэсэн ЦЭХ-ний тооцоог хийж нэхэмжлэх бичнэ.
- 5.2. ЦЭХ-ний төлбөр тооцооны нэхэмжлэх, Цахилгаан хангамж түдгэлзүүлэх мэдэгдлийг хэрэглэгчийн энэхүү гэрээнд бүртгэлтэй цахим шуудангаар /e-mail/ илгээснээр хүлээн авсанд тооцно.
- 5.3. Эрчим хүчний зарцуулалтын хэмжээг тооцохдоо тоолуураар гарсан заалтын зөрүүг гүйдэл хүчдэлийн трансформаторын итгэлцүүрээр үржүүлнэ.
- 5.4. Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан бусад тарифыг аргачлалын дагуу тооцож нэхэмжлэлд тусгана.
- 5.5. Хэрэглэгчийн тоолуурын заалт авах үед тухайн тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байгааг хангагчийн ажилтан илрүүлсэн бол тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэлд хэрэглэгчийн буруутай үйлдэл нөлөөлсөн эсэхийг тогтооно.
- 5.5.1. Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсанд хэрэглэгч буруутай буюу цахилгаан эрчим хүчийг зүй бусаар ашигласан болох нь тогтоогдвол "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 7.5 дугаар заалт (цахилгаан тоног төхөөрөмжийн суурилагдсан чадлыг ажиллавал зохих цаг / сүүлийн удаа шалгалт хийснээс хойш тухайн зөрчлийг арилгах хүртлэх/-аар үржүүлж тодорхойлно)-ыг үндэслэн хэрэглээг тооцно.
- 5.5.2. Тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэлд хэрэглэгч буруугүй тохиолдолд хэрэглэгчийн тухайн сарын хэрэглээг "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 7.6 дугаар заалтыг үндэслэн сүүлийн 3 сарын тоолуурын заалтаар тооцсон хэрэглээний дунджаар тооцно.
- 5.6. Хэрэглэгч нь цахилгаан эрчим хүчний төлбөрөө бичилт хийснээс хойш 5 хоногийн дотор төлнө.
- 5.7. Хэрэглэгч нь ЦЭХ-ний бичилт хийснээс хойш 5 хоногийн дотор хэрэглэсэн ЦЭХ-ний төлбөрийг Хангагчийн харилцах дансанд шилжүүлнэ.
- 5.8. Хэрэглэгч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд төлөгдөөгүй үнийн дүнгээс хоног тутам 0,5 хүртэл хувьтай тэнцэх алдангийг Хангагчид төлнө.
- 5.9. Тухайн сард төлсөн төлбөрийг тооцохдоо өмнөх сард ногдуулсан алданги, хазайлтын төлбөрийг эхний ээлжинд төлснөөр тооцож зөрүүг тухайн сарын төлбөрт тооцно. ЦЭХ-ний хэрэглээ түдгэлзүүлсэн нь алдангиас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 5.10. Хэрэглэгч нь сард захиалсан эрчим хүчнээс ± 2 хувиас илүү буюу дутуу ЦЭХ хэрэглэсэн тохиолдолд /захиалга хэрэглээний зөрүү / Импортын цахилгаан эрчим хүчний графикийн хазайлтыг тооцох журмын дагуу хэрэглээний хазайлтын төлбөрийг төлнө.
- 5.11. Хангагчийн ашиглаж байгаа Тоолуурын хяналт удирдлагын систем, ДҮТ ХХК, ЦДҮС ТӨХК-ийн Тоолуурын системээс авсан параметрууд /гүйдэл, хүчдэл, идэвхтэй болон идэвхгүй чадал, cosφ гэх мэт/ болон тоолуурын заалтыг мөнгөн тооцоонд шууд хэрэглэнэ.
- 5.12. Хэрэглэгч нь захиалга өгч цахилгаан эрчим хүчнээс бүрэн салгуулсны дараа шугам трансформаторын алдагдлыг тооцохгүй;
- 5.13. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийдэг ажилтны буруугаас гарсан зөрүүг хангагч хэрэглэгч хамтран шийдвэрлэж дараа сарын тооцоонд тусгана.
- 5.14. Хэрэглэгч нь ЦЭХ-ний хэрэглээний тооцоог буруу гэж үзвэл тооцоо нийлснээс хойш хуанлийн 5 хоногийн дотор албан ёсоор мэдэгдэнэ. Хангагч хүсэлт хүлээн авснаас хойш хуанлийн 14 хоногийн дотор маргааныг хянаж шийдвэрлэх арга хэмжээ авна. Талууд хоорондоо зөвшилцөн шийдвэрлэж чадахгүйд хүрвэл гэрээний маргаан шийдвэрлэх хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.
- 5.15. Хэрэглэгч тоолуураас гадуур, хууль бусаар ЦЭХ хэрэглэсэн, тоолуур хэмжүүрийн трансформаторуудын битүүмжлэлийг алдагдуулсан, тоолуур гэмтээсэн тохиолдолд зохих нөхөн тооцоололт хийж, хууль, дүрэм, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ТООЛУУР ХЭМЖИХ ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

Тоолуурын № 201800047974 Гүйдлийн тр марк
 Тоолуурын марк CL730S11 Гүйдлийн тр баталгаат хугацаа
 Баталгаат хугацаа 2030-09-14 Хүчдэлийн тр марк
 Коэффициент Гүйдлийн тр лац А, В, С

Хэлхээнд тавьсан тоолуурын мэдээлэл	Хэлхээнээс авсан тоолуурын мэдээлэл
Тоолуурын № Тоолуурын марк Баталгаат хугацаа	Тоолуурын № Тоолуурын марк Баталгаат хугацаа

Тоолуур сольсон шалтгаан

Үнэ тариф

- 5.16. Цахилгаан зарцуулалтын төлбөрийн тооцоог Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос (ЭХЗХ) баталсан үнэ тарифаар хийнэ.
- 5.17. Үнэ тариф өөрчлөгдсөн тохиолдолд ЭХЗХ нь 15 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. Батлагдсан тогтоолын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн шинэчлэгдсэн тарифыг мөрдөнө. Мэдээлээгүй нь тус үнэ тарифыг мөрдөхгүй байх үндэслэл болохгүй.

ЗУРГАА. ХАНГАГЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. **Хэрэглэгч нь дараах эрх, үүрэгтэй**
 - 6.1.1. Стандартын шаардлагад нийцсэн цахилгаан эрчим хүчээр хангагдах;
 - 6.1.2. Цахилгаан эрчим хүчний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;
 - 6.1.3. Техник ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх;
 - 6.1.4. Эрчим хүчээр хангагчийн төлөөллийг үйл ажиллагаа явуулах боломжоор хангах;
 - 6.1.5. Эрчим хүчний тоолуур, хэмжүүрүүдийн бүрэн бүтэн байдал баталгаажуулалтыг хариуцах;
 - 6.1.6. Өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, засвар үйлчилгээг бүрэн хариуцах;
 - 6.1.7. Захиалсан эрчим хүчийг авахгүй болсон тохиолдолд хангагчид хуанлийн 7 хоногийн өмнө мэдэгдэх;
 - 6.1.8. Хангагчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах;
 - 6.1.9. Хангагчийн болон бусад байгууллагын эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах зардлыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй.
 - 6.1.10. Өөрийн эзэмшиж буй цахилгаан шугам сүлжээ, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг бүрэн хариуцах ба энэ ажлыг хариуцсан ажилтныг тусгайлан томилох;
 - 6.1.11. Хэрэглэгчийн хүсэлтээр захиалгат ажил болон тоног төхөөрөмжид гэмтэл саатал гарсан үед хангагч байгууллага засвар үйлчилгээ, гэмтэл устгах бүх төрлийн ажилд ашиглагч байгууллагын олгосон нарыдаар ажил гүйцэтгэнэ;
 - 6.1.12. Өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, хамгаалах багаж хэрэгсэлд ашиглалтын үеийн үзлэг үйлчилгээ, засвар, урьдчилан сэргийлэх ээлжит туршилтыг зохих норм, дүрмийн дагуу тогтоосон хугацаанд мэргэжлийн байгууллага, ажилтнаар хийлгэх;
 - 6.1.13. Хангагчаас зөвшөөрсөн хэрэглэгчийн сүлжээний горим болон реле хамгаалалт, автоматикийн тавил, хугацааг мөрдөх;
 - 6.1.14. Цахилгаан тоног төхөөрөмжийн байрыг аваар ослоос урьдчилан сэргийлэх галын анхан шатны тоног төхөөрөмж, гал түймэр эсэргүүцэх багаж хэрэгслээр тоноглогдсон байх;
 - 6.1.15. Хангагчийн нэвтрүүлж буй шинэ дэвшилтэт техник технологитой уялдан ажиллах тоноглол, хэмжих хэрэгслээр өөрийн тоноглолыг шинэчлэх;
 - 6.1.16. Цахилгаан тоног төхөөрөмж хариуцсан ажилтныг хамгаалах багаж хэрэгсэл, угсралт, ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, гарын авлагаар хангаж, холбогдох сургалтад хамруулсан байх;
 - 6.1.17. Цахилгаан станц, шугам сүлжээнд аваар гарсан тохиолдолд ачаалал бууруулах талаар өгсөн хангагчийн шийдвэрийг шууд биелүүлэх;
 - 6.1.18. Хангагчийн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, тавьсан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлэх;
 - 6.1.19. Хангагчийн шаардлагаар ачааллын хэмжилт хийж дүнг мэдээлж байх;
 - 6.1.20. Хэрэглэгч нь жил бүрийн 07-р сарын 20-ны дотор дараа жилийн ЦЭХ-ний хэрэглээ/кВт.ц/, чадлын захиалга /МВт/-ыг сар, улирлаар хуваарилан тарифын ангиллаар ± 2 /хоёр/ хувиас илүүгүй зөрүүтэй төлөвлөн гарын үсэг, тамга тэмдэг бүхий баталгаажуулан ирүүлэх;
 - 6.1.21. Хэрэглэгч нь "Импортын цахилгаан эрчим хүчний графикайн хазайлтын журам"-д заасны дагуу өмнөх сарын 15-ны дотор дараа сарын хэрэглээний захиалгаа тодотгож өгөх;
 - 6.1.22. Хэрэглэгч нь хэрэглээний захиалгад тодотгол хийгээгүй, хийсэн боловч өмнөх сарын 15-ны өдрөөс хойш ирүүлсэн тохиолдолд тодотгох боломжгүй;
 - 6.1.23. Өөрийн эзэмшлийн цахилгаан шугам, дэд станц, хуваарилах байгууламж, цахилгаан тоног төхөөрөмж болон тэдгээрийн холболтууд, дотоод холболт /монтаж/, оруулгын кабель, шит, цахилгаан хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах;
 - 6.1.24. Хэрэглэгч нь дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай дамжуулагч, түгээгч, хангагчид шуурхай мэдээлж байх
 - а/ тооцооны хэмжих хэрэгсэлд эвдрэл, гэмтэл гарсан буюу гарч болзошгүй болсон
 - б/ тэжээлийн шугам таслагдан хүчдэлгүй болсон, цахилгаан гүйдэлд хүн, амьтан нэрвэгдсэн буюу нэрвэгдэх нөхцөл бүрдсэн
 - в/ хэрэглэгчийн нутаг дэвсгэр, орчин тойронд орших хангагчийн мэдлийн цахилгаан тоног төхөөрөмжид гэмтэл гарсан буюу гарч болзошгүй болсон
 - 6.1.25. Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг хэрэгжүүлж, өөрийн эзэмшлийн газарт байгаа цахилгаан тоног төхөөрөмжийг хамгаалах, тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, дэд станц, кабелийн болон агаарын шугамын хамгаалалтын зурваст газар шорооны болон бусад ажлыг хангагчийн зөвшөөрөлгүйгээр хийлгэхгүй байх;
 - 6.1.26. Бусад хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдаж, учирсан хохирлыг хангагч төлсөн тохиолдолд буруутай хэрэглэгч уг төлбөрийг хангагчид төлөх;

- 6.1.27. Өөрийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээ, дэд өртөөнд байгаа цахилгаан тоног төхөөрөмжид засвар хийхдээ сүлжээнээс таслах, сүлжээнд залгахыг хангагч, түгээгч байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэх;
- 6.1.28. Төрийн ёслол, олон улсын шинжтэй уулзалт, тэмцээн зэрэг арга хэмжээг тодорхой хугацаанд зохион явуулах үед цахилгаан хангамжийн найдвартай байдлыг онцгойлон анхаарах шаардлага гарвал 3-аас доошгүй хоногийн өмнө хангагчид албан ёсоор мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх. Мэдэгдээгүйгээс үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй;
- 6.1.29. Улирлын шинжтэй ажилладаг хэрэглэгч цахилгаан тоног төхөөрөмжид хангагчаар үзлэг хэмжилт хийлгэн шалгуулсны үндсэн дээр сүлжээнд залгуулах;
- 6.1.30. Хэрэглэгч нь тооцооны эзэмшлийн зааг дээр байгаа тоолуур хэмжих хэрэгслийн ажиллагааг хянах;
- 6.1.31. Шаардлагатай тохиолдолд тоолуурын заалт харах;
- 6.1.32. Хангагч байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээ, харьцааны талаар санал гомдол хүлээн авах утас, Хэрэглэгчийн Үйлчилгээний Төв болон Салбарын утсанд мэдээлэх;
- 6.1.33. Цахилгаан хангамжийн найдваржилтыг дээшлүүлэх хүсэлтээ хангагчид тавих эрхтэй бөгөөд сайжруулахад шаардлагатай зардлыг /тооцоо, зураг төсөл, төсвийн дагуу хийх ажлын зардал/ хэрэглэгч өөрөө хариуцна.
- 6.1.34. Хангагчийн эрх бүхий ажилтны ажил гүйцэтгэх үед аюулгүй байдлыг өөрийн эзэмшлийн лиценз, зөвшөөрлийн талбай, үйлдвэрлэл, үйл ажиллагааны бүсэд бүрэн хангах;
- 6.1.35. Хангагчаас шалтгаалсан цахилгаан эрчим хүчний тасалдал болон чанарын шаардлага хангаагүй цахилгаан эрчим хүчээр хангасан тохиолдолд хангагчийн диспетчерт 1 цагийн дотор шуурхай мэдээлэх. Энэ үүргээ биелүүлээгүйгээс үүдэх хохирлыг хангагч хариуцахгүй.
- 6.1.36. Хэрэглэгч нь богино залгааны гүйдэл, реле хамгаалалтын тавилын тооцоонд шаардлагатай өөрсдийн эзэмшлийн тоноглолын мэдээллийг үнэн зөв гаргасан байна. Мэдээллийг дутуу эсвэл буруу өгснөөс үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй;
- 6.1.37. Тооцооны хэмжих хэрэгсэлд эвдрэл, гэмтэл гарсан буюу гарч болзошгүй болсон, тэжээлийн шугам тасарч хүчдэлгүй болсон, цахилгаан гүйдэлд хүн амьтан нэрвэгдсэн буюу нэрвэгдэх нөхцөл бүрдсэн, хэрэглэгчийн нутаг дэвсгэр ойр орчинд хангагчийн мэдлийн цахилгаан дамжуулах шугам, дэд станц, тоног төхөөрөмжид гэмтэл гарсан буюу гарч болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд хангагчид шуурхай мэдээлж байх;
- 6.1.38. Хамгаалалтын зурваст дур мэдэн хашаа хороо барих, барилга байшингаа тэлж өргөжүүлэх, шинээр барих зэрэг зөрчлийг гаргахгүй байх. Хамгаалалтын зурвасын дотор үйл ажиллагаа зөвшөөрөлгүй явуулсан тохиолдолд зөрчлийг устгатай цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлэх, цаашлаад гэрээг цуцлах арга хэмжээг хангагчийн эрх бүхий ажилтан авч хэрэгжүүлнэ.
- 6.1.39. Нутаг дэвсгэртээ байрлаж байгаа дэд өртөө, хуваарилах байгууламж, шугам сүлжээнд сэлгэн залгалт, үзлэг үйлчилгээ, засвар хийхээр ирсэн хангагчийн ажилтныг ямар ч үед саадгүй оруулах;
- 6.1.40. Улирлын шинж чанартай ажилладаг хэрэглэгч цахилгаан тоног төхөөрөмждөө хангагчаар үзлэг хэмжилт хийлгэн шалгуулсны үндсэн дээр сүлжээнд залгуулах;
- 6.1.41. Эрх бүхий байгууллагаас олгосон техникийн нөхцөл шаардлагын дагуу холбогдоогүй, хүчин чадлыг дур мэдэн нэмэгдүүлснээс эрчим хүч түгээх, хангах байгууллагад хохирол учруулсан бол хохирлыг барагдуулах үүрэгтэй. Хохирол барагдуулах шаардлагыг биелүүлээгүй бол эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 6.1.42. Өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжид засвар үйлчилгээг Хангагчаар хийлгэсэн тохиолдолд батлагдсан үнэлгээний дагуу төлбөр төлөх;
- 6.1.43. Урьд авсан техникийн нөхцөлийг хэрэглээ өсгөхөөр өөрчилж, цахилгааны ачааллыг нэмж сүлжээнд залгах болсон тохиолдолд энэ тухайгаа хангагчид урьдчилан мэдэгдэж шинээр техникийн нөхцөл авч гэрээг шинэчлэн байгуулах;
- 6.1.44. Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэмд заасны дагуу реактив чадлыг зохицуулах техникийн боломжийг шийдвэрлэх;
- 6.1.45. Хэрэглэгч нь шугам тоноглолд засвар үйлчилгээ хийх болон гэмтэл устгах үеийн таслалтын захиалгыг, захиалга өгөх эрх бүхий хүмүүс Хангагчийн диспетчерт ажлын 3 хоногийн өмнө холбогдох журмыг баримтлан ирүүлэх;
- 6.1.46. Ачааллын горимд өөрчлөлт орох тохиолдолд Хангагчид мэдээлэх;
- 6.1.47. Хэрэглэсэн ЦЭХ-ний хэрэглээний тооцоог гэрээнд заасан хугацаанд Хангагчид төвлөрүүлэх;
- 6.1.48. Компанийн нэр, эзэмшигчийн нэр, хаяг, утас, цахим шуудангийн хаяг, харилцах дансны дугаараа өөрчлөх мөн бүтцийн өөрчлөлт хийх бол энэ талаар Хангагчид мэдэгдэж гэрээг шинэчилнэ. Мөн техникийн нөхцөлийг шинэчлэн гаргах ба Дамжуулах ТЗЭ-ийн тоноглолоос тэжээгдэж байгаа бол Дамжуулах ТЗЭ-ээс, Түгээх ТЗЭ-ийн тоноглолоос тэжээгдэж байгаа бол Түгээх ТЗЭ-ээр техникийн нөхцөлийг гаргуулна. Мэдэгдээгүйгээс үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй.
- 6.1.49. Эрчим хүчний тухай хуулийн 32.2 дахь хэсэгт заасны дагуу ЦЭХ-ний хэрэглээгээ түдгэлзүүлсэн тохиолдолд ЦЭХ-ийг сэргээхдээ батлагдсан тарифын дагуу төлбөр төлнө.
- 6.1.50. Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас Хангагч болон бусад хэрэглэгчдэд хохирол учруулсан бол хохирлыг акт үйлдэж баталгаажуулан төлөх;
- 6.1.51. Өөрийн шугам, дэд станц, цахилгаан тоног төхөөрөмжид хангагчийн диспетчерийн зөвшөөрөлгүй сэлгэн залгалт хийснээс үүдэн гарах хохирлыг бүрэн хариуцах;

- 6.1.52. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээ, дэд станц, тоног төхөөрөмжийн ашиглалтыг бүрэн хариуцаж эргүүл үзлэг, шалгалт, засвар үйлчилгээ, аянгын улирлын өмнөх бэлтгэл ажил, өвөл зуны их бага ачааллыг давах бэлтгэлийг техник ашиглалтын дүрмийн дагуу мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлэх;
- 6.1.53. Өөрийн эзэмшлийн шугам дэд станц, тоноглолын ашиглалтыг хариуцах ажилтныг томилон, туршиж, ашиглахыг зөвшөөрсөн хамгаалах багаж хэрэгсэл, угсралтын болон техник ашиглалтын, аюулгүй ажиллагааны дүрэм, ашиглалтын заавар, гарын авлагаар бүрэн хангаж ажиллуулах;
- 6.1.54. Өөрийн эзэмшлийн шугам тоноглолд хэт хүчдэлийн хамгаалалт, гүйдэл ихсэлтийн, хэт ачааллын, хүчдэл ихсэлт бууралтын, фаз 0 тасралт, фазын дараалал алдагдлаас сэргийлсэн тоноглол болон хэрэглэгчид ашиглагдах цахилгаан тоног төхөөрөмжийн онцлогоос шалтгаалсан реле хамгаалалтаар тоноглож хамгаалах;
- 6.1.55. Хэрэглэгчийн эзэмшлийн шугам тоноглолд гарсан гэмтэл нь хангагчийн болон бусад хэрэглэгчийн түгээх сүлжээнд аваар саатал гарах шалтгаан нөхцөл болсон бол хариуцлага, хохирлыг хүлээх;
- 6.1.56. Реактив чадлын зохицуулалт хийх техникийн боломжийг шийдвэрлээгүйгээс системийн (дэд станц, хуваарилах байгууламж дээр) чадлын коэффициент буурсан тохиолдолд хариуцлагыг хүлээж журмын дагуу төлбөр төлөх;
- 6.1.57. "Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль"-д заасны дагуу эрчим хүч хэмнэх, үр ашигтай хэрэглэх, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх боломж, нөхцөлүүдийг судалж хэрэгжүүлэх;
- 6.1.58. Эрчим хүчний системийн оргил ачаалалын цагуудад 17.00 цагаас 22.00 цагийн хооронд хэрэглээгээ 30% хүртэл бууруулах үүрэгтэй.
- 6.2. **Хангагчийн эрх, үүрэг**
- 6.2.1. Стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах;
- 6.2.2. Эрчим хүчний төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид 24-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэх;
- 6.2.3. Гэрээнд заасан хугацаанаас эхлэн эрчим хүчээр хангах;
- 6.2.4. Эрчим хүчийг тасалсан шалтгаан арилсан даруй эрчим хүчний хангамжийг холбогдох журам, зааврын дагуу сэргээх;
- 6.2.5. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан ажил, үүргийн шаардлагаар хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, энэ зорилгоор орон байранд нэвтрэх;
- 6.2.6. Хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийн хэрэглээг түдгэлзүүлэх, алданги тооцох, эрчим хүчээр хангах гэрээг цуцлах;
- 6.2.7. Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах;
- 6.2.8. Эрчим хүч хэрэглэсний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол цахилгаан хангамж түдгэлзүүлэх;
- 6.2.9. Эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан тохиолдолд цахилгаан хангамжийг түдгэлзүүлэн нөхөн тооцоолол хийх;
- 6.2.10. Хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хэрэглээний хүрээнээс өөр хэрэглэгчийг эрчим хүчээр хангасан тохиолдолд цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх;
- 6.2.11. Байгалийн гамшиг/аянга цахилгаан, гал түймэр, аадар бороо, мөндөр, газар хөдлөлт, хүчтэй салхи, мөстөлт гэх мэт/, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн, түлшний хомсдол бий болсон, эрчим хүчний хангамжид осол, саатал гарсан, хүний амь нас, эд хөрөнгөнд аюул учрах, гал түймэр гарах нөхцөл үүссэн, эрчим хүчний систем нь чадлын дутагдал орж хязгаарлалтанд орох тохиолдолд цахилгаан хангамжийг урьдчилан мэдэгдэлгүйгээр түдгэлзүүлэх;
- 6.2.12. Хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийг шалгах, үзлэг хийх эрх бүхий Хангагчийн томилсон ажилтнуудын үйл ажиллагаанд саад учруулсан бол цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх;
- 6.2.13. Хэрэглэгчийн эзэмшлийн цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмж нь техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрэмд заагдсан шаардлагыг хангаагүй, хүн, амьтанд аюул учруулах, гал түймэр үүсгэх байдалд хүргэсэн тохиолдолд цахилгаан хангамжийг таслах;
- 6.2.14. Эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөлийг зөрчсөн тохиолдолд цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх;
- 6.2.15. Гэрээгээр тогтоосон цахилгаан чадлыг хэтрүүлсэн бол цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх;
- 6.2.16. Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох;
- 6.2.17. Эрчим хүчний тухай хууль тогтоомжид заасан, орон нутгийн удирдлага, мэргэжлийн хяналтын болон хуулийн байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гэрээнд заагаагүй нөхцөл, шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлахгүй байх;
- 6.2.18. Хангагч нь Хэрэглэгчийн цахилгаан зарцуулалтад тооцоо хийх эрх бүхий ажилтныг томилох;
- 6.2.19. Цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг сайжруулах, гэмтэл, зөрчлийг арилгах талаар Хангагчийн эрх бүхий хүмүүсийн шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд цахилгаан хангамжийг түдгэлзүүлэх;
- 6.2.20. Хангагч нь гэрээний үүргээ биелүүлээгүй Хэрэглэгчид Эрчим хүчний тухай хууль тогтоомжийг үндэслэн нөхөн бичилт хийх, алданги торгууль тавих, зөрчлийг арилгах хугацаагаар ЦЭХ-ийг түдгэлзүүлэх, гэрээг цуцлах;
- 6.2.21. Тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуурын битүүмжлэлийг шалгаж, шинэчлэн сэргээх;
- 6.2.22. Хангагч нь энэхүү гэрээнд заасан эрхийнхээ дагуу Хэрэглэгчийн ЦЭХ-ний хэрэглээг түдгэлзүүлэхэд хүрвэл Хэрэглэгчид 24 цагийн өмнө мэдэгдэл өгнө. ЦЭХ-ний хэрэглээ түдгэлзүүлснээс үүсэх эдийн засгийн болон техник, технологийн үйл ажиллагаатай холбоотой бүх хохирлыг хангагч хариуцахгүй.

- 6.2.23. Хэрэглэгч нь ЦЭХ-ний төлбөрөө төлөөгүй тохиолдолд таслалт, хязгаарлалтыг Эрчим хүчний тухай хууль, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм болон Нэгдсэн сүлжээний дүрэмд заасны дагуу гүйцэтгэх. Энэхүү таслалт, хязгаарлалттай холбогдон гарах зардлыг Хэрэглэгчээс нэхэмжлэн авах;
- 6.2.24. Хангагч нь гэрээнд заасан хугацаанд ЦЭХ-ний төлбөрөө төлж барагдуулаагүй, хугацаа хэтэрсэн хэрэглэгчийн хангагдаж буй шугам тоноглолыг хураах;
- 6.2.25. Хангагч нь Хэрэглэгчийн тооцооны тоолуур ЦЭХ-ний балансжилтанд хяналт тавьж гүйдлийн трансформаторыг ачаалалд нь тохирсон нарийвчлал өндөртэйгээр солихыг шаардах;
- 6.2.26. Цахилгаан тоног төхөөрөмжийн реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмжүүдийн хугацааны барил, тавил нь техникийн нөхцөлийн байгаа эсэхийг шалгах, техникийн нөхцөлд заагдсанаас өөрөөр тохируулсан бол гарах хохирлыг хэрэглэгчид хариуцуулж, техникийн нөхцөлийн заалт болон цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм зөрчсөн, туршилтад тэнцээгүй шугам тоноглолыг хүчдэлд залгахгүй байх;
- 6.2.27. Хэрэглэгчийг өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа тоног төхөөрөмждөө засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс Хангагч болон бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх;
- 6.2.28. Техникийн болон улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар биелүүлж хангагчид албан бичгээр мэдэгдээгүй бол цахилгаан эрчим хүч түдгэлзүүлэх;
- 6.2.29. Хангагчийн эрх бүхий ажилтны хуулийн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд цахилгаан эрчим хүч түдгэлзүүлэх;
- 6.2.30. Хэрэглэгчийн мэдээллийн нууцыг хуульд зааснаас бусад тохиолдолд нууцлах;
- 6.2.31. Хангагчийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам тоноглолд ноцтой гэмтэл гарсан үед Эрчим хүчний тухай хуулийн 6.1.4-т заасан журмыг баримтлан Хэрэглэгчийн ЦЭХ-ний хангамжийг зохицуулна.

ДОЛОО . ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

- 7.1. Хэвийн болон Аваарын горимын үед цахилгаан эрчим хүчний хүчдэл, давтамжийн хэлбэлзлийн хязгаар нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, техник ашиглалтын дүрэм болон нэгдсэн сүлжээний дүрэмд заасан хэм хэмжээнд байгаа тохиолдолд стандартын шаардлага хангасан эрчим хүч гэж үзнэ.
- 7.2. Хангагч нь дараах стандартуудыг мөрдлөг болгон ажиллана.
 - 7.2.1. Цахилгаан сүлжээ, хэвийн хүчдэл MNS 1500:82;
 - 7.2.2. Стандарт хүчдэл MNS IEC 196:2001;
 - 7.2.3. Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага MNS 5872:2019;

НАЙМ . ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

- 8.1. Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 5.1-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж, гэр, байр, граж, агуулахын цахилгаан сүлжээний дотоод холболт, гэр байшингийн оруулгын кабель, давхрын шитны монтаж болон цахилгаан хэрэгслийн ашиглалт, бүрэн бүтэн байдал, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх /гал түймэр эсэргүүцэх тоноглолоор тоноглох/ шаардлагуудыг бүрэн хариуцах үүрэгтэй.
- 8.2. Цахилгааны утасыг хэрэглэгч өөрийн ачаалалдаа тохируулан сонгож авах ёстой. Хангагчаас техникийн нөхцөл олгосон бол техникийн нөхцөлд заасан хөндлөн огтлол бүхий дамжуулагчийг сонгоно.
- 8.3. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шатдаг бараа материал, эд зүйл, задгай агуулахын дээгүүр татах, шатдаг материалаар хийгдсэн дээвэр дээр дамнуулан татахыг хориглоно.
- 8.4. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, хөдөлгүүр, цахилгаан дамжуулах утсыг орчны нөхцөл, үйлдвэрийн галын болон тэсрэх аюулын зэрэгт тохируулан сонгон хэрэглэнэ.
- 8.5. Барилгад цахилгаан дамжуулах утсыг ил татахдаа механик гэмтэл учирч болох хэсгүүдэд төмөр хоолой болон нэмэлт хамгаалалт хийнэ.
- 8.6. Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглах үед дараах зүйлийг хориглоно.
 - а. Цахилгаанаар халах хэрэгслийг шатдаг материалаар хийсэн суурьтай ашиглах, хяналтгүй орхих.
 - б. Барилга байгууламжийг халах зорилгоор стандарт бус цахилгаан зуух, бусад төхөөрөмж ашиглах.
 - в. Цахилгаан гүйдэл бүхий кабель шугам, дамжуулах утасны хамгаалалтгүй үзүүрийг ил орхих.
 - г. Гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглах.
 - д. Цахилгаан дамжуулах утсыг хадаасаар бэхлэх, хаалганы хавтасны завсараар гаргах, цахилгааны утас, унтраалгаас эд зүйл өлгөх.
 - е. Цахилгааны хянах самбар, цахилгаан хөдөлгүүр, асааж унтраах аппаратын дэргэд шатамхай (хялбар авалцан асах) бодис, материал байрлуулах, хураах.
- 8.7. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн сүлжээ, кабель утас, цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дотоод холболт монтажны галын аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэн гарсан хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийн хохирлыг хангагч байгууллага хариуцахгүй.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1. Талууд нь харилцан тохиролцон байгуулсан гэрээний үүрэг, хариуцлагыг бүрэн хүлээнэ. Гэрээний биелэлтийг талууд жилээр дүгнэж акт протокол үйлдэнэ.
- 9.2. Гэрээний дагуу хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагыг биелүүлж үйлдвэрлэл явуулахад шаардагдах техникийн нөхцөл, зөвшөөрөл, шийдвэрийг Хангагч нь зохих дүрэм, журмын дагуу олгоно.
- 9.3. Хангагч нь эрчим хүчний төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид 24-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ.
- 9.4. Хангагч нь чадлын дутагдалд орж, Хэрэглэгчийг чанарын үзүүлэлтээр шаардлага хангахгүй ЦЭХ-ээр хангасан тохиолдолд Хэрэглэгч нь цаг алдалгүй мэдэгдэж, Хангагч нь горимын болон ачааллын зохицуулалт хийнэ.
- 9.5. Зайлшгүй нөхцөл, шаардлагын дагуу Хэрэглэгчийн үйлдвэр нь түр хугацаагаар зогсох болсон тохиолдолд Хэрэглэгч нь Хангагчид мэдэгдэнэ. Хэрэглэгчийн үйл ажиллагааны түр зогсолт нь энэхүү гэрээний бусад заалтыг хүчингүй болгохгүй.
- 9.6. Хангагч нь энэхүү гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээллийг авах хүсэлт тавихад Хэрэглэгч цаг тухай бүрд нь гаргаж өгнө.
- 9.7. Хэрэглэгч өөрийн буруутай үйлдэл /хангагчийн төлөөлөгчийг хэл амаар доромжлох, заналхийлэх, биед халдах, ЦЭХ-ийг зүй бусаар хэрэглэх, хангагчийн өмчлөлд дүр мэдэн халдах гэх мэт/, өөрийн эзэмшлийн гэрийн тэжээвэр амьтдыг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хангагчид хохирол учруулсан бол холбогдох хууль, дүрмийн дагуу хохирлыг хэрэглэгч хариуцна.
- 9.8. Энэхүү гэрээний 9.11-т зааснаас бусад тохиолдолд талуудын шугам тоноглолд гарсан аваар саатлын улмаас ЦЭХ тасалсан, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс Талуудын аль нэгэнд учирсан шууд хохирлыг Талууд 5 хоногийн дотор хамтран актаар тогтооно.
- 9.8.1. Дамжуулах сүлжээнд шууд холбогдсон Хэрэглэгчийн хувьд 3 тал (Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч)-ын хамтарсан акт үйлдэнэ. Актад ЦЭХ-ээр тасалсан, хэлбэлзсэн огноо, хугацаа, шалтгаан, үйлдвэрлэл үйлчилгээнд учруулсан шууд хохирлын хэмжээг тодорхой бичиж удирдлагуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 9.8.2. Хэрэглэгчийн шугам тоноглолоос дамжуулан тэжээгдэж байгаа хэрэглэгчийн хувьд хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, дамжуулан түгээж байгаа хэрэглэгч, хэрэглэгчийн шугам тоноглолоор дамжуулан хангагдаж байгаа хэрэглэгч нар хамтарсан акт үйлдэнэ. Актад ЦЭХ-ээр тасалсан, хэлбэлзсэн огноо, хугацаа, шалтгаан, үйлдвэрлэл үйлчилгээнд учруулсан шууд хохирлын хэмжээг тодорхой бичиж удирдлагуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 9.9. Талуудын аль нэг нь гарын үсэг зураагүй акт нь хохирлыг нөхөн төлөх үндэслэл болохгүй. Хохирлыг 1 сарын дотор буруутай тал нь хариуцан барагдуулна.
- 9.10. Шууд хохиролд Монгол улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор баталсан Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2-д заасны . ЦЭХ хэрэглэх дүрмийн 10.1-д заасан актыг ажлын 5 хоногийн дотор гаргаж, актад цахилгаан эрчим хүч тасалдсан, хэлбэлзсэн он, сар, өдөр, үргэлжилсэн хугацаа, шалтгаан, үйлдвэрлэл, үйлчилгээнд учруулсан шууд хохирол (цахилгаан хангамж тасалдсан, чанарын үзүүлэлт хэлбэлзсэнээс хэрэглэгчид учирсан бүтээгдэхүүний чанарын гологдол, цахилгаан хэрэгслийн гэмтэл)-ын хэмжээ, хангагч, хэрэглэгчийн төлөөлөгчийн нэр, албан тушаалыг тодорхой тусгаж, гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
- 9.11. ЦЭХ-ний тасалдлаас учирсан хохирлыг дор дурдсан тохиолдолд Хангагч хариуцахгүй.
- 9.11.1 Байгалийн гэнэтийн аюул /аянга, салхи, шуурга, мөстлөг, аадар бороо, мөндөр, үер, гал түймэр, газар хөдлөлт гэх мэт/;
- 9.11.2 Гэнэтийн хүчин зүйл / дайн байлдаан, ажил хаялт, өлсгөлөн, нийтийг хамарсан үймээн гэх мэт/
- 9.11.3 Хангагчтай тохиролцсон горимыг Хэрэглэгч мөрдөөгүйгээс Хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан бол;
- 9.11.4 Хэрэглэгч нь цахилгаан хангамжийн найдваржилтын зэрэглэлийн шаардлагыг хангаагүйн улмаас бэлтгэл тэжээл болон нөөц эх үүсгүүр залгадаагүй буюу бэлтгэл тэжээл, нөөц эх үүсгүүргүй бол;
- 9.11.5 Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч (Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК)-ийн эзэмшлийн 220/110/35/10/6 кВ дэд станц болон 220,110 кВ цахилгаан дамжуулах шугам болон Үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоноглол дээр гэмтэл гарсан, цахилгаан эрчим хүчний параметрууд хэлбэлзэн, реле хамгаалалт ажилласан бол;
- 9.11.6 Реле хамгаалалт ажиллаж таслуурыг тасалсан боловч автоматаар дахин залгагч төхөөрөмжөөр залгагдсанаас үүдэн хэрэглэгчийн реле хамгаалалтын төхөөрөмжүүд ажиллаж системээс өөрийгөө тусгаарласан бол;
- 9.11.7 Нэгдсэн сүлжээний бүрэлдэхүүн цахилгаан станцууд 0 зогсолт хийсэн болон ОХУ-н системээс Төвийн эрчим хүчний систем тусдаа ажиллаж чадлын дутагдалд орж, Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч хязгаарлалт хийсэн тохиолдолд;
- 9.11.8 ДҮТ ХХК, ДДЦС ТӨХК болон Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шуурхай ажиллагааны хүмүүс, техникийн удирдах ажилтнуудын буруутай үйл ажиллагаа, шийдвэрээс болон тоног төхөөрөмжийн гэмтлээс шалтгаалан тасралт саатал гарсан бол;
- 9.11.9 Эрчим хүчний тухай хуулийн 29.1.2, 32.2-т заасны дагуу Хэрэглэгчийн цахилгаан хангамжийг түдгэлзүүлсэн;
- 9.11.10 Хэрэглэгчийн цахилгаан дамжуулах шугам, тоноглолыг гуравдагч этгээд гэмтээж эрчим хүчээр тасалдуулсан;
- 9.11.11 Хүний амь нас, цахилгаан тоноглолд илэрхий аюултай байдал үүссэн тохиолдолд урьдчилан мэдэгдэлгүйгээр цахилгаан эрчим хүч гэнэт тасалсан бол;

- 9.11.12 Системийн реле хамгаалалт болон, автоматикийн төхөөрөмжүүдийн ажилласнаас болж ЦЭХ-р тасалдуулсан;
- 9.11.13 Бусад зэрэгцээ ажиллаж буй томоохон хэрэглэгчийн хэрэглээ гэнэт зогссоноос системд савлалт үүссэн үед;
- 9.11.14 Шугам тоноглол реле хамгаалалтаар тасарч автоматаар дахин залгагч төхөөрөмж (АПВ) ажилласан;
- 9.11.15 ОХУ-ын эрчим хүчний системийн үйл ажиллагаанаас хамаарч төвийн эрчим хүчний систем тусдаа ажиллаж буй нөхцөлд чадлын дутагдал үүсэж Диспетчерийн үндэсний төвийн диспетчерийн шийдвэрээр эх үүсвэрээс хязгаарлалт хийсэн тохиолдолд;
- 9.11.16 Хангагч нь өөрийн эзэмшлийн шугам, тоноглолыг бүрэн хүчин чадлаар болон хэт ачаалуулж ажиллаж байгаа хэдий ч чадлын дутагдал үүсч аваарын үед мөрдөх таслалт, хязгаарлалтын графикийн дагуу Хэрэглэгчийн зэрэглэлээр хязгаарлалтад орсон тохиолдолд;
- 9.11.17 Системийн давтамж буурахад аваар эсэргүүцэх автоматаар буюу АЧР-ийн тавилд хүрч тасран хязгаарлалтад орсон тохиолдолд;
- 9.11.18 Хэрэглэгч Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм зөрчсөн;
- 9.11.19 Хэрэглэгч нь реактив чадлын зохицуулалт хийх техникийн боломжийг шийдвэрлээгүйгээс чадлын коэффициент 0,9 -аас доош орсноос үүдэн таслалт хийсэн бол;
- 9.11.20 Техникийн нөхцлийн дагуу холболт хийгээгүй бол;
- 9.11.21 Хангагчаас тогтоож өгсөн реле хамгаалалтын тавилыг мөрдөөгүй бол;
- 9.11.22 ОХУ-ын Буриадын эрчим хүчний систем, Төвийн эрчим хүчний системийн бүрэлдэхүүн эх үүсгүүр, цахилгаан дамжуулах агаарын шугам хамгаалалтаар тасарсан, засвар хийснээс болж хүчдэлийн уналт үүссэн тохиолдолд;
- 9.11.23 Техникийн нөхцлөөр олгосон хүчин чадлыг хэтрүүлсэн тохиолдолд ухаалаг тоолуур автоматаар тасарч хэрэглэгчийн цахилгаан хангамж тасарсан бол;
- 9.12 Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа тоног төхөөрөмждөө засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангагч болон бусад этгээдэд учруулсан хохирлыг төлнө.
- 9.13 Өөрийн эзэмшлийн шугам тоноглолд хэт хүчдэлийн хамгаалалт, гүйдэл ихсэлтийн, хэт ачааллын, хүчдэл ихсэлт бууралтын, фаз 0 тасралт, фазын дараалал алдагдлаас сэргийлсэн тоноглол болон хэрэглэгчид ашиглагдах цахилгаан тоног төхөөрөмжийн онцлогоос шалтгаалсан реле хамгаалалтаар тоноглож хамгаалах;
- 9.14 Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 33-р зүйлийг зөрчвөл хангагч хамгаалалтын зурвас дахь барилга байгууламжийг буулгуулж, зурвасыг чөлөөлүүлнэ.
- 9.15 Эрх бүхий байгууллагаас олгосон техникийн нөхцлийн шаардлагын дагуу холбоогүй, хүчин чадлыг дур мэдэн нэмэгдүүлснээс эрчим хүч дамжуулах, түгээх, хангах байгууллагад хохирол учруулсан, хохиролыг барагдуулах тухай шаардлагыг биелүүлээгүй нь нотлогдвол хангагч цахилгаан хангамжийг түдгэлзүүлнэ.
- 9.16 Хэрэглэгч нь Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм зөрчиж хамгаалах зурвасын дотор үйл ажиллагаа явуулах, оршин суух, хангагчийн эзэмшлийн гэмтэл гарсан сүлжээ, тоног төхөөрөмж, шитэнд дур мэдэн ойртох, хүрч шүргэснээс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал амьтан эрсдэх, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд хангагч байгууллага хариуцахгүй.
- 9.17 Талууд цаг агаарын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан ажиллах ба аваар гарсан тохиолдолд богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг авч ажиллах бөгөөд эрчим хүчний хангамжийг сэргээхэд шаардагдах хугацаа, залгалт хийж эхлэх цаг хугацааг харилцан шуурхай мэдээлж ажиллана.
- 9.18 Бусад хэрэглэгчийн эзэмшлийн шугам, тоноглолоор дамжуулан цахилгаан эрчим хүчээр хангагдаж байгаа хувьд
 - ✓ Эзэмшигч нь цахилгаан эрчим хүчний төлбөрөө төлөөгүйгээс түдгэлзүүлсэн
 - ✓ Эзэмшигчийн шугам тоноглол нь техникийн ашиглалтын шаардлага хангаагүйгээс мэдэгдэл өгч тасласан
 - ✓ Эзэмшигчийн шугам тоноглолд гэмтэл гарч цахилгаан хангамж таслагдсан
 - ✓ Эрх бүхий байгууллагаас шаардаж цахилгаан хангамжийг тасласан
 зэрэг болон бусад асуудлаас болж цахилгаан хангамж тасарсан, тасласан, түдгэлзүүлсэн тохиолдолд дамжуулан тэжээгдэж буй хэрэглэгчид гарсан хохиролыг хангагч байгууллага хариуцахгүй.

АРВАН . ГЭРЭЭГ ДҮГНЭХ, СУНГАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

- 11.1. Талууд нь жил бүр тооцоо нийлсэн акт үйлдэж цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоо, үлдэгдлийг баталгаажуулах ба жилийн хэрэглэх эрчим хүчний захиалга гүйцэтгэл, гэрээний биелэлтийг дүгнэнэ.
- 11.2. Гэрээний хүчинтэй байх хугацаа дуусахаас хуанлийн 20 хоногийн өмнө гэрээг сунгана.
- 11.3. Энэхүү гэрээний заалтууд нь талууд болон тэдний эрх шилжүүлэн авсан иргэн, хуулийн этгээдүүдэд нэгэн адил хамаарна.
- 11.4. Энэхүү гэрээний хавсралт №01, 02 нь гэрээний салшгүй хэсэг болно.

ХЭРЭГЛЭГЧИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ

1. Трансформаторуудын нийлбэр чадал 250 кВА
2. Тоног төхөөрөмжийн нийлбэр чадал кВт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Хүчин чадал /кВт/	Тоо ширхэг	Хоногт ажиллах цаг	Хоногийн хэрэглээ /кВт.ц/
1	Уух мотор	4	2	24	192
2	Гэрэл	0,1	24	8	19,2
3	Цахилгаан хөгжим	0,5	3	5	2,5
4	Караоке	1,1	2	5	11
5	Тайзны гэрэл	0,5	12	5	30
6					
7					
8					
9					
10					

Хавсралт №02

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ОНЫ ЗАХИАЛГА, ХЭРЭГЛЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭСЭН АКТ

Хугацаа /сар/	Хэрэглээ /м. кВт.ц/				
	Захиалга / кВт.ц/	Захиалганд оруулсан өөрчлөлт /кВт.ц/	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1 сар					
2 сар					
3 сар					
1-р улирал					
4 сар					
5 сар					
6 сар					
2-р улирал					
7 сар					
8 сар					
9 сар					
3-р улирал					
10 сар					
11 сар					
12 сар					
4-р улирал					
Жилийн дүн					

АРВАН НЭГ . МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 11.1. Талуудын хоорондын гэрээний эрх, үүргийн биелэлттэй холбоотой гарсан маргааныг харилцан зөвшилцөх за шийдвэрлэнэ.
- 11.2. Харилцан зөвшилцөж чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 11.3. Талууд нь гэрээг цуцлахаас бусад тохиолдолд шүүхийн шийдвэр гартал гэрээний дагуу хүлээсэн ү хариуцлагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Хангагч ЦЭХ-ээр хангаж, Хэрэглэгч хэрэглэсэн ЦЭХ-ний төлбөр тооцо үргэлжлүүлэн төлнө.
- 11.4. Хэрэв төлбөр тооцооны тодорхой хэсгийн талаар маргаан үүссэн бол шүүхийн шийдвэр гартал маргаангүй ба төлбөрүүдийг төлнө.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАНГАГЧ:

ДСЦТС ХК-ийн Сүхбаатар

Салбар, ХҮТ-ийн дарга



/ Э.Сувдаа /

Борлуулалтын мэргэжилтэн

/ Б.Отгонцэцэг /

Борлуулалтын ажилтан

/ Э.Баярсувд /

ХЭРЭГЛЭГЧ:

Соёлын төв -ийн эрхлэгч

албан тушаалтай



/ П.Болормаа /

Цахилгааны инженер, цахилгаанчин



Ня-бо

/ Б.Билэгмаа /

Талуудын албан ёсны хаяг:

ХАНГАГЧ:

Хаяг: ДСЦТС ХК-ийн Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
7 -р баг

Салбар, ХҮТ-ийн байр

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 7 -р баг

И-мэйл: contacts@dsedn.mn

Веб сайт: www.dsedn.mn/

Аппликейшн: Billcenter

Холбогдох утас: 72221010

Мессеж лавлагаа: 140015

ХЭРЭГЛЭГЧ:

УБГ-ний хаяг: Сэлэнгэ аймаг, Ерөө Тавин,

Үйл ажиллагаа явуулж буй газрыг хаяг:

Сэлэнгэ аймаг, Ерөө сум , Тавин, 1-р гудамж, Тоот 101

УБГ-ний № 1370002040

Регистрийн дугаар 3744574

E-mail: bolormaa9570@gmail.com

Website:

Утас: Эрхлэгч-99929570

Утас: Ня-бо-99676233

Утас: Цахилгаанчин

**БАТЛАВ**

ДАРХАН НЕФТЬ ХАНГАМЖИЙН
САЛБАРЫН ДАРГА
Б.ИДЭРЖАВХУЯН



ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ЗЭЭЛЭЭР НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

БАТЛАВ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Ф.БОЛОРМАА



2025 оны 01-р сарын 13-ны өдөр

№ 2025/к-23

Дархан-Уул аймаг

Энэхүү Газрын тосны бүтээгдэхүүн зээлээр нийлүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “НИК” ХХК /РД:2075261, УБД: ,УБД:9011250037/-г төлөөлж ахлах нягтлан бодогч албан тушаалтай Н.Содонцэцэг (цаашид “Худалдагч” гэх), нөгөө талаас Сэлэнгэ аймгийн Шаамар Ерөө сумын Соёлын төв /РД: 3744574/ төлөөлж нягтлан бодогч албан тушаалтай Б.Билэгмаа (цаашид “Худалдан авагч” гэх) бид (цаашид дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) Иргэний хуулийн 243-264 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү Гэрээг дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Гэрээний зорилго нь Худалдагч Гэрээнд заасан нөхцөлийн дагуу Монгол Улсын чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүн (цаашид “бүтээгдэхүүн” гэх)-ийг шатахууны карт ашиглан Худалдан авагчид дараа төлбөрт нөхцөлөөр нийлүүлэх, Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, тогтоосон хугацаанд бүтээгдэхүүний төлбөр, гэрээнд заасан хүүг төлөх, төлбөр төлөх хугацаа хожимдуулснаас тооцох алдангийн хэмжээ болон зээлээр бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдсон бусад бүхий л харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээ нь хүсэл зоригоо бүрэн илэрхийлж, сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд Талууд Гэрээний зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн уншиж танилцан, гарын үсэг зурж хүлээн зөвшөөрсөн болно.
- 1.3. Гэрээний хавсралтууд, Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг бөгөөд Гэрээний хамт хүчин төгөлдөр байна.
- 1.4. Гэрээг 2025 оны 01-р сарын 13-ны өдрөөс эхлэн 2026 оны 01-р сарын 13-ны өдөр хүртэл хугацаагаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Худалдагч нь Гэрээ байгуулсан тухайн сараас эхлэн бүтээгдэхүүнийг Худалдагчид дараа төлбөрт нөхцөлөөр, шатахууны картаар дамжуулан нийлүүлэх ба Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг Худалдагчийн Улаанбаатар хотын шатахуун түгээх станцууд болон зэргэлдээ компани болох “НИК” ХХК-ийн хөдөө, орон нутагт байрлах шатахуун түгээх станцууд (цаашид “ШТС” гэх)-аас өөрийн тээврийн хэрэгслээр авах бөгөөд бүтээгдэхүүний үнэ тухайн ШТС дахь жижиглэнгийн үнэ байна. Энэхүү үнэнд НӨАТ орсон болно.
- 2.2. Худалдагчаас нийлүүлж буй бүтээгдэхүүний зээлийн шугам буюу Худалдагчийн авлагатай байх нэг сарын дээд хэмжээ 900,000 (Есөн зуун мянган) төгрөг байх бөгөөд Худалдан авагч энэхүү хэмжээнд багтаан худалдан авна.
- 2.3. Нийлүүлсэн шатахууны тоо хэмжээ нь түгээгүүрийн мэдээлэлд зааснаар тодорхойлогдоно.

Худалдагч /гарын үсэг/

Худалдан авагч /гарын үсэг/



- 2.4. Гэрээний зүйлд хоёр тал харилцан тохиролцон өөрчлөлт оруулах тохиолдолд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээтэй адил журмаар баталгаажуулна.
- 2.5. Худалдан авагч бүтээгдэхүүн хүлээн авсан тухайн сарын сүүлийн ажлын өдөр тооцоо нийлж, тухайн сардаа багтаан төлбөрийг бүрэн төлж барагдуулна.
- 2.6. Гэрээний 2.5 дахь хэсэгт заасан хугацаанд бүтээгдэхүүний төлбөрт тооцох хүү 0 хувь байна.
- 2.7. Бүтээгдэхүүний төлбөрийг зөвхөн төгрөгөөр тооцох бөгөөд төлбөрийг бэлэн бусаар буюу Худалдагчийн данс руу шилжүүлнэ.
- 2.8. Худалдан авагч нь шатахууны худалдан авсан НӨАТ-тай үнийн дүнгээс 0 хувийн хөнгөлөлт эдэлнэ.
- 2.9. Худалдан авагч нь Гэрээний Хавсралт 2-д заасан Карт ашиглах зааврыг карт эзэмших өөрийн ажилтан тус бүрд танилцуулж, түүнийг мөрдүүлж ажиллана.
- 2.10. Картыг зээлээр цэнэглэж байгаа тохиолдолд, түгээлт тус бүрд шатахууны картыг уншуулах бөгөөд карт цэнэглэснээс илүү хэмжээгээр ШТС-аас зээл авах эрхгүй байна.
- 2.11. Худалдан авагч нь бүтээгдэхүүн хүлээн авах шатахууны ерөнхий дансны дугаарыг Хавсралт 1-д тусгана.
- 2.12. Худалдан авагчид хүлээлгэн өгсөн боловч үнэ нь төлөгдөөгүй байгаа бүтээгдэхүүний үнэ төлөгдөх найдваргүй гэж Худалдагч үзвэл уг бүтээгдэхүүнийг захиран зарцуулах эрхийг өөртөө шилжүүлэн авахыг шаардах эрхтэй ба Худалдан авагч үүнд саад хийх эрхгүй.
- 2.13. Хүлээн авсан боловч үнэ нь бүрэн төлөгдөөгүй байгаа бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээний бүрэн бүтэн байдлыг Худалдан авагч хариуцах ба аливаа үрэгдэл, дутагдал гарсан явдал нь бүтээгдэхүүний үнэ төлөх үүргээс Худалдан авагчийг чөлөөлөх буюу хөнгөлөх үндэслэл болохгүй.
- 2.14. Худалдагч нь Худалдан авагчид Хавсралт 1-д заасан ерөнхий дансыг энэхүү гэрээний 2.2-т заасан хэмжээнд багтааж Худалдан авагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу цэнэглэх бөгөөд Худалдан авагчид хүлээлгэн өгснөөс хойш эрсдэлийг хариуцахгүй.
- 2.15. Худалдан авагч шатахууны картын нууц дугаар алдагдах эрсдэлийг бүрэн хариуцна.

Гурав. Худалдан авагчийн эрх, үүрэг

- 3.1. Бүтээгдэхүүний төлбөрийг Худалдагчид энэхүү Гэрээний 2.5 дахь хэсэгт заасны дагуу хугацаа хэтрүүлэлгүй төлөх үүрэгтэй.
- 3.2. Худалдан авагч нь бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээг шалгаж, хүлээн авах үүрэгтэй.
- 3.3. Худалдан авагч бүтээгдэхүүн хүлээн авснаас хойш барааны чанар муудсан ба тоо хэмжээ өөрчлөгдөх, устах зэрэг бүх эрсдэлийг дангаар хариуцна.
- 3.4. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Худалдагчаас шаардах эрхтэй.
- 3.5. Хууль буюу Гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

Дөрөв. Худалдагчийн эрх, үүрэг

- 4.1. Худалдагч нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй Монгол Улсын чанар, стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг Худалдагчийн эзэмшлийн шатахууны картаар дамжуулан нийлүүлэх үүрэгтэй.
- 4.2. Худалдан авагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээний 5.1-т заасны дагуу алдангийн хэмжээг тооцон авах эрхтэй.
- 4.3. Худалдан авагч Гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Худалдан авагчийн барьцаалсан хөрөнгийг өөрийн эзэмшилд шилжүүлэн, захиран зарцуулах эрхтэй.
- 4.4. Худалдагч нь биет байдлын доголдолтой бүтээгдэхүүн нийлүүлсэн нь хүлээн авах явцад баримтаар илэрсэн тохиолдолд түүнтэй холбоотой бүх зардлыг бие даан хариуцаж доголдлыг арилгана.
- 4.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Худалдан авагчаас шаардах эрхтэй.
- 4.6. Худалдан авагчийн Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх тухай шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.



4.7. Хууль буюу Гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

Тав. Хариуцлага

- 5.1. Худалдан авагч нь Гэрээний 2.5 дахь хэсэгт заасан хугацаанд худалдан авсан бүтээгдэхүүний төлбөрийг төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-иар тооцож хоног тутам алдангийг төлнө.
- 5.2. Иргэний хуулийн 232.8 дахь хэсгийг үндэслэн, Талууд нөхцөл байдлыг үнэлсний үндсэн дээр гэрээгээр хүлээсэн үүргээ гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тал нь хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх алданги төлөхөөр тохиролцож, тэр хэмжээгээр нөгөө тал нь нэхэмжлэх, буруутай тал нь төлж барагдуулахаар хүлээн зөвшөөрч байгаа ба тохиролцсон алданги, тооцсон үнийн дүнгийн хэмжээний талаар аливаа маргаан үүсгэхгүй.
- 5.3. Гэрээний үүргээ гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй буруутай тал тийнхүү гүйцэтгээгүйгээс нөгөө талд учирсан бүх хохирол, зардал (хууль зүйн туслалцаа авсны төлбөр, нотариатын зардал, улсын тэмдэгтийн хураамж г.м)-ыг төлж барагдуулах үүрэгтэй.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

- 6.1. Талууд давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн нөхцлийн үр дүнд (гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн улмаас) хүлээсэн үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гүйцэтгээгүй хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөнө. Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл гэж онцгой нөхцөл байдлаар үүссэн нөхцөл буюу тэдгээрийг Талууд урьдчилан мэдэж таслан зогсоох боломжгүй (түймэр, үер, газар хөдлөлт буюу байгалийн бусад үзэгдэл болон дайн, бүслэлт, Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон арга хэмжээ, хорио цээр, бүх төрлийн хязгаарлалт, удаашрал, мөн үйлдвэрлэгч компаниас шалтгаалсан тасалдал, хомсдол, импортын хязгаарлалт г.м) ба эдгээр нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд саад учруулж байгаа нөхцөл байдалд тооцогдоно.
- 6.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тал нь нөгөө талдаа 3 хоногийн дотор мэдэгдэнэ. Мэдэгдэл нь факсаар, эрх бүхий ажилтны э-мэйлээр, шуудангаар илгээгдэж болох ба цаашид эх хувиараа хүргэгдэнэ. Мэдэгдсэн огноог шуудан, харилцааны огноогоор тооцно.
- 6.3. Талууд Гэрээний 6.1 дэх хэсэгт заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлөөс болоод үүргээ гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдалтай тулгарсан тухайгаа энэхүү зүйлд заасан аргаар мэдэгдээгүй бол гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлд үндэслэн хариуцлагаас чөлөөлөгдөх эрхээ алдана.
- 6.4. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас олгосон давагдашгүй хүчин зүйлийн баталгаа нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл бий болсны хангалттай нотолгоо болно.

Долоо. Гэрээ цуцлах, дуусгавар болгох

- 7.1 Гэрээний хугацаа дууссан, эсхүл аль нэг тал Гэрээг дуусгавар болгох тухай саналаа 1 /нэг/ сарын өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдсэний үндсэн дээр харилцан тохиролцсон бол гэрээг дуусгавар болгож болно.
- 7.2 Дор дурдсан нөхцөлд гэрээг цуцалж болно:
 - 7.2.1. Талуудын аль нэг тал Гэрээнд заасан үүргээ 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн бол;
 - 7.2.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл үүссэний улмаас Худалдан авагч нь 60 (жар)-аас дээш хоногийн хугацаанд Гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон;
 - 7.2.3. Худалдан авагч төлбөрийн чадваргүй болсон нь илт болсон.



- 7.3. Гэрээний 7.2-т зааснаар Гэрээг цуцалсан бол тийнхүү Гэрээг цуцлах өдрөөс өмнө Худалдагчийн нийлүүлсэн бүтээгдэхүүний үнийг Худалдан авагч төлөх үүрэгтэй.

Найм. Бусад

- 8.1. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт, хавсралт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талууд гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр болох ба энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 8.2. Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх ба тохиролцоонд хүрэхгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.3. Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа харилцан нэг нэгнийхээ эрхийг хүндэтгэж, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгын хэрэгжилтийг хангахын тулд өөрөөс шалтгаалах бүхий л зохистой арга хэмжээг авна.
- 8.4. Энэхүү гэрээ болон түүний хавсралтуудыг талууд нууцлан хадгалж хамгаалах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.
- 8.5. Энэхүү гэрээг 3 эх хувь үйлдсэн бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна.
- 8.6. Энэхүү гэрээнд талууд 2025 оны –р сарын –ны өдөр гарын үсэг зурж, баталгаажуулав.

Ес. Талуудын хууль ёсны хаяг:

Худалдагч:

Дархан-Уул аймаг Дархан
НХСалбар

Ахлах нягтлан бодогч
Н.Содонцэцэг

Утас: 9988-1273

Факс:

Цахим

cardcenter@petroviz.mn

шуудан:

Утас: 70110808

Факс: 330808

Данс:

ХХБ: - 429000747 /₮/

ХААН банк: - 5038058532 /₮/

Голомт банк: - 8115100989 /₮/

Хас банк:-5002009938/₮/

Төрийн банк:-343100204768/₮/

Худалдан авагч:



Утас: 99676233

Факс:



БАТЛАВ.



ЗАХИРАЛ

ХӨГЖИМ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар: 25109.1.29.02/46

Улаанбаатар хот

2025 оны 9 сарын 9 өдөр

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээг нэг талаас регистрийн 3744574 тоот дугаар бүхий Эрөө сумт Соёмто товчин дараа /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас улсын бүртгэлийн 90111040018, регистрийн 2741261 тоот дугаар бүхий Эгшиглэн Магнай ХХК түүнийг төлөөлж тус компанийг төлөөлж Т.С. Г. Байгалжав /цаашид гүйцэтгэгч гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2025 оны 9 сарын 29-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Хоёр. Захиалагч талын үүрэг

- 2.1. Захиалагч тал нь хөгжмийн сэлбэг хэрэгсэл дагалдах хэрэгсэл худалдан авахаар тохиролцов. Тус байгууллагад шаардлагатай байгаа хөгжмийн зэмсэг болон бусад бүтээгдэхүүний жагсаалтыг нэхэмжлэхээр хавсаргав. Гэрээнд нийт үнийг дүнг бичиж баталгаажуулна.
- 2.2. Захиалагч тал бүтээгдэхүүнээ хүлээн авахдаа тоо, сав баглаа боодлыг шалгаж, орлого, зарлагын баримтыг үйлдэж гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулан авах
- 2.3. Гүйцэтгэгч талд хөгжмийн зэмсгүүдийн төлбөрийг гэрээгээр тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн дагуу төлөх

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 3.1. Бид өөрсдийн үйлдвэрлэсэн хөгжмийн зэмсгүүдэд үйлдвэрлэлээс шалтгаалах чанарт 100 хувийн баталгаа өгнө.
- 3.2. Гүйцэтгэгч тал нь бүтээгдэхүүнээ тохирсон хугацаанд тоо ширхэгийн дагуу захиалагч талд хүлээлгэн өгнө.
- 3.3. Бүтээгдэхүүний сав баглаа боодлыг гүйцэтгэгч тал хариуцна.
- 3.4. Захиалсан барааг 2025 оны 10 сарын 10 дотор хүлээлгэн өгнө.
- 3.5. Захиалагч талд гэрээний биелэлтийн талаарх мэдээллийг үнэн зөв өгөх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Гэрээний хугацаа

- 4.1. Энэхүү гэрээ нь 2025 оны 9-р сарын 29 наас, 10-р сарын 10-ныг дуустал хүчинтэй байна.
- 4.2. Гэрээний хугацаанд аль нэг тал цуцлах санал тавьсан тохиолдолд гэрээг дуусгавар болгоно.
- 4.3. Гэрээ нь талуудын харилцан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

Тав. Баталгаат хугацаа

- 5.1. Баталгаат засварын хугацаа нь барааны нэр төрлөөс хамаарч худалдан авсан өдрөөс хойш 6 сар хүртэл хүчинтэй байна.
- 5.2. Баталгаат засвар нь барааны дагалдах хэрэгсэлд хамаарахгүй болно.

Соёмто
Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:

Т.С. Г. Байгалжав
Гүйцэтгэгчийг төлөөлж

- 5.3. Баталгаат хугацаанд гадны нөлөөлөлөөс болсон эвдрэл гэмтэлд баталгаа үйлчлэхгүй болно.
- 5.4. Баталгаат хугацаанд илэрсэн үйлдвэрлэлээс шалтгаалах гэмтлийг бид үнэгүй засварлана. Гэмтэлтэй барааг 7-14 хоногт багтаан засварлаж өгнө. Засварлах боломжгүй тохиолдолд ижил нэрийн бараагаар сольж өгнө.
- 5.5. Бид танд мэргэжлийн үүднээс үнэгүй зөвөлгөө өгөх ба та 75752233 дугаараас лавлаж асууж болно.
- 5.6. Бүтээгдэхүүнд өгсөн баталгааны хуудасыг үндэслэн баталгааны хугацааг тооцно.

Зургаа. Санхүүжилт

- 6.1. Гүйцэтгэгч тал захиалагын дагуу барааны төлбөрийг нэхэмжилнэ.
- 6.2. Хөгжмийн зэмсгүүдийг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тухай 2 тал акт үйлдэнэ.
- 6.3. Гэрээний нийт үнэ 4721600 (Дөрвөн сая долоон зуун даван нэгэн мянган төгрөг болно төгрөг бөгөөд 2025 оны 10-р сарын 10-ны дотор төлнө. Зургаан зуун)
- 6.4. Төлбөрөө Голомт банк дахь 2800001055 тоот дансанд шилжүүлэх буюу бэлнээр тушаана.
- 6.5. Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө хийгээгүй тохиолдолд хоног тутам 0.2 хувийн алданги тооцно.

Долоо. Бусад

- 7.1. Энэхүү гэрээ болон нэмэлт өөрчлөлтүүд нь зөвхөн бичгээр үйлдэгдэн талууд баталгаажуулан гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2. Гэрээтэй холбоотой асуудлаар талууд албан бичгээр буюу электрон шуудан болон факсаар харилцана.
- 7.3. Гэрээний явцад өөрчлөлт оруулах шаардлага гарвал хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.4. Хэрвээ талуудын хооронд гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба маргаан шийдвэрлэж чадахгүйд хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.



ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Бүтээгдэхүүн төлбөр
Утас: 99676233

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ЭГШИГЛЭН МАНГАЙ" ХХК-ны худалдааны зөвлөх *Отмогзор*
 Утас: 11-328419, 11-312732
 Харилцагч банк: Голомт банк

Дансны дугаар/IBAN: MN52001500/
 2800001055
 Регистрийн дугаар: 2741261

Отмогзор
 Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:

Отмогзор
 Гүйцэтгэгчийг төлөөлж